

АГУУЛГА

Нэгтгэл	3
Өмнөх үг	4
Талархал	5
Хүснэгт	6
График ба Зураг	7
Товчилсон үгийн тайлбар	10
Бүлэг нэг	11
1.1 Оршил	11
1.2 Судалгааны зохион байгуулалт ба арга зүй	11
Бүлэг хоёр: Зах зээлийн судалгаанд хамрагдсан аймаг, сумдын нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал	14
2.1. Баянхонгор аймаг	14
2.1.1 Газар зүй	14
2.1.2 Хүн ам	15
2.1.3 Хөдөө аж ахуй	16
2.1.4 Аймаг, сумдыг хөгжүүлэх бодлого	18
2.1.5 Судалгаанд хамрагдсан сумд	19
2.2 Өвөрхангай аймаг	22
2.2.1 Газар зүй	22
2.2.2 Хүн ам	23
2.2.3 Хөдөө аж ахуй	23
2.2.4 Аймаг, сумдыг хөгжүүлэх бодлого	25
2.2.5 Судалгаанд хамрагдсан сумд	26
2.3 Сэлэнгэ аймаг	31
2.3.1 Газар зүй	31
2.3.2 Хүн ам	32
2.3.3 Хөдөө аж ахуй	32
2.3.4 Аймаг, сумдыг хөгжүүлэх бодлого	34
2.3.5 Судалгаанд хамрагдсан сумд	34
Бүлэг гурав: Уламжлалт бус ба сайжруулсан бүтээгдэхүүний зах зээлийн өнөөгийн байдал	41
3.1. Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, зах зээлийн өнөөгийн байдал	41
3.1.1 Монгол улсын мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, зах зээл	41
3.1.2 Баянхонгор аймаг	42
3.1.3. Өвөрхангай аймаг	47
3.1.4. Сэлэнгэ аймаг	50
3.2. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, зах зээлийн өнөөгийн байдал	55
3.2.1. Монгол улсын сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл	55
3.2.2. Баянхонгор аймаг	58
3.2.3. Өвөрхангай аймаг	64

3.2.4.	Сэлэнгэ аймаг	68
3.3.	Цагаан идээний зах зээлийн өнөөгийн байдал	71
3.3.1	Баянхонгор аймаг	72
3.3.2	Өвөрхангай аймаг	74
3.3.3	Сэлэнгэ аймаг	77
3.4.	Төмс, хүнсний ногооны зах зээлийн өнөөгийн байдал	78
3.4.1	Баянхонгор аймаг	78
3.4.2	Өвөрхангай аймаг	79
3.4.3	Сэлэнгэ аймаг	80
3.5.	Жимс, жимсгэний зах зээл	81
3.5.1	Баянхонгор аймаг	81
3.5.2	Өвөрхангай аймаг	81
3.5.3	Сэлэнгэ аймаг	82
3.6.	Байгалийн гаралтай хүнсний ногоо ба эмийн ургамал	85
3.6.1	Баянхонгор аймаг	85
3.6.2	Өвөрхангай аймаг	86
3.6.3	Сэлэнгэ аймаг	86
3.7.	Даршилсан болон нөөжилсэн хүнсний ногоо	86
3.7.1	Баянхонгор аймаг	86
3.7.2	Өвөрхангай аймаг	86
3.7.3	Сэлэнгэ аймаг	87
3.8.	Эсгий урлалын зах зээл	87
3.8.1	Баянхонгор аймаг	88
3.8.2	Өвөрхангай аймаг	88
3.8.3	Сэлэнгэ аймаг	88
3.9.	Сур болон модон эдлэл	89

Бүлэг дөрөв: Уламжлалт бус ба сайжруулсан бүтээгдэхүүнүүдийн талаарх дүгнэлт, зөвлөмжүүд **90**

Хавсралт		101
Хавсралт 1	Асуулгын үндсэн агуулга	101
Хавсралт 2	Сургалтанд оролцогчдын нэрс	103
Хавсралт 3	Сургалтанд ашигласан материал	109
Хавсралт 4	Судалгааны ажлын хүрээнд явуулсан бүлгийн хэлэлцүүлэг	113
Хавсралт 5	Уламжлалт бус бүтээгдэхүүний зах зээлийн судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагын жагсаалт	131
Хавсралт 6	Уламжлалт бус болон сайжруулсан бүтээгдэхүүний талаарх зөвлөмжүүд	133

НЭГТГЭЛ

Судалгааны нэр:	Монголын хөдөөд үйлдвэрлэгдэж буй уламжлалт бус бүтээгдэхүүний зах зээлийн судалгаа
Судалгааны зорилго:	Монгол орны хөдөө, орон нутагт үйлдвэрлэж болох уламжлалт бус, шинэлэг бүтээгдэхүүний зах зээлийн боломжийн судалгаа явуулах замаар БТМТ-ийн үйл ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлэх
Захиалагч:	НҮБХХ Бэлчээрийн тогтвортой менежмент төсөл (БТМТ)
Гүйцэтгэгч:	Монголын хоршооллын сургалт, мэдээллийн Төв (МХСМТ)
Холбоо барих:	Утас: 461302, 450920, Факс:450920 И-мэйл: mccti@mbox.mn

СУДАЛГААНЫ БАГИЙН ТАНИЛЦУУЛГА

Санжжавын БАЙГАЛМАА	Судалгааны багийн удирдагч, Монголын хоршооллын сургалт, мэдээллийн төвийн Гүйцэтгэх захирал
Совдын ХАНДСҮРЭН	Судалгааны багийн гишүүн, Эдийн засагч, Эдийн засгийн ухааны доктор (Ph. D.), ХААИС-ийн ЭЗБС-ийн багш
Готовын МАНАЛЖАВ	Судалгааны багийн гишүүн, Худалдааны зохион байгуулалт, бүтээгдэхүүн судлал MBA, МХСМТ-ийн сургагч багш, зөвлөх
Авирмэдийн МӨНХЖАРГАЛ	Судалгааны багийн гишүүн, Малын их эмч, МХСМТ-ийн сургагч багш, зөвлөх
Адъяадоржийн БОЛДСҮХ	Судалгааны багийн гишүүн, Бизнесийн удирдлагын менежер, МХСМТ-ийн зөвлөх

ТӨСЛИЙН БАГИЙН ТАНИЛЦУУЛГА

Н.Батжаргал	БТМТ-ийн үндэсний менежер
Жан Эвэрэт	БТМТ-ийн зөвлөх
Эжей Юпадхаяа	БТМТ-ийн мэргэжилтэн, НҮБХХ-ийн сайн дурын ажилтан

ӨМНӨХ ҮГ

Монгол улсын ХХААЯ, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс хамтран хэрэгжүүлж буй Бэлчээрийн тогтвортой менежмент төслийн хүрээнд “Хөдөөд үйлдвэрлэгдэж буй уламжлалт бус бүтээгдэхүүний зах зээл”-ийн судалгааг 2005 оны 1-3 сард хийж гүйцэтгэсэн юм.

Энэхүү судалгааны зорилго нь Монгол орны хөдөө орон нутагт үйлдвэрлэж болох уламжлалт бус, сайжруулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, зах зээлийн байдлыг судлан тодорхойлох замаар БТМТ-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх явдал юм. Энэхүү судалгааны үр дүн нь эхний ээлжинд БТМТ-д хамрагдсан малчдын орлогыг нэмэгдүүлэх эх үүсвэрийн боломжийг нэмэгдүүлэхэд удирдамж болох ба хамгийн гол нь шинэ бизнес санаачлагыг хэрэгжүүлэхэд малчдад туслана гэж үзэж байна.

Байгаль, цаг уурын нөлөөллөөс малын тоо толгой сүүлийн жилүүдэд цөөрч малчин өрхийн орлого буурсан өнөө үед БТМТ-ийнхөн малчдын орлогыг нэмэгдүүлэхийг 2 дахь зорилт болгон дэвшүүлсэн нь тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чухал алхам болно. Энэхүү судалгааны хүрээнд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх, уламжлалт бус, сайжруулсан бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх боломжийг чухалчлан анхаарсан. Мөн судалгааны баг судалгааныхаа үр дүнд түшиглэн зөвлөмжүүдийг боловсруулан гаргалаа.

Уламжлалт бус бүтээгдэхүүний зах зээлийн судалгааны ажлыг Монголын хоршооллын сургалт, мэдээллийн төвийн зөвлөх багш нар хийж гүйцэтгэсэн бөгөөд судалгааны дүнг БТМТ-өөс зохион байгуулсан дугуй ширээний уулзалтаар хэлэлцүүлж, гарсан саналуудыг энэхүү тайланд тусгасан болно.

“Хөдөөд үйлдвэрлэгдэж буй уламжлалт бус бүтээгдэхүүний зах зээлийн судалгаа”-ны тайланг танд толилуулж байна.

Хүнс, хөдөө аж ахуйн яамны
Гадаад харилцааны хэлтсийн дарга,
Төслийн үндэсний захирал

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн
Бэлчээрийн тогтвортой менежмент
төслийн үндэсний менежер

(И. ХАНЫМХАН)

(Н. БАТЖАРГАЛ)

ТАЛАРХАЛ

Монгол улсын ХХААЯ, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс хамтран хэрэгжүүлж байгаа Бэлчээрийн тогтвортой менежмент төслийн хүрээнд хийсэн “Уламжлалт бус бүтээгдэхүүний зах зээлийн судалгаа”-ны ажлыг гүйцэтгэн боловсруулж, үр дүнг танилцуулахад таатай байна.

Судалгааны зорилго нь хөдөө орон нутагт үйлдвэрлэж болох уламжлалт бус, шинэлэг бүтээгдэхүүний зах зээлийн боломжийн судалгааг явуулж БТМТ-ийн цаашдын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршиж байв.

Энэхүү судалгааг Улаанбаатар хот, Дархан сум болон БТМТөсөл хэрэгжиж буй Баянхонгор, Өвөрхангай, Сэлэнгэ аймгуудын 11 сумын малчин, бизнес эрхлэгч, бөөний болон жижиглэн худалдаачин, экспорт/импорт эрхлэгч иргэд зэрэг 528 хүнээс асуулгаар ярилцлага авах болон бүлгийн хэлэлцүүлгийн оролцооны аргыг ашиглан хийлээ. Судалгаа нь мэдээлэл цуглуулах; зах зээлийн судалгаа хийх ур чадварыг малчдад сургах; үр дүнг үнэлэх; зөвлөмж боловсруулах гэсэн үндсэн хэсгээс бүрдсэн.

Уламжлалт бус бүтээгдэхүүний тухай ойлголт нь орон нутагт шинэлэг зүйл байсан тул зах зээлийн судалгаа хийхэд цаг хугацаа нилээд шаардагдсан ч судалгааны багийн гишүүд их хичээл чармайлттай ажилласан.

Судалгааны үр дүнг тоймлон дүгнэвэл: **1) малчдын зах зээлийн тухай ойлголтыг сайжруулахын хамт тэдгээрийн үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд сурталчлан таниулах ажлыг идэвхжүүлэх; 2) хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг эцсийн хэрэглэгчид хүргэх зах зээлийн оновчтой бүтцийг бий болгоход дэмжлэг үзүүлэх; 3) аймаг, сум тус бүрд тохирсон уламжлалт бус бүтээгдэхүүнийг тодорхойлж хөгжүүлэх** нь зүйтэй гэсэн дүгнэлт гаргав.

Судалгааны багийн өмнөөс Баянхонгор, Өвөрхангай, Сэлэнгэ аймгийн сумдын малчдын бүлгийн ахлагч, гишүүд, БТМТ-ийн орон нутгийн ажилтнууд, хоршооны сургагч багш нарын дэмжлэг туслалцаа их ач холбогдолтой байсныг тэмдэглэн талархал илэрхийлж байна.

Мөн төслийн Үндэсний менежер Н.Батжаргал, зөвлөх Жан Эвэрэт, НҮБХХ-ийн сайн дурын ажилтан Эжей Юпадхаяа нар үнэтэй зөвлөгөө өгч судалгааны ажлыг үр дүнтэй болгоход дэмжлэг үзүүлж байсанд талархал илэрхийлж байна.

Амьдралыг хэрхэн сайжруулах, сум орноо хөгжүүлэх талаар санаа бодлоо харамгүй хуваалцсан малчдадаа аз жаргал, ажлын амжилт хүсье. Энэхүү судалгааны ажил тэдгээрийн амьдралд бага ч гэсэн нэмэр болно гэдэгт бид найдаж байна.

С.Байгалмаа

Монголын хоршооллын сургалт, мэдээллийн төвийн

Гүйцэтгэх захирал

ХҮСНЭГТ

- Хүснэгт 1.1 Судалгааны объектууд
- Хүснэгт 2.1 ӨХ аймгийн аж үйлдвэрийн гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл
- Хүснэгт 2.2 ӨХ аймгийн Арвайхээр сумын малын тоо
- Хүснэгт 3.1 Махны нөөц ба таваарын махны хэрэгцээ
- Хүснэгт 3.2 БХ аймгийн малын үнэ
- Хүснэгт 3.3 ӨХ аймгийнхан махаа хаанаас худалдан авдаг вэ
- Хүснэгт 3.4 Улсын хэмжээний сүүний нөөц
- Хүснэгт 3.5 Монгол улсын хүн амын сүү, цөцгийн тосны хэрэгцээ
- Хүснэгт 3.6 Импортын сүү, цагаан идээ /2000-2003/
- Хүснэгт 3.7 БХ аймгийн ариутгасан ба шингэн сүүны харьцуулалт
- Хүснэгт 3.8 Цагаан идээний үйлдвэрлэлийн юуг өөрчлөн сайжруулах вэ
- Хүснэгт 3.9 Малчдын бүлгийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн ямар шаардлага хангасан байх вэ
- Хүснэгт 3.10 Мандал сумын төмс, хүнсний ногооны хэрэгцээ
- Хүснэгт 3.11 Сэлэнгэ аймгийн судалгаанд хамрагдсан хүн амын жимс, жимсгэний эрэлт хэрэгцээ

ГРАФИК БА ЗУРАГ

Зураг 1.1	Судалгаа явуулсан дэс дараалал
Зураг 2.1	Судалгаанд хамрагдсан аймаг, сумд
График 2.1	БХ аймгийн газрын нэгдмэл сан
График 2.2	БХ аймгийн хүн амын тоо
График 2.3	БХ аймгийн малын тооны өсөлт
График 2.4	БХ аймгийн 2000-2004 онд тариалсан талбай
График 2.5	БХ аймгийн 2001-2003 оны аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт
График 2.6	БХ аймгийн Богд сумын малын тоо
График 2.7	ӨХ аймгийн малын тоо
График 2.8	ӨХ аймгийн тариалсан талбай ба хураан авсан ургац
График 2.9	ӨХ аймгийн Төгрөг сумын малын тоо
График 2.10	Өвөрхангай аймгийн Хужирт сумын малын тоо
График 2.11	СЭ аймгийн ХАА-н эдэлбэр газрын бүтэц
График 2.12	СЭ аймгийн усалгаатай талбай
График 2.13	СЭ аймгийн Жавхлант сумын малын тоо
График 2.14	СЭ аймгийн Мандал сумын цэвэр, эрлийз малын тоо
График 2.15	СЭ аймгийн Мандал сумын хүнсний ногооны талбайн бүтэц
График 2.16	СЭ аймгийн Баянгол сумын цэвэр, эрлийз малын тоо
График 2.17	СЭ аймгийн Баянгол сумын газар тариалангийн талбайн атаршсан байдал
Зураг 3.1	Махны экспортын суваг
График 3.1	Та махаа хаанаас худалдан авдаг вэ
График 3.2	Таны худалдан авсан махны юу нь таны хэрэгцээг хангаж чадахгүй байна вэ
График 3.3	БХ аймаг дах хонины махны үнэ
График 3.4	Цаашдын мах бэлтгэлд Баянхонгор аймгийнхан юуг өөрчлөн сайжруулах хэрэгтэй вэ
График 3.5	БХ аймгийн хэрэглэгчид ямар шаардлага хангасан мах худалдан авах вэ
График 3.6	БХ аймгийн хэрэглэгчид цаашдаа хаанаас мах худалдан авах вэ

График 3.7	СЭ аймгийн мах үйлдвэрлэлийн бүтэц
График 3.8	СЭ аймгийн нэг өрх жилдээ хэдэн төгрөгийг мах худалдан авахад зарцуулдаг вэ
График 3.9	СЭ аймгийн хэрэглэгчид ямар төрлийн мах, махан бүтээгдэхүүн хэрэглэдэг вэ
График 3.10	СЭ аймгийн гахайн мах ба өндөг үйлдвэрлэл
График 3.11	СЭ аймгийнхан жилдээ гахайн утсан маханд хэдэн төгрөг зарцуулдаг вэ
График 3.12	2002-2004 оны өндөгний үнэ
График 3.13	Тахианы өндгийг хаанаас худалдан авдаг вэ?
График 3.14	Импортоор авсан сүү, сүүн бүтээгдэхүүн
График 3.15	БХ аймгийн нэг өрх жилдээ хэдэн төгрөгийг зөвхөн сүү худалдан авахад зарцуулдаг вэ
График 3.16	БХ аймгийн сүүний нийлүүлэлтийн сувгууд
График 3.17	БХ аймгийн хэрэглэгчид сүү худалдан авахдаа юуг голлон анхаардаг вэ
График 3.18	БХ аймагт үйлдвэрлэсэн сүү яагаад бидний шаарлагыг хангахгүй байна вэ
График 3.19	БХ аймагт 1 литр шингэн сүүний үнэ
График 3.20	БХ аймагт цаашдаа сүүний юуг нь сайжруулах хэрэгтэй вэ
График 3.21	Сайжруулсан болон уламжлалт бус сүүн бүтээгдэхүүн ямар шаардлага хангасан байх ёстой вэ
График 3.22	БХ аймагт хэрэглэгчид цаашдаа сүү борлуулалтын ямар сувгийг сонгох шаардлагатай вэ
График 3.23	ӨХ аймагт 1 литр шингэн сүүний үнэ
График 3.24	ӨХ аймгийн хэрэглэгчид ямар сүү хүнсэндээ илүү их хэрэглэдэг вэ
График 3.25	ӨХ аймгийн Арвайхээр сумынхан хаанаас сүүн бүтээгдэхүүнээ худалдан авдаг вэ?
График 3.26	СЭ аймаг, Улаанбаатар хотын сүүний үнийн харьцуулалт
График 3.27	СЭ аймгийнхан сүүгээ хаанаас худалдан авдаг вэ
График 3.28	СЭ аймгийнхан цаашдаа сүү үйлдвэрлэлд юуг нь өөрчлөх хэрэгтэй вэ
График 3.29	СЭ аймгийн хэрэглэгчид ямар шаардлага хангасан сүүн бүтээгдэхүүн худалдан авдаг вэ
График 3.30	БХ аймгийнхан цаашдаа цагаан идээний юуг нь сайжруулах хэрэгтэй вэ

График 3.31	БХ аймагт борлуулалтын ямар суваг байвал зохимжтой вэ
График 3.32	БХ аймгийн хангайн сумдын цагаан идээний үзэсгэлэн худалдаанд оролцогсдоос авсан судалгаа
График 3.33	ӨХ аймгийн нэг өрх цагаан идээнд жилдээ хэдэн төгрөг зарцуулдаг вэ
График 3.34	СЭ аймгийн цөцгийн тосны үнэ
График 3.35	ӨХ аймгийнхан тарьсан ногоогоо хэдийд худалддаг вэ
График 3.36	СЭ аймгийн дотоодын жимсний чанамал хэр зэрэг чанартай вэ
График 3.37	СЭ аймгийн нэг өрх жимсний чанамалд хэр зэрэг мөнгө зарцуулдаг вэ
График 3.38	СЭ аймгийн хэрэглэгчид хаанаас жимс, жимсний чанамалаа авдаг вэ
График 3.39	Сэлэнгэ аймгийн нэг өрхийн хэмжээнд үйлдвэрлэгдэж буй жимсний чанамлын юуг нь өөрчлөн сайжруулах вэ
График 3.40	СЭ аймгийн хэрэглэгчид ямар шаардлага хангасан бүтээгдэхүүн /жимсний чанамал/ худалдан авах вэ
Зураг 4.1	Судалгаанд хамрагдсан аймгуудад үйлдвэрлэж болох уламжлалт бус бүтээгдэхүүн
Зураг 4.2	Судалгаанд хамрагдсан аймгуудад үйлдвэрлэж болох сайжруулсан бүтээгдэхүүн
Зураг 4.3	Баянхонгор аймгийн мах борлуулалтын суваг
Зураг 4.4	Мандал сумын сүүний борлуулалтын суваг
Зураг 4.5	Сүүний борлуулалтыг боловсронгуй болгох загвар бүтэц
Зураг 4.6	Олон төрөлт хоршооны бүтэц, үйл ажиллагааны уялдаа

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ХХААЯ	Хүнс, Хөдөө Аж Ахуйн Яам
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
БТМТ	Бэлчээрийн Тогтвортой Менежмент төсөл
МХСМТ	Монголын Хоршооллын Сургалт, Мэдээллийн Төв
ХААИС	Хөдөө Аж Ахуйн Их Сургууль
ЗД	Засаг Дарга
БО	Байгаль Орчин
ЭЗБС	Эдийн Засгийн Бизнесийн Сургууль
ББСБ	Банк Бус Санхүүгийн Байгууллага
ХХК	Хязгаарлагдмал Хувьцаат Компани
ХК	Хувьцаат Компани
ТББ	Төрийн Бус Байгууллага
УБ	Улаанбаатар
ӨХ	Өвөрхангай
БХ	Баянхонгор
СЭ	Сэлэнгэ
ХАА	Хөдөө Аж Ахуй
ОНА	Орон Нутгийн Ажилтан
ОНСур	Орон Нутгийн Сургалт

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, АРГАЧЛАЛ

1.1 Оршил

Бэлчээрийн тогтвортой менежмент төслөөс 2004 оны 12-р сард зарласан “Уламжлалт бус бүтээгдэхүүний зах зээл” мэргэжлийн судалгаа хийх тендерт шалгарч хамтран ажиллах гэрээг 2004 оны 12 дугаар сарын 29-нд байгуулсанаар бидний судалгааны ажил эхэлсэн.

1.2 Судалгааны зохион байгуулалт ба арга зүй

Судалгааны ажил нь дараах үндсэн 6 үе шатаас бүрдсэн:


- 1 Холбогдох байгууллагуудаас урьд өмнө уламжлалт бус бүтээгдэхүүний чиглэлээр хийгдсэн ажил, материалуудыг судалж, уламжлалт бус бүтээгдэхүүний жагсаалтыг гаргах;
- 2 Судалгааны анкет, асуулгын маягыг боловсруулах;
- 3 Мэдээлэл цуглуулах, үүнд:
 - 3.1 Бүлгийн хэлэлцүүлэг зохион байгуулах;
 - 3.2 Маягтын дагуу асуулга авах;
- 4 Зах зээлийн судалгаа хийх чадварыг малчдад эзэмшүүлэх сургалт зохион байгуулах;
- 5 Мэдээлэл боловсруулах;
- 6 Тайлан бичих.

Судалгааны 1 дэхь үе шатанд Монгол улсад хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр болон хөдөөгийн уламжлалт болон уламжлалт бус бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулж буй Меркурий, Нарантуул, Хүчит шонхор захуудад худалдаа эрхлэгч, борлуулагчид зэрэг 19 хүнтэй уулзаж уламжлалт бус, шинэлэг 15 төрлийн 102 бүтээгдэхүүний жагсаалтыг гаргасан.

Судалгааны 2 дахь шатанд мэдээлэл цуглуулах зорилгоор судалгаанд хамрагдах бүлгүүд, судалгааг авах асуулгын маягыг боловсруулсан.

Судалгааны 3 дахь шатанд судлаачдын багийг Улаанбаатар хот, БТМТөслийн аймгийн төв, сумдад ажиллуулж уламжлалт бус бүтээгдэхүүний зах зээлийн хэрэгцээ, орон нутагт үйлдвэрлэх боломж, нөхцөл зэргийн тухай мэдээллийг өгөгдсөн удирдамжийн дагуу цуглуулсан.

Судалгааг дараах дарааллаар явуулсан:



Зураг 1.1

Орон нутагт уламжлалт бус бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломж, нөхцлийг тодорхойлохын тулд бүлгийн болон бүлгийн бус малчид, сумын төвийн оршин суугчид, хөдөө аж ахуйн мэргэжилтэн нарыг оролцуулсан бүлгийн хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Уламжлалт бус бүтээгдэхүүний зах зээлийн багтаамж, хэрэглээг тодорхойлохын тулд аймгийн төв, сумдаас эцсийн хэрэглэгч, бөөний болон жижиглэн худалдаа эрхлэгч, үйлчилгээний салбарын төлөөлөгчид, түүхий эд боловсруулагчидаас өгөгдсөн маягтын дагуу асуулга авч мэдээлэл цуглууллаа.

Мөн сум, багийн удирдах ажилтнуудаас судалгаа авсан. Улаанбаатар хотын зах зээлийн судалгааг явуулсан. Судалгаанд Улаанбаатар хот болон 3 аймгийн 528 хүнтэй уулзаж мэдээлэл цуглуулсан болно.

Хүснэгт 1.1

Д/Д	Судалгаанд хамрагсад	Баян хонгор	Өвөр хангай	Сэлэнгэ	Улаан баатар	Нийт
1	Эцсийн хэрэглэгч	90	93	90	30	303
2	Үйлчилгээний байгууллага ресторан, кафе, цайны газар, жуулчны бааз, зочид буудал, цэцэрлэг гэх мэт	11	10	10	5	36
3	Бөөний худалдаа эрхлэгч	5	6	6	5	22
4	Түүхий эд боловсруулагч	3	5	5	5	18
5	Жижиглэн худалдаа эрхлэгч	25	27	18	10	80
6	Экспорт, импорт эрхлэгч	3	4	2	5	14
7	Аймаг, сумдын удирдлага, банкны мэргэжилтэн	18	21	16		55
	Нийт	155	166	147	60	528

Судалгаанд Үндэсний статистикийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Үйлдвэр, худалдааны яам, Гаалийн ерөнхий газрын холбогдох газар, хэлтсүүдийн мэдээ, мэдээлэл, Хөдөө аж ахуйн их сургуулийн Эдийн засаг, бизнесийн сургууль, “Цаг тоо” ХК-ний гүйцэтгэсэн судалгааны материалуудыг ашигласан болно.

Судалгааны 4 дэхь шатанд малчны бүлгийн болон бүлгийн бус малчдад зах зээлийн судалгаа хийх, бүтээгдэхүүний SWOT шинжилгээг хийх, малчны бүлэг ба хоршооны ялгаа сэдвээр 8 цагийн сургалтыг 9 суманд зохион байгуулсан.

Судалгааны 5 дахь шатанд судалгаанд авагдсан мэдээллүүдийг нийтлэг шинжээр бүлэглэн аймаг, сумын онцлогийг гаргаж эдгээр бүтээгдэхүүнийг цаашид хөгжүүлэх, сум орон нутгийн болон үндэсний зах зээлийн хэрэгцээ, багтаамжийг тодорхойлох ажлыг хийсэн болно.

Судалгааны 6 дахь үе шатанд судалгааны багийн гишүүд тайлангийн бүтцийг 4 удаа бүрэлдэхүүнээрээ хэлэлцэн эцсийн хувилбарыг боловсруулсан юм. Эцсийн тайлангийн өмнө БТМТөсөлд 3 удаа явцын тайланг хүлээлгэн өгсөн.

Судалгааны явцад төслийн багийн гишүүд, БТМТөслийн менежер Н.Батжаргал, зөвлөх Жан, Эжей нартай 3 удаа уулзаж нэг удаа дугуй ширээний уулзалт ярилцлага зохион байгуулсан ба эдгээр ярилцлагаас гарсан санал, дүгнэлтүүдийг асуулгын маягт боловсруулах, эцсийн тайлан бичихдээ харгалзан үзсэн болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГААНД ХАМРАГДСАН АЙМАГ, СУМДЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Судалгаанд Бэлчээрийн тогтвортой менежмент төсөл хэрэгжиж буй Баянхонгор аймгийн Жинст, Богд, Эрдэнэцогт, Баянхонгор сумд, Өвөрхангай аймгийн Төгрөг, Хужирт, Сант, Арвайхээр сумд, Сэлэнгэ аймгийн Мандал, Жавхланта, Баянгол сумд болон Дархан-Уул аймгийн Дархан сум, Улаанбаатар хот хамрагдсан болно.



Зураг 2.1

2.1. Баянхонгор аймаг

Баянхонгор аймаг нь нийтдээ 11588,6 мян га газар нутагтай.

2.1.1. Газар нутаг

Баянхонгор аймаг нь Улаанбаатараас 630 км-ийн зайтай байрладаг, 20 сум 100 багтай, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалаар Хангайн бүсэд багтдаг.

Баянхонгор аймгийн газрын нэгдмэл сан




График 2.1

Нийт газар нутгийн 77,8 хувь нь ХАА-н эдэлбэр газар, Хөдөө аж ахуйн эдэлбэр газрын 99.85 хувь нь бэлчээрийн талбай, 0.09 хувь нь хадлангийн талбай, 0.013 хувь буюу 819.4 га тариалангийн талбай байна. Тариалангийн талбайн 81.4 хувь буюу 667.3 га-д төмс, хүнсний ногоо тариалж байна. Харин судалгааны объект болох Жинст сум 3.9 га, Богд сум 2 га, Эрдэнэцогт сум 54 га, Баянхонгор сум 24 га тариалангийн талбайтай. Газар тариаланд ашиглах боломжтой нийт талбайн 50.9 хувь буюу 851.5 га газар нь атаржсан байна.

2.1.2. Хүн, амын тоо




График 2.2

Аймгийн нийт хүн ам 84304 болж, өмнөх оноос 0,4 хувиар өссөн байна. Нийт хүн амын 35,8 хувийг 16 хүртлэх насны хүүхэд, 58,4 хувийг хөдөлмөрийн насныхан, 5,8 хувийг өндөр настан эзэлж байна. Хүн амын 51 хувийг эмэгтэйчүүд, 49 хувийг эрэгтэйчүүд эзэлдэг. Хөдөлмөрийн насны хүн амын 70,2 хувь буюу 34447 хүн хөдөлмөр эрхэлж байна. Нийт ажиллагсдын 68,9 хувь хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байна. Ажил эрхлээгүй 8598 хүн байгаагийн 2733 нь албан ёсны ажилгүйчүүд буюу хөдөлмөр зохицуулалтын албанд

бүртгэлтэй байна. Ажилгүйдлийн түвшин нь 7,8 хувьтай байна. Баянхонгор аймаг нь хүний хөгжлийн түвшингээр доод бүлэгт хамрагддаг байна.¹

Нийт хүн амын 30 хувь нь аймгийн төвд, 14 хувь нь сумын төвд, 56 хувь нь хөдөө амьдарч байна. Нийтдээ 21357 өрхтэй ба нэг өрхөд дундажаар 3,9 хүн оногдож байгаа нь улсын дундажаас 0,3 хүнээр цөөн байна. 2004 онд малчин өрхийн тоо 1048-аар нэмэгджээ.

Нийт малчин өрхийн 41,3 хувь нь 100 хүртэл, 17,3 хувь нь 101-200 хүртэл, 40,7 хувь нь 201-500 хүртэл, 0,6 хувь нь 501-1000 хүртэл, 0,1 хувь нь 1000-аас дээш толгой малтай байна.

2.1.3. Хөдөө аж ахуй

Малын тоо, бүтэц




График 2.3

Баянхонгор аймаг нь нийтдээ 1,323,646 толгой малтай ба үүний 32.0 хувь нь аймгийн төвөөс 100 хүртэл км-т, 28.2 хувь нь 100-200 км-т, 39,8 хувь нь 200 км-с цааш байрлаж байна. Малын тоо 2004 онд урд оноос 20,4 хувиар өссөн нь цаг агаар тааламжтай байсантай холбоотой юм.

Нийт малын 57,8 хувь буюу 764160 толгой ямаа, 28,8 хувь буюу 381583 толгой хонь, 6,8 хувь буюу 90642 толгой үхэр, 5 хувь буюу 66238 толгой адуу, 1,6 хувь буюу 21023 толгой тэмээ байна. Говийн сумдын малчин өрхийн мал аж ахуйн орлогын 70-80 орчим хувийг ямааны аж ахуйгаас олдог байна.

Газар тариалан ба тэжээл бэлтгэл

Баянхонгор аймаг нь байгалийн бүслүүрийн хангай ба говийн гэсэн 2 хэсэгт хуваагддаг. Газар тариалангийн салбарыг хангайн сумын иргэд бага зэрэг эрхэлж байсан.

¹ Монгол улсын эдийн засаг нийгмийг 2005 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, 2006-2008 оны хөгжлийн хандлага, 2004 он

Харин сүүлийн 2-3 жилд ган, зуд болсон учраас хүмүүс газар тариалан эрхлэхийг сонирхох болжээ. 2004 оны байдлаар Баянбулаг, Гурванбулаг сумдаас бусад сумдын иргэд төмс, хүнсний ногоо тариалсан байна.

2000-2004 онд тариалсан талбай /га-аар/




график 2.4

2002 оноос эхлэн иргэд төмс, хүнсний ногоог нилээд тариалж эхэлсэн боловч 2003 онд нэг га-аас төмс 4,1 тн, хүнсний ногоо 28,3 цн-ийг хураан авсан нь улсын дундажаас даруй 48,1-72,1 хувиар бага ургац авсан байна. Үүний гол шалтгаан нь:

1. 2002-2003 онд нийт нутгийг хамарсан ган болсон
2. Нутгийн иргэд газар тариалан эрхэлж байсан уламжлал бага
3. Хөрсний бүтэц нь газар тариаланд тохиромжтой бус зэрэг хүчин зүйлтэй холбоотой гэж үзэж болно.

2004 онд цаг агаар тааламжтай байсан учраас малын тоо толгой өссөн, өмнөх жилдээ бага ургац авсан гэх мэт шалтгаанаар тариалалт буурсан ба нэг га-аас төмс 6.7 тн, хүнсний ногоо 10.1 тн-ийг хураан авсан байна. Ер нь газар тариалангийн салбар нь Баянхонгор аймгийн хувьд уламжлалт бус салбар гэж үзэж болох юм.

Тус аймаг нь жилдээ дундажаар 3,5 мянган тн байгалийн хадлан, 0,6 мянган тн гар тэжээл бэлтгэдэг ажээ.

Боловсруулах аж үйлдвэр

Баянхонгор аймагт аж үйлдвэр олигтой хөгжөөгүй, 2003 оны байдлаар цахилгаан эрчим хүч, талх нарийн боов, архи ундааны үйлдвэрүүд ажиллаж, жилдээ дундажаар 7,7 тэр бум төгрөгийн бүтээгдэхүүний борлуулалт хийсэн байна.

2001-2003 оны аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт




график 2.5

2003 онд ундааны үйлдвэрлэл 39,5 хувь, талх үйлдвэрлэл 18,9 хувь, нарийн боовны үйлдвэрлэл 41,7 хувь өссөн байхад, цахилгаан эрчим хүч 4,5 хувь, алт олборлолт 25,9 хувь, архи үйлдвэрлэл 66,2 хувиар тус тус буурсан байна. Харин малын өлөн боловсруулах “Хулман” жижиг үйлдвэр, хонины ноос боловсруулах “Хонгорын сор” хоршоо ажиллаж байна.

2.1.4. Аймаг, сумдыг хөгжүүлэх бодлого

Баянхонгор аймаг 2002 оноос Японы улсын Ойта мужтай хамтран жил бүрийн 12 сард “Нэг сум - нэг бүтээгдэхүүн” нэртэй үзэсгэлэнг зохион байгуулж байна. Энэ үзэсгэлэнгээс шалгарсан бүтээгдэхүүнд цом, медаль олгох, үйлдвэрлэгчийг нь Японд урих зэргээр урамшуулжээ. Сүүлийн 2 жилд уг үзэсгэлэн худалдаагаар Хонгорын сор хоршооны эсгий шаахай, Эрдэнэцогт сумын цэцгийн тос, Баянлиг сумын сурагчдын тэмээний ноос, ямааны ноолуураар хийсэн төрөл бүрийн бүтээгдэхүүнүүд шалгарсан байна. Энэ нь бусад үйлдвэрлэгчдэд үлгэр болж бүтээгдэхүүнийхээ чанар, сав баглаа боодол, хийц загварыг сайжруулах өрсөлдөөнийг бий болгож байна. Үзэсгэлэнд оролцож буй бүтээгдэхүүн жилээс жилд өсч, чанаржиж байгаа юм байна. Баянхонгор аймгийн энэ туршлагыг дэлгэрүүлэх зорилгоор Монгол улсын Засгийн газар мөрийн хөтөлбөртөө “Нэг бүтээгдэхүүн-нэг суурин”² хөдөлгөөнийг өрнүүлж чанар сайтай, өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүнийг шинээр буй болгож, дотоод гадаадын зах зээлд гаргахыг дэмжин ажиллаж байна.

² Монгол улсын эдийн засаг нийгмийг 2005 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, 2006-2008 оны хөгжлийн хандлага, 2004 он хуудас 134

Мөн цөөн малтай малчин өрхийн амьжиргааг дээшлүүлэхийн тулд аймаг, сум, орон нутгаас дараахь ажлуудыг хийж байна. Үүнд:

- Гадаад болон дотоодын төсөлд хамруулан малжуулах, тухайлбал 2005 оноос Швейцарийн хөгжил хамтын ажиллагааны агентлагтай хамтран малжуулах ажлыг эхэлж байна,
- Малчдын бүлэг, хоршоог байгуулах санаачлагыг дэмжин зээл олгох,
- Газар тариалан эрхэлж болохуйц сумын иргэдэд газар олгох, үрээр хангах,
- Хонины ноос, хөөвөр, тэмээний ноосыг гар аргаар боловсруулан бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх талаар малчдын болон иргэдийн дунд сургалт зохион байгуулах, тэдний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулах,
- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх таатай нөхцөл бүрдүүлэх,
- Малын үүлдэр, угсааг сайжруулах замаар өндөр ашиг шимт малтай болгох,
- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг сав баглаа боодолтой болгох.

Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх замаар хөдөө дэх ядуурал, ажилгүйдлийг бууруулахаар аймгийн болон сумдын засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагджээ.

2.1.5 Судалгаанд хамрагдсан сумд

А. Баянхонгор сум

Баянхонгор сум нь 8 багтай, 6.4 мянган кв км нутагтай, 27160 хүн амтай, 6671 өрхтэй. Нийт хүн амын 47,5 хувийг эрэгтэйчүүд, 52,5 хувийг эмэгтэйчүүд эзэлдэг. Хүн амын 62.1 хувь нь эдийн засгийн идэвхтэй хүн ам ба ажиллах хүчний 47,6 хувь ажил эрхэлж байгаа, албан ёсны ажилгүйдэл 15,1 хувьтай байна. Нийт өрхийн 48.1 хувь нь ядуу, 30.0 хувь нь нэн ядуу өрх байгаа нь ядуурал, ажилгүйдэл өндөр байгааг харуулж байна. Энэ нь малгүй болсон малчид төв суурин газар бараадаж амьдрах зорилгоор аймгийн төв, Улаанбаатар хот болон бусад хот суурин газар шилждэгтэй холбоотой юм. Зөвхөн 2003 онд 1127 хүн шилжиж ирсэн байхад 424 хүн шилжиж явсан байна.

Сум нийтдээ 66635 толгой малтайн 2913 толгой буюу 4.4 хувийг нь адуу, тэмээ, 9045 толгой буюу 13.6 хувийг үхэр, 17715 толгой буюу 26.6 хувийг хонь, 36962 толгой буюу 55.4 хувийг нь ямаа эзэлж байна.

Б. Богд сум

Богд сум нь аймгийн төвөөс 130 км, Улаанбаатар хотоос 720 км-ийн зайтай байрладаг, 6 багтай, 398,3 мянган га газар нутагтай, нийт газар нутгийн 96,3 хувийг хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 3,4 хувийг ойн ба усан сан, 0,3 хувийг бусад газар эзэлж байна.

Тус сум нь 2979 хүн амтай, үүний 48,1 хувийг эрэгтэйчүүд, 51,9 хувийг эмэгтэйчүүд эзэлдэг. 2001–2002 оны зуднаар нийт малынхаа 52,2 хувийг зуданд хорогдуулснаас 200 орчим хүн Баянхонгор сум, Улаанбаатар хот болон бусад суурин газруудруу шилжсэн байна.

2004 онд хүн ам 40 хүнээр буюу 1,3 хувиар өссөн байна. Хүн амын 78,6 хувь нь хөдөө буюу малчин өрхийн ам бүлд, 21,4 хувь нь сумын төв дээр амьдардаг байна. Нийт өрхийн 28,9 хувь нэн ядуу буюу ядуу өрхөд хамаарч, 0,9 хувь нь чинээлэг гэсэн бүлэгт багтаж, үлдэх 70,2 хувь дундчууд байна. Хөдөлмөр эрхэлж буй 1348 хүний 94,7 хувь нь буюу 1277 нь малчид байна. Ажилгүйдлийн түвшин 8,2 хувьтай байна.

Богд сум 73340 толгой малтай, нийт малын 2.9 хувь буюу 2171 тэмээ, 2.7 хувь буюу 1954 толгой адуу, 2.4 хувь буюу 1767 толгой үхэр, 14,3 хувь буюу 10483 толгой хонь, 77,7 хувь буюу 56965 толгой ямаа байна. Өнгөрсөн онд малаа 16243 толгойгоор өсгөжээ. Мөн нийт малын 38,3 хувь хээлтэгч байна. Тус суманд бод малын тоо буурсантай холбогдон үнэ нь маш өндөр байна.

Богд сумын малын тоо




график 2.6

Сүүлийн 2 жилд цаг агаар тааламжтай байсан нь малын тоо толгой өсөхөд нөлөөлсөн. Нөгөө талаар зуднаас сургамж авсан малчид малдаа өвс тэжээл бэлтгэх, өвлийн бэлтгэлийг сайтар хангах, малын үүлдэр угсааг сайжруулах талаар нилээд санаачилгатай ажиллаж байна. Тухайлбал 2004 онд аймгийн нийт бэлтгэсэн хадлангийн 49,5 хувь буюу 1532 тн

хадланг бэлтгэжээ. Гэхдээ зэгсийг хадлангийн гол эх үүсвэр болгон хэтрүүлэн ашигласнаас Орог нуур нь 1890 оноос хойшхи хугацаанд 9 дэх удаагаа ширгэсэн байна. Энэ нь мөн элсний нүүдлийг маш хүчтэй болгож байгаа сөрөг талтай.

Богд суманд мал аж ахуйгаас гадна өөр салбар хөгжөөгүй, сумын төв дээр 17 жижиг дэлгүүр үйл ажиллагаа явуулж жилдээ 63,8 сая төгрөгийн бараа, бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд худалддаг байна. Гэхдээ эдгээр жижиг дэлгүүрүүд архи, гурил, чихэр, гутал, өмд оймс, сургуулийн хүүхдийн хичээлийн хэрэглэл, талх нарийн боов зэрэг ижил төрлийн бараа худалддаг.

Хөдөө аж ахуйн хүнсний бүтээгдэхүүн зардаг дагнасан дэлгүүр байхгүй. Мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг хувийн 1 мал эмнэлэгтэй. Тэр нь бараг үйлчилгээ үзүүлдэггүй. Учир нь малчид төлбөр төлж үйлчилгээ авч сураагүй учраас төлбөр төлөх сонирхол багатай нөгөө талаас малын эмч нь ч сонирхолгүй байлаа.

Богд сумын төв дээр ХААН банкны салбар, Кредит Монгол ББСБ-ын төлөөлөл ажилладаг байна. ХААН банк нь малчны зээл, бүлгийн зээлийг олгодог. Зээлийн хүү нь 2.5% хугацаа нь нэг жил, зээлийн нийт хэмжээ 5.0 сая хүртлэх төгрөг, 250 толгой малтай байх, 150 хувийн барьцаа хөрөнгөтэй байна. Харин малыг үнэлэхдээ зах зээлийн үнийн 40-50 хувиар үнэлдэг. Харин Кредит Монгол ББСБ нь зөвхөн Богд суманд мал барьцаалахгүйгээр 3.5-4 хувийн хүүтэй өрхийн, 2.5 хувийн хүүтэй бүлгийн зээл олгодог. Барьцаа хөрөнгө 150 хувь ба малыг зах зээлийн үнийн 50 хувиар үнэлдэг. Мөн «Хориулт ХЗХ» ажиллаж 200 хувийн барьцаа хөрөнгөтэйгээр 6 сар хүртэл хугацаатай 4 хувийн хүүтэй, хувь хүний хэрэглээнд 500000 төгрөгийг, бизнесийн зээл 2.0 сая төгрөг олгож байна. Малчдын зээл нь нийт зээлийн 30 хувийг эзэлдэг байна.

В. Жинст сум

2004 оны эцэст 2053 хүн амтай ба өнгөрсөн оныхоос 0,3 хувиар өсчээ. Нийт хүн амын 45,8 хувь нь хөдөлмөрийн насны хүн эзэлж, албан ёсны ажилгүйдлийн түвшин 9,1 хувьтай байна. Хүн амын 82,4 хувь нь хөдөө, 17,6 хувь нь сумын төв дээр амьдардаг. Нийт өрхийн 356 өрх нь малтай, 115 өрх огт малгүй байна. Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой 187 өрхөд 824 хүн амьдарч байгаагийн 133 өрхийн 608 хүн нэн ядуу амьдралтай байна. Тухайлбал ядуу буюу нэн ядуу гэсэн бүлэгт нийт хүн амын 40,5 хувь нь багтаж байна.

Жинст сум нь 45341 толгой малтай ба өнгөрсөн оноос 35,4 хувиар өссөн байна. Нийт малын 546 толгой буюу 1,2 хувь нь тэмээ, 582 толгой буюу 1,3 хувь нь адуу, 298 толгой буюу 0.6 хувь нь үхэр, 15,1 хувь нь буюу 6832 толгой хонь, 37083 толгой буюу 81,8 хувь нь ямаа байна.

2001-2002 оны зуданд нийтдээ 100-аад мянган толгой мал хорогдсон нь хүн амын амьжиргааны түвшинг их хэмжээгээр бууруулсан байна.

Жилдээ дундажаар 11,1 тн ямааны ноолуур, 5,0 тн хонины ноос, 2,1 тн тэмээний ноос үйлдвэрлэдэг. Мөн Жинст суманд ХААН банкны салбар, Монгол шуудан банкны явуулын үйлчилгээ зээл олгодог байна. ХААН банкны зээл олголтын нөхцөл нь Богд сумынхтай адил. Харин Монгол шуудан банк бизнесийн зээл, жижиг дунд аж ахуйн нэгжийг дэмжих зээл олгодог. Эрсдэл ихтэй гэдгээр шалтгаалан малчны зээлийг олгохгүй байна.

Г. Эрдэнэцогт сум

Эрдэнэцогт сум нь аймгийн төвөөс 28 км-т оршдог 4397 хүн амтай. Үүнээс ажил эрхэлж буй хүн 2159, ажилгүйдэл 6%-тай байна.

1124 өрхтэй өрхийн 83% ядуу ба нэн ядуу өрхт хамаардаг. Сумын хэмжээгээр 46603 толгой малтай, үүнд: тэмээ-11, адуу-3479, үхэр-14010, хонь-15582, ямаа-13521 малтай байна.

Тус сум нь сүү цагаан идээ үйлдвэрлэгч гол сумуудын нэг бөгөөд үйлдвэрлэсэн сүү цагаан идээгээ аймгийн төвд борлуулдаг. Зах зээлд ойрхон давуу талтай, дэд бүтэц сайн хөгжсөн, аймгийн эрчим хүчний сүлжээнд холбогдсон байнгын цахилгаантай, аймгийн төв сумын төвийн хооронд өдөр бүр 4 фургон машин хүн тээвэр хийдэг. Малын 33 хувийг сарлаг эзэлдэг. Эрдэнэцогт сум төвлөрсөн мах бэлтгэл, дотоодын зах зээлд өнгөрсөн онд 3220 толгой мал нийлүүлсэнд үхэр 540, адуу 70, хонь 350, ямаа 26 байна.

2.2. Өвөрхангай аймаг

Өвөрхангай аймаг 19 сум, 108 багтай. Аймгийн төв Арвайхээр Улаанбаатараас баруун урагш 420 км зайд оршдог. Тус аймгийн дэд бүтцийн хөгжил сайн, төвийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон, аймгийн төв болон Хархорин сум засмал замаар Улаанбаатар хоттой холбогдсон. Холбоо мэдээллийн сүлжээ сайн хөгжсөн.

2.2.1. Газар нутаг

Өвөрхангай аймаг нийтдээ 62.9 мян га нутаг дэвсгэртэй. Аймгийн нутгийн 23 хувь нь хангайн, 28.2 хувь нь тал хээрийн, 48.8 хувь нь говийн бүсэд хамаарагддаг.

Нутгийн 3.4 хувь буюу 211.8 мянган га талбайг 17.5 сая шоометр нөөц бүхий шилмүүст болон навчит, заган ой эзэлдэг. Газрын нэгдмэл сан 6289.5 мянган га бөгөөд хөдөө аж ахуйн эдэлбэр газар 5767.8 мянган га байна.

Нийт газар нутгийн 91.7 хувь нь ХАА-н эдэлбэр газар, 3.1 хувь нь ойн сан бүхий газар, 0.05 хувь нь усан сан бүхий газар эзэлж байна. Нийт 104419 га талбай бүхий үзэсгэлэнт 10 газар тусгай хамгаалалтанд байдаг.

2.2.2. Хүн ам

Аймгийн нийт хүн ам 2004 оны эцсээр 108489 болж, өмнөх оноос 688 хүнээр өссөн байна. Хүн амын 35,4 хувийг 15 хүртлэх насны хүүхэд, 58,4 хувийг хөдөлмөрийн насныхан, 10.5 хувийг 60-аас дээш насны хүн ам эзэлж байна. Нийт хүн амын 51 хувь нь эмэгтэй, 49 хувь нь эрэгтэй. Хөдөлмөрийн насны хүн амын 72 хувь буюу 45.6 мянган хүн хөдөлмөр эрхэлж байна. Ажил эрхлээгүй 9.5 мянган хүн байгаагийн 2.3 мянга нь албан ёсны ажилгүйчүүд буюу хөдөлмөр зохицуулалтын албанд бүртгэлтэй байна.

Нийт хүн амын 21.5 хувь нь аймгийн төвд, 23.2 хувь нь сумын төвд, 55,3 хувь нь хөдөө амьдарч байна.

Аймаг 28429 өрхтэй, нэг өрхөд дундажаар 3,8 хүн оногдож байгаа нь улсын дундажаас 0,4 хүнээр цөөн байна. 2004 онд малчин өрхийн тоо 361-ээр буурсан байна. Нийт малчин өрхийн 62,6 хувь нь 100 хүртлэх толгой малтай, 22 хувь нь 101-200 хүртлэх толгой малтай, 14 хувь нь 201-500 хүртлэх толгой малтай, 1.1 хувь нь 501-1000 хүртлэх толгой малтай, 0,2 хувь нь 1000-аас дээш толгой малтай байна.

2.2.3. Хөдөө аж ахуй

Малын тоо, бүтэц

Өнгөрсөн 2004 оны эцэст аймаг нийтдээ 2155452 толгой малтай болсон ба малын тоог онуудаар авч үзвэл




график 2.7

2004 онд өнгөрсөн оноос 236.6 мянган толгойгоор малын тоо өссөн нь өнгөрсөн жил цаг агаар тааламжтай байсантай холбоотой юм. Нийт малын 38.7 хувийг хээлтэгч мал эзэлж байна. Цэвэр үүлдрийн ба шилмэл омгийн мал нийт малын 4.3 хувийг эзэлж байгаа юм.

Аймгийн нийт малын 43.9 хувийг ямаа, 45.1 хувийг хонь, 4.2 хувийг үхэр, 6.2 хувийг адуу, 0.6 хувийг тэмээ эзэлж байна.

Газар тариалан ба тэжээл бэлтгэл

Өнгөрсөн 2004 оны байдлаар бүх сумдын иргэд төмс, байцаа, манжин, лууван зэрэг хүнсний ногоо тариалсан байна.

Тариалсан талбай ба хураан авсан ургац




график 2.8

Хураан авсан төмс, хүнсний ногооны хэмжээ жил дараалан өссөн байгаа бөгөөд энэ нь хөдөөгийн хүн ам орлогоо нэмэгдүүлэх шинэ эх үүсвэр болгон газар тариалан эрхлэх болсонтой холбоотой юм.

Хураан авсан хүнсний ногооны 60 орчим хувийг зах зээлд борлуулсан, 10 орчим хувийг дараа жилийн үрийн хэрэглээнд нөөцөлсөн, 30 гаруй хувийг өөрсдийн хэрэглээнд зарцуулжээ.

Өвөрхангай аймаг 2004 онд 20292.7 тонн байгалийн хадлан, 4200 тонн гар тэжээл бэлтгэсэн байна.

Боловсруулах аж үйлдвэрийн салбар

Аж үйлдвэрийн гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Хүснэгт 2.1

	Бүтээгдэхүүн	хэмжих нэгж	2003	2004	2004/2003
1	Гурил	тн	18.8		-100
2	Талх	тн	220.7	320.7	45.3
3	нарийн боов	тн	181.2	227.1	25.3
4	Архи	мян.литр	146.1	170.1	16.4

5	Ундаа	мян.литр	159.5	204.7	28.3
6	Цахилгаан	мян.квт	151.3	143.1	-5.4
7	Дулаан	мян. гкал	40.6	41.5	2.2
8	Нүүрс олборлолт	ян.тн	34.1	34.4	0.9
9	гэрийн мод	шир	172	183	6.4
10	Гутал	хос	478	207	-56.7
11	Оёдол	шир	533	756	41.8
12	Чихэр	тн	0.4		-100.0

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь үнийн дүнгээр 1.633.161.3 мянган төгрөг болж 2003 оныхоос 14.5 хувиар өссөн байна. Үүний дотор хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл 24.9 хувиар өсчээ. Харин өнгөрсөн жил гурил үйлдвэрлээгүй нь Хархорин суманд ургац алдаж нэг га-аас 0.4 центнер ургац авсан, гурилын үйлдвэрлэл ашиггүй болж зогссон, импортын болон Улаанбаатараас нийлүүлэгдэх гурилын хэмжээ, чанар өссөнтэй холбоотой байна. Аймгийн хүнсний үйлдвэрт чихэр үйлдвэрлэх нь ашиг багатай байгаагийн зэрэгцээ чанарын хувьд зах зээлийн шаардлагыг тэр бүр хангахгүй, борлуулалт буурч ирсэнтэй холбоотойгоор чихрийн үйлдвэрлэл зогссон байна. Нөгөө талаар импортын сайн чанарын олон нэр төрлийн чихрийн хангамж нэмэгдсэн явдал нөлөөлсөн байна. Цаашид үйлдвэрлэлийг сэргээх боломж бага байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтын хэмжээ аймгийн дүнгээр 10.1 хувиар нэмэгдэв. Нийт бараа гүйлгээ 2738550.8 мянган төгрөг болж 2003 оныхтой харьцуулахад 95.8 хувиар өссөн байна. Үүний дотор хүнсний бүтээгдэхүүний борлуулалт 19 хувиар, мод, модон эдлэлийн борлуулалт 124.6 хувиар, оёмол бүтээгдэхүүний борлуулалт 55.8 хувиар тус тус өссөн байна.

Аймгийн татварын албанд бүртгэлтэй 376 аж ахуйн нэгж, үүний дотор ОНӨААҮГ 3, ТӨҮГ 4, ХК 18, ХХК 182, нөхөрлөл 71, хоршоо 98 тус тус үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр аж ахуйн нэгжүүдийн 61 хувь нь худалдаа, арилжааг голлон явуулдаг байна. Компаниуд нь гол төлөв Арвайхээр, Хархорин, Хужирт зэрэг томоохон сумын төв, суурин газарт төвлөрсөн бол хоршоо, нөхөрлөл нь хөдөөгийн сумдад зонхилж байна.

2.2.4. Аймаг, сумдыг хөгжүүлэх бодлого

Аймгийн 2004-2008 онд баримтлах чиглэл- стратегийн нэгдсэн хөтөлбөрт хөдөө аж ахуйн хөгжлийн талаар:

1. хоршооны хөгжлийн аймгийн дэд хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах,
2. “хүлэмж” төсөл хэрэгжүүлж малын тэжээл 200-с доошгүй га-д, төмс, хүнсний ногоог 100 хувь усалгаатай тариалж, ургацыг нэмэгдүүлэх,
3. Арвайхээрт шувууны жижиг аж ахуй бий болгох

4. Бэлчээрийн менежментийг сайжруулах талаар зохиож буй ажлын туршлага, арга барилын үзүүлэх сургуулийг Хужирт, Төгрөг сумдад зохион байгуулах,
5. Мах, сүүг бүрэн боловсруулах чадавхийг нэмэгдүүлэх, малчдын бүлгийг дэмжих чиглэлээр болзол зарлаж дүгнэх,
6. Бөөний худалдааны сүлжээ байгуулах асуудлыг судалж хэрэгжүүлэх,
7. Шахмал түлш үйлдвэрлэх,

Аймгийн зүгээс эдгээр арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж чадвал мал аж ахуйн үйлдвэрлэлийг сайжруулж, бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой болох юм.

2.2.5 Судалгаанд хамрагдсан сумд

А. Төгрөг сум

Төгрөг сумын төв Хоолт нь аймгийн төвөөс урагш 100 км, Улаанбаатар хотоос 520 км-ийн зайтай байрладаг, 4 багтай, 5467 хавтгай дөрвөлжин км газар нутагтай, нийт газар нутгийн 97.4 хувийг хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 2.2 хувийг ойн, үлдэх хэсгийг усан сан эзэлж байна. Говийн бүсэд багтана.

Тус сум нь 2839 хүн амтай нийт хүн амын 49.3 хувь нь эрэгтэй, 50.7 хувь нь эмэгтэй 2004 онд хүн ам нь 201 хүнээр буюу 7.6 хувиар өссөн байна. Нийт 895 хүн сумын төвд, 1944 хүн хөдөөд амьдардаг байна. Хөдөлмөр эрхэлж буй 1170 хүн байгаа нь эдийн засгийн идэвхтэй хүн амын 94.5 хувийг эзэлж байгаа ба харин ажилгүй хүн 68 байгаа нь нийт хүн амын 2.4 орчим хувийг эзэлж байгаагийн 38 буюу 56 хувь нь эмэгтэйчүүд байна.

Малын тоо




график 2.9

Малын тоо 2004 онд урьд оноос 10248 толгойгоор буюу 11.3 хувиар өссөн байна. Нийт малын 49.6 хувь нь ямаа, 42.6 хувь нь хонь, 4.91 хувь нь адуу, 2.4 хувь нь тэмээ, 0.9 хувь нь үхэр байна.

2004 онд бороо хур бага, царцаа, оготнын хөнөөл зэргээс газрын гарц муу байсан тул хадлан тэжээл ихээр бэлтгэж базаагаагүй байна. Тухайлбал өвс 34.3 тонн, гар тэжээл 31.1 тонныг бэлтгэсэн нь урьд жилийнхээс 31-53 хувиар бага байна.

Газар тариалангийн үйлдвэрлэлийн хувьд 2004 онд 14.3 га талбайд төмс, хүнсний ногоо тариалж, 184 тонн ургац авсан нь өмнөх оныхоос 42.6 тонноор их байна. Тус суманд байрлах Мазарын усалгаатай талбайд иргэд, малчид, малчдын бүлгийнхэн хүнсний ногоо тариалж зах зээлд борлуулж байна.

Тус суманд 12 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдгийн, 9 нь хоршоо ба 6 хоршоо нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, 1 нь мал эмнэлгийн үйлчилгээ явуулдаг байна.

Сумын төвд жижиг дэлгүүр, мухлаг зэрэг 13 үйлчилгээний цэг ажиллаж, 2004 онд 25390.7 сая төгрөгийн бараа борлуулалт хийсэн байна. Мах, сүү, цагаан идээг малчдаас авч худалдах ба бусад төрлийн өргөн хэрэглээний барааг аймгийн төв, хилийн боомтоос гол төлөв татан авч борлуулалт хийдэг.

Б. Сант сум

Сант сум нь говийн бүсэд багтах бөгөөд сумын төв Майхан нь аймгийн төвөөс зүүн урагш 95 км, Улаанбаатар хотоос 360 км-ийн зайтай байрладаг, 5 багтай, 2586 хавтгай дөрвөлжин км газар нутагтай, нийт газар нутгийн 99.7 хувийг хөдөө аж ахуйн эдэлбэр газар, үлдэх хэсгийг усан сан эзэлж байна.

Хүн ам

Тус сум нь 3706 хүн амтай, үүний 49.9 хувь нь эрэгтэй, 50.1 хувь нь эмэгтэй. Нийт 648 хүн буюу 21.1 орчим хувь нь сумын төвд, 3058 хүн буюу 78.9 хувь нь хөдөөд амьдардаг байна. Нийт 1119 өрхтэй ба нэг өрхөд ногдох ам бүлийн тоо нь хөдөөд 3.2 хүн, сумын төвд 3.8 хүн ногдож байна. Хөдөлмөр эрхэлж буй 1615 хүн байгаа ба харин ажилгүй хүн 16 байгаа нь нийт хүн амын 0.4 орчим хувийг эзэлж байгаагийн 9 буюу 56 хувь нь эмэгтэйчүүд байна.

Мал аж ахуй

Сант сум нийт 168750 толгой малтай, нийт малын 0.5 хувийг нь тэмээ, 3.7 хувийг адуу, 2.1 хувийг үхэр, 49.3 хувийг хонь, 44.2 хувийг нь ямаа эзэлж байна. Өнгөрсөн оноос 17480 толгойгоор нэмэгджээ. Нийт малын 40 хувь нь хээлтэгч байна. Малтай өрхийн 81.7 хувийг 51-500 малтай өрх эзэлж, 1000-аас дээш малтай өрх байхгүй байна.

Газар тариалан

2004 онд өвс 590 тонн, гар тэжээл 202 тонныг бэлтгэсэн нь урьд жилийнхээс 5.8-12.5 хувиар өссөн байна. Газар тариалан эрхлэх боломж тааруу, газар нутаг нь хуурайшилт

ихтэй, хужир шүү бүхий шаварлаг хөрстэй нь зохих хүндрэл учруулдаг, тухайлбал 2004 онд дөнгөж 1.9 га талбайд төмс, хүнсний ногоо тариалж, 17.4 тонн ургац авсан байна.

Үйлдвэрлэл үйлчилгээ

Тус суманд 9 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдгийн 4 нь хоршоо байгаа ба үүний 2 нь малчдын хоршоо / бүлэг / байна. Хоршоод нь гол төлөв хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байна. Нөхөрлөл 5 байдаг ба нэг нь мал эмнэлгийн үйлчилгээ эрхэлж, 4 нь худалдаа үйлчилгээний чиглэлээр ажиллаж байна.

Сумын төвд жижиг дэлгүүр, мухлаг зэрэг 10 гаруй үйлчилгээний цэг байдаг бөгөөд 2004 онд 133,3 сая төгрөгийн бараа борлуулжээ. Мах, сүү, цагаан идээг малчдаас авч худалдах ба бусад төрлийн өргөн хэрэглээний зүйлийг Улаанбаатар хот, аймгийн төвөөс гол төлөв татан авч үйл ажиллагаа явуулж байна. Нэг хүн хувиараа нарийн боовны үйлдвэрлэл явуулдаг. Түүнийг Чойсүрэнгийн Дэлгэрцэцэг гэдэг бөгөөд өвөл, хаврын улиралд сургуулийн хүүхэд, дотуур байрны хэрэгцээнд зориулж өдөрт 200 нэгж-ширхэг бүтээгдэхүүн хийдэг байна. Мөн модон эдлэл, сийлбэр хийдэг, буриад гутал үйлдвэрлэдэг засварладаг хувь хүмүүс хэд хэд бий. Тэдний нэг нь хөдөөгийн малчин бөгөөд малчдын захиалгаар хөхүүрийн цах, гал тогооны тавиур хийдэг. Харин сумын төвд оршин суудаг малчин эмэгтэй Тулгаагийн 2 хүүхэд төрөл бүрийн сийлбэртэй модон эдлэл хийдэг байна. Эдгээр нь өргөн хүрээтэй болж хөгжих хандлага багатай. Учир нь захиалга бага, модны олдоц сайнгүй.

В. Хужирт сум

Хужирт хангайн бүсэд хамаарах бөгөөд сумын төв Халуун-Ус нь аймгийн төвөөс хойш 84 км, Улаанбаатар хотоос 390 км-ийн зайтай байрладаг, тус сум 5 багтай, 1663 хавтгай дөрвөлжин км газар нутагтай, нийт газар нутгийн 75 хувийг хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 6.4 хувийг ойн сан, үлдэх хэсгийг усан сан эзэлж байна. 126 мянган га бэлчээртэй. Нуур, гол, булаг, рашаан зэрэг гадаргуугийн усны нөөц ихтэй. Хужирт сум дэд бүтцийн хөгжил сайн, төвийн эрчим хүчний системд холбогдсон.

Хүн ам

Тус сум нь 6871 хүн амтай, хүн амын 48.6 хувь нь эрэгтэй, 51.4 хувь нь эмэгтэй. Нийтдээ 2031 өрхтэй, нийт 2843 хүн сумын төвд, 4028 хүн хөдөөд амьдардаг байна. Хөдөлмөр эрхэлж буй 2521 хүн байгаа ба харин ажилгүй хүн 239 байна.

Хужирт сумын малын тоо




график 2.10

Хужирт сум нийт 118203 толгой мал тоолуулсан нь өнгөрсөн оноос 9313 толгойгоор буюу 8.5 хувиар өсчээ. Нийт малын 0.5 хувийг нь тэмээ, 3.7 хувийг нь адуу, 2.1 хувийг нь үхэр, 49.3 хувийг нь хонь, 44.2 хувийг нь ямаа эзэлж байна. Нийт малын 40 хувь нь хээлтэгч байна. Тус суманд 1000-аас дээш малтай өрх 2 байна. Малтай өрхийн 51.4 хувийг 51-500 малтай, 22,5 хувийг 31-50 малтай өрх эзэлж байна.

Газар тариалан

2004 онд 44.8 га талбайд төмс, хүнсний ногоо тариалж, 249.8 тонн ургац авсан нь 55.8 тонноор 2003 оныхоос өссөн байна. Зохион байгуулалттай малчны зарим бүлгүүд төмс, хүнсний ногоо тариалж туршсан нь үр дүнтэй болжээ.

2004 онд өвс 2112 тонн, гар тэжээл 198 тонныг бэлтгэсэн нь урьд жилийнхээс 6-17 хувиар өссөн байна.

Үйлдвэрлэл үйлчилгээ

Тус суманд 23 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдгийн 12 нь ХХК, 7 нь хоршоо, 2 нь нөхөрлөл, 2 нь хувьцаат компани байна. Хоршоод нь гол төлөв хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байгаа ба үүнээс 3 нь малчны бүлгийн зохион байгуулалтаар ажилладаг байна. Компаниуд нь ихэнхдээ худалдаа үйлчилгээ эрхлэх ба зочид буудал 2, хүүхдийн зуслан нэг, мал эмнэлгийн үйлчилгээ эрхэлдэг 1, жуулчны үйлчилгээ эрхэлдэг 1, архи ундааны үйлдвэрлэлийн нэг компани байна. Сумын төвд худалдааны ба бөөний худалдааны төв, жижиг дэлгүүр, мухлаг, жуулчны бааз, зочид буудал, бар зэрэг 70 орчим үйлчилгээний цэг байдаг бөгөөд 2004 онд нийт бараа борлуулалт 127.8 сая төгрөг болсон.

Хужиртын рашаан сувилал нь улсын хэмжээнд үйлчилгээ явуулдаг бөгөөд сумын төвийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтэнд томоохон нөлөөлөл үзүүлдэг. Худалдааны цэг салбар, рашаан сувилал нь мах, сүү, цагаан идээг малчдаас авч худалдах ба бусад төрлийн өргөн хэрэглээний зүйлийг Улаанбаатар хотоос гол төлөв татан авч үйл ажиллагаа явуулж байна.

Гэрийн сийлбэртэй болон эрээн мод нь улс даяар алдаршсан. Үүнд “Баянзүлэгт” хоршоо томоохон байр суурийг эзэлдэг бөгөөд сүүлийн жилүүдэд зах зээл дэх эрэлт багассанаас үйлдвэрлэл буурах хандлагатай байна.

Г. Арвайхээр сум

Өвөрхангай аймгийн төв-Арвай хээр сум, Улаанбаатар хотоос 420 км-ийн зайтай байрладаг, 9 багтай, 17303 га талбай бүхий нутагтай, газар нутгийн 36 хувийг хөдөө аж ахуйн эдэлбэр газар эзэлж байна. 6365 га бэлчээртэй. Арвайхээр сум дэд бүтцийн хөгжил сайн, төвийн эрчим хүчний системд болон Улаанбаатар хоттой хатуу хучилттай замаар холбогдсон.

Хүн ам

Тус сум нь 23298 хүн амтай, нийт хүн амын 47.6 хувь нь эрэгтэй, 52.4 хувь нь эмэгтэй. 2004 онд хүн ам нь 404 хүнээр буюу 1.7 хувиар өссөн байна. Нийт 5289 өрхтэй. Хөдөлмөр эрхэлж буй 7916 хүн байгаа ба харин ажилгүй хүн 893 байгаа нь нийт хүн амын 3.8 орчим хувийг эзэлж байна. Ажил эрхэлж байгаа хүний тоо 2003 оныхоос 2.8 хувиар буюу 218 хүнээр нэмэгдсэн байна.

Арвайхээр сумын малын тоо

Хүснэгт 2.2

	1995 он	2000 он	2001 он	2002 он	2003 он	2004 он
Бүгд	82130	36669	23785	27663	36527	42447
Тэмээ	18	4	1	3	0	5
Адуу	2860	1662	8217	1348	1744	1664
Үхэр	5665	2604	873	959	1190	1302
Хонь	57452	21755	13652	15210	18814	21521
Ямаа	16135	10644	8062	10143	14779	17955

Арвайхээр сум нийт 42447 толгой малтай, нийт малын 0.01 хувийг нь тэмээ, 3.9 хувийг нь адуу, 3.1 хувийг нь үхэр, 50.7 хувийг нь хонь, 42.3 хувийг нь ямаа эзэлж байна. Өнгөрсөн оноос малын тоо нь 5920 толгойгоор өсчээ. Мөн нийт малын 43.3 хувь хээлтэгч байна.

Тус суманд 1000-аас дээш малтай өрх байхгүй, 10-100 малтай өрх 74.2 хувийг, 100-аас дээш малтай өрх 18.1 хувийг эзэлж байна.

Газар тариалан

2004 онд өвс 422.1 тонн, гар тэжээл 160.8 тонныг бэлтгэсэн нь урьд жилийнхээс 45.5-76 хувиар өссөн байна.

Арвайхээр сум 2004 онд 84.8 га талбайд төмс, хүнсний ногоо тариалж, 802 тонн ургац авсан нь 126.6 тонноор 2003 оныхоос бага байна.

Үйлдвэрлэл үйлчилгээ

Тус суманд 162 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдгийн 96 нь хувийн өмчийн ХХК, 22 нь хоршоо, 31 нь нөхөрлөл, харин 9 нь хувьцаат компани байна. Төрийн өмчийн оролцоотой байгууллага 4 байна.

Сумын төвд Худалдааны төв, бөөний худалдааны төв, жижиг дэлгүүр, мухлаг, жуулчны бааз, ресторан, цайны газар, кафе, бар зэрэг 405 үйлчилгээний цэг байдаг бөгөөд нийт бараа гүйлгээ 703,3 сая төгрөг байгаа нь аймгийн нийт гүйлгээний 25 орчим хувийг эзэлж байна. Худалдааны цэг салбарууд нь мах, сүү, цагаан идээний төрлийг малчдаас авч худалдах ба бусад төрлийн өргөн хэрэглээний зүйлийг Улаанбаатар хот, аймгийн төвийн захаас гол төлөв татан авч үйл ажиллагаа явуулж байна.

2.3. Сэлэнгэ аймаг

2.3.1. Газар нутаг

Сэлэнгэ аймаг нь байгалийн бүслүүрийн хувьд хангайн бүсэд оршдог. Нийт газар нутгийн хэмжээ 4115263 га ба нийт талбайн 45.89 хувь нь хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 0.85 хувь нь хот суурин газар, 0.47 хувь нь зам шугам сүлжээ, 52.29 хувь нь ойн сан бүхий газар, 0.5 хувь нь усан сан бүхий газар байна. Манай улсын ойн сан бүхий газрын 11.6 хувь нь Сэлэнгэ аймагт байна.

Сэлэнгэ аймгийн ХАА-н эдэлбэр газрын бүтэц




График 2.11

ХАА-н эдэлбэр газрын 62 хувь нь бэлчээр, 23 хувь нь хадлан, 15 хувь нь тариалангийн талбай эзэлж байна.

2.3.2. Хүн ам

Сэлэнгэ аймаг нийтдээ 101.8 мянган хүн амтай нь хүн амын тоогоороо аймгуудаас 3 дугаарт орж байна. Нийт хүн амын 31.8 хувь суурин газар, 68.2 хувь хөдөөд амьдарч байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2004 онд 1258 болсон нь урьд оныхоос 45.6 хувиар нэмэгджээ.

2.3.3. Хөдөө аж ахуй

Малын тоо, бүтэц

Тус аймаг 2004 онд 577,4 мянган толгой малтай болсон байна. Малын тоо 2004 онд урьд оноос 9.5 мянган толгойгоор буурсан нь 2002-2003 онд тохиолдсон цаг агаар хүндэрч зуд болсонтой холбоотой юм.

Нийт малын 45.1 хувийг хээлтэгч мал эзэлж байна. Нийт малын 46.1 хувийг хонь, 33.96 хувийг ямаа, 12.38 хувийг үхэр, 7.43 хувийг адуу, 0.12 хувийг тэмээ эзэлж байна.

2000-2004 онд хийгдсэн үржлийн ажил үйлчилгээний дүнд жилд дундажаар 90 гаруй мянган бог, 20-иод мянган бод малд үзлэг ангилалт хийж 51.3 мянган хонь, 16.3 мянган ямаагаар цөм сүрэг бүрдүүлжээ. Аймгийн малын үржлийн албанд Орхон, Ерөө үүлдрийн 500 гаруй хонь, сүүний чиглэлийн 20 гаруй үхрээс бүрдсэн орон нутгийн өмчит “Генefonдын аж ахуй” байгуулан үржлийн мал өсгөн бойжуулах, үр, үр хөврөл, үржлийн мал импортлох, экспортлох үүрэгтэй ажиллуулж байна.

Мах, сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор АНУ-аас махны хонь, Итали, АНУ-аас махны үхэр, Норвеги улсаас сүүний үхрийн үр авч хээлтүүлэгт ашиглаж байна.

Цэвэр үүлдрийн болон эрлийз малын тоо 2004 онд өмнөх оноос 2, 3 хувиар нэмэгдсэн. 2004 онд мал өвөлжилтөнд зориулан 124.0 мян тн хадлан, 5.9 мян тн хүчит тэжээл, 10.0 мянган тн давс хужир бэлтгэсэн нь нэг хонин толгойд 51 кг тэжээлийн нэгж ногдож байна.

Сэлэнгэ аймагт таван хошуу малаас гадна гахай, шувууны аж ахуйг эрхэлдэг. Манай улсын нийт гахайны 42.3 хувь нь буюу 5810 толгой гахайтай, шувууны 79.7 хувь нь буюу 12156 толгой шувуутай байна. 2004 оныг урьд онтой харьцуулахад шувуу 20 хувь үүнээс өндөглөгч 24.5 хувиар буурсан бол гахай 28.3 хувь, үүнээс үндсэн мэгж 5.7 хувиар тус тус өсчээ.

Газар тариалан

Сэлэнгэ аймаг нь манай улсын газар тариалангийн гол бүс нутаг юм. Монгол улсын нийт тариалангийн талбайн 41.9 хувь нь Сэлэнгэ аймагт байдаг.

Аймгийн нийт тариалсан талбайн 92.7 хувьд үр тариа, 1.5 хувьд төмс, 1 хувьд хүнсний ногоо, 4.8 хувьд тэжээлийн болон бусад ургамал тариалж байна.

Аймгийн хэмжээнд усалгаатай тариалан эрхлэх хөдөлгөөн эрчимтэй өрнөж 2004 онд буудай 1432 га, төмс 560 га, хүнсний ногоо 889 га-д тариалалт хийсэн байна.

Усалгаатай талбай




график 2.12

Усалгаатай тариалан эрхэлсний үр дүнд нэг га-аас төмс 105 цн, хүнсний ногоо 99.4 цн-ийн ургац хураан авсан нь аймгийн дундажаас 12-20 цн-ээр илүү байна.

2004 оныг 2003 онтой харьцуулахад үр тариа 12.2 хувиар, хүнсний ногоо 7.1 хувь тус тус буурч харин төмс 3.5 хувиар өссөн байна. Энэ нь:

1. Үр тариа тариалсан талбайн хэмжээ 18.7 хувиар буурсан боловч 1 га-с авах ургацын хэмжээ 8.6 хувиар өссөн,
2. Төмс тариалсан талбайн хэмжээ 15.9 хувиар өссөн боловч 1 га-с авах ургацын хэмжээ 10.7 хувиар буурсан,
3. 2004 оны зун 2242 га мөндөрт цохиулсан, 3772 га ганд нэрвэгдсэн, 430 га царцаанд идүүлж нийтдээ 6444 га-с ургац алдсан /Тухайлбал дээрх хураан авах боломжтой 5864 тн ургацыг алджээ/-тай холбоотой байна.

Улсын дундажаар 2004 онд нэг га-аас үр тариа 8.0 цн авсан бол Сэлэнгэ аймаг нь 8.8 цн-ийг авсан нь 0.8 цн буюу 10 хувиар илүү ургац авсан байна. Сэлэнгэ аймаг нь улсын нийт үр тарианы ургацын 52.1 хувь төмсний 18.2 хувь, хүнсний ногооны 25.8 хувийг хураажээ.

2.3.4. Аймаг, сумдыг хөгжүүлэх бодлого

Сэлэнгэ аймгийн засаг даргын хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг дэмжих хүрээнд:

1. Дээд үржүүлгийн үр үржүүлэх чиглэлээр " Үр " дэд хөтөлбөр
2. Хүнсний хангамж аюулгүй байдал, хоол тэжээл хөтөлбөр
3. Ногоон хувьсгал дэд хөтөлбөр
4. Цагаан хувьсгал дэд хөтөлбөр
5. Мал эмнэлгийн эмчлэн сэргийлэх арга хэмжээ дэд хөтөлбөр
6. Мал сүргийг ган зудаас хамгаалахад туслах дэд хөтөлбөр
7. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх дэд хөтөлбөр хэрэгжүүлж байгаа болно.

Эрчимсэн мал аж ахуйг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд 8 суманд сүүний үхрийн, 13 суманд махны үхрийн , 5 суманд мах ноосны хонины, 4 суманд гахайны, 2 суманд шувууны, 1 суманд зөгийн эрчимжсэн аж ахуй байгуулах зорилт дэвшүүлээд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Баруунбүрэн, Сайхан суманд сүү цуглуулах, хөргөх анхан шатны боловсруулалт хийх цех байгуулан ажиллаж байна.

Ялангуяа мах сүүн бүтээгдэхүүнд эцсийн боловсруулалт хийж зах зээлд нийлүүлэх, зах зээлийн тогтолцоог сайжруулах, төмс, хүнсний ногоо, гахай, шувууны аж ахуйг дэмжих зэрэг асуудал нь уламжлалт бус бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар малчдын орлогыг нэмэгдүүлэхэд багагүй хувь нэмэр болно гэж үзэж байна.

Тус аймгийн дэд бүтцийн хөгжил сайн, төвийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон, аймгийн төв болон олонх сумд хатуу хучилттай засмал зам болон төмөр замаар Улаанбаатар хоттой холбогдсон. Холбоо мэдээллийн сүлжээ сайн хөгжсөн.

Сэлэнгэ аймагт 1389 аж ахуйн нэгж бүртгэлтэйгээс 985 аж ахуйн нэгж нь үйл ажиллагаа явуулдаг байна. Газар тариалангийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг 325 аж ахуйн нэгж , уул уурхай олборлох үйлдвэр-10, боловсруулах үйлдвэр-88, цахилгаан, хий үйлдвэрлэл, усан хангамж-13, барилга-6, бөөний болон жижиглэн худалдаа-202, зочид буудал, зоогийн газар-30 үйл ажиллагаа явуулж байна.

2.3.5 Судалгаанд хамрагдсан сумд

А. Жавхлант сум

Жавхлант сумын төв нь аймгийн төвөөс урагш 60 км, Улаанбаатар хотоос 280 км-ийн зайтай байрладаг, 3 багтай.

Дархан хотыг дайрч өнгөрдөг олон улсын чанартай хатуу хучилттай засмал зам сумын төвөөс баруун тийш 8 км-ын зайтай өнгөрөх ба төвийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон. Холбоо мэдээллийн сүлжээ сайн.

Хүн ам

Жавхлант сум нь 1804 хүнтэй ба үүний 51.5 хувь нь эрэгтэй, 48.5 хувь нь эмэгтэй. Өрхийн ам бүлийн дундаж тоо 4.0 байгаа нь аймгийн дундажаас 0.5 хүнээр бага. Нийтдээ 450 өрхийн 30.2 хувь нь малгүй, 69.7 хувь нь малтай байна. Албан ёсоор бүртгүүлсэн ажилгүйчүүдийн тоо 34 байгаа нь Сэлэнгэ аймгийн ажилгүйчүүдийн 2.6 хувийг эзэлж байна.

Малын тоо

Нийт 53083 толгой малтай ба нийт малын 5 хувийг адуу, 7 хувийг үхэр, 42 хувийг ямаа, 47 хувийг хонь эзэлж байна. Нийт малын 2.8 хувийг цэвэр үүлдрийн болон эрлийз мал эзэлж байна. 2004 онд тус сум 253 толгой шувуу, 155 гахай тоологдсон байна.

Малын тоо




график 2.13

Графикаас харахад малын тоо жил дараалан буурах хандлагатай байна. Үүний гол шалтгаан нь :

- 1) 2003 онд хээлтэгч малын 46.0 хувь нь төллөсөн;
- 2) оны эхний малын 9.1 хувь нь зүй бусаар хорогдсон зэрэг гэж үзэж болох юм.

Тус сумын мал бүхий нэг өрхөд дундажаар 169 толгой мал ноогдож байгаа нь Сэлэнгэ аймгийн дундажаас даруй 99.2 толгойгоор илүү байна. Гэхдээ мал бүхий өрхийн 37.9 хувь нь 100 хүртлэх толгой малтай байна.

Газар тариалан

Жавхлант сумын гол үйлдвэрлэл нь газар тариалан юм. Нийт тариалсан талбайн 96.02 хувь буюу 3638 га-д үр тариа, 2.48 хувь буюу 94.1 га-д хүнсний ногоо, 1.5 га-д төмс

тариалж нийтдээ үр тариа 2794 тн, хүнсний ногоо 1210 тн, төмс 466 тн-ийг тус тус хураан авсан байна.

2004 оныг 2003 онтой харьцуулан үзэхэд тариалсан талбайн хэмжээ 36.2 хувиар буурсан, 1 га-аас хураан авсан ургац үр тариа 48.1 хувиар нэмэгдсэн, төмсний ургац 28.6 хувиар буурсан, хүнсний ногооны ургац 6 хувиар тус тус буурсан байна.

Үйлдвэрлэл үйлчилгээ

Тус суманд 37 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдгийн 2 нь хоршоо, 28 нь газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг ХХК, 6 нь төсвийн байгууллага, 1 нь хувийн мал эмнэлэг байна. Жавхлант суман дахь гурилын үйлдвэр 2004 онд 10 тн гурил үйлдвэрлэсэн.

Сумын төвд хүнсний жижиг дэлгүүр, мухлаг 3, цайны газар 1, ХААН банкны салбар үйл ажиллагаа явуулдаг.

Сумын төвийн ихэнх оршин суугчид болон малчид хүнс болон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг Дархан хотоос татан авдаг бөгөөд 3 жижиг хүнсний дэлгүүрээр тэтгэврийн насныхан болон ажилгүй хүмүүс, сургуулийн хүүхдүүд голлон үйлчлүүлж архи, гурил, будаа, ургамлын тос, савласан сүү, тамхи, ундаа, дэвтэр, ном үзэг зэрэг бүтээгдэхүүнийг худалдан авдаг.

Жавхлант суманд ХААН банкны салбар үйл ажиллагаа явуулдаг.

Б. Мандал сум

Мандал сумын төв аймгийн төвөөс зүүн урагш 95 км, Улаанбаатар хотоос 170 км-ийн зайтай байрладаг, төвийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон, Дархан-Сэлэнгийн төмөр зам дайран өнгөрдөг. Үүрэн телефон болон харилцаа холбооны сүлжээ сайн.

Хүн ам

Мандал сум нь нийтдээ 22864 хүн амтай байгаа нь Сэлэнгэ аймгийн хамгийн олон хүнтэй сумын нэг юм. Тухайлбал Сэлэнгэ аймгийн нийт хүн амын 24.9 хувь нь амьдарч байна. Нийт хүн амын 91.5 хувь нь сумын төвд, 8.4 хувь нь хөдөө амьдарч байна.

Тус суманд ерөнхий боловсролын сургууль 13, нэгдсэн эмнэлэг 1, ерхийн эмнэлэг 5, Тэнгэр, Баялаг гэсэн бөөний худалдааны төв, хүнсний болон барааны дэлгүүр, мухлаг 14, зочид буудал 5, хүнс өргөн хэрэглээний барааны зах 2 тус тус үйл ажиллагаа явуулдаг байна.

Малын тоо

2004 онд Мандал сум нийт 61105 толгой мал тоолуулсан нь өнгөрсөн оныхоос 4.1 хувиар буурсан байна. Жил дараалан малын тоо толгой буурч байгаа нь малчид ашиг шим өндөртэй цөөн тооны малтай болох сонирхол нэмэгдэж байгаатай холбоотой юм.

Мандал сумын цэвэр , эрлийз малын тоо




график 2.14

Цэвэр үүлдрийн болон эрлийз малын тоо 2004 оныг 2002 онтой харьцуулахад 948 толгойгоор буюу 2.4 дахин, 2003 онтой харьцуулахад 9.3 хувь буюу 137 толгойгоор нэмэгдсэн байна.

Нийт малын 38 хувийг хонь, 33.8 хувийг ямаа, 19 хувийг үхэр, 9 хувийг адуу, 0.2 хувийг тэмээ эзэлж байна. Мандал сум 122 тэмээтэй нь аймгийн нийт тэмээний 33.75 хувь байна.

Тус сум гахай, шувууны аж ахуйг эрхлэж байсан уламжлалттай бөгөөд 2004 оны байдлаар 5932 толгой шувуутай, 802 гахайтай нь аймгийн нийт шувуу, гахайны 48,8-13.8 хувь болж байна. Мандал суманд “Спирт Бал Бурам”-ын үйлдвэр ажилладаг нь гахайн аж ахуйн тэжээлийн маш том нөөц.

Газар тариалан

Мандал сум нь төмс, хүнсний ногоог аймагтаа хамгийн ихээр тариалдаг. 2004 онд нийтдээ төмс 500.3 га-д тариалсан нь аймгийн төмсний талбайн 36.9 хувь, хүнсний ногоо 209.6 га-д тариалсан нь аймгийн хүнсний ногооны талбайн 23.5 хувийг эзэлж байна.

Хүнсний ногооны талбайн бүтэц




график 2.15

Сэлэнгэ аймгийн хэмжээгээр нийтдээ 220 га талбайд байцаа тариалсаны 156 га нь Мандал сум тариалжээ. 2004 онд нийтдээ үр тариа 2543 тн, төмс 6351 тн-ийг хураан авсан нь Сэлэнгэ аймгийн хураан авсан төмсний 41.3 хувь, Монгол улсын хураан авсан төмсний 7.0 орчим хувийг эзэлж байна. 2004 онд нийтдээ 4117.1 тн хүнсний ногоо хураан авсан нь Сэлэнгэ аймгийн нийт ургацын 32.5 хувь, Монгол улсын нийт ургацын 8.4 хувийг хураан авсан байна. Мандал сум нь 2004 онд 16150 тн хадлан бэлтгэсэн нь аймгийн хадлангийн 13.2 хувь болж байна.

Үйлдвэрлэл үйлчилгээ

Мандал суманд талх нарийн боовны, ундаа, зайрмагийн, зүсмэл болон зах банз үйлдвэрлэх жижиг дунд үйлдвэрүүд нь 2004 онд талх 1.2 тн, ундаа 24.2 мян л, зайрмаг 104.9 мян шир, нарийн боов 3.9 тн, зүсмэл банз 311 м³, зах банз 169 м³ буюу нийтдээ 26.865 мянган төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь аймгийн аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 0.06 хувийг эзэлж байна.

Мандал суманд ХААН, Монгол шуудан, Зоос, Хас, ХХБ-ны салбарууд байдаг.

В. Баянгол сум

Баянгол сум нь Улаанбаатар хотоос 160 км-ийн, Дархан хотоос 70 км зайтай байрладаг, Улаанбаатар хотыг Дархан, Сэлэнгэ аймгийн төвтэй холбосон хатуу хучилттай засмал зам, төмөр зам дайран өнгөрдөг, Эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон зэргээр дэд бүтцийн хөгжил сайн. Тус сум 4 багтай.

Хүн ам

Нийтдээ 4264 хүнтэй байгаа нь урьд оныхоос 208 хүнээр буюу 4.6 хувиар буурсан байна. Нийт хүн амын 48.3 хувь эрэгтэй, 51.7 хувь нь эмэгтэй. Баянгол сум нь 1116 өрхтэй. Нийт өрхийн 27.7 хувь нь хөдөө, 72.2 хувь нь сумын төвд амьдарч байна.

Малын тоо

2004 онд Баянгол сум нь нийт 53785 толгой малтай болсон нь урьд оныхоос 2.4 хувиар өссөн байна. Нийт малын 42.9 хувийг цэвэр үүлдрийн болон эрлийз мал эзэлж байна.

Цэвэр, эрлийз малын тоо




график 2.16

2004 онд 23084 толгой цэвэр үүлдрийн болон эрлийз малтай болсон нь аймгийн нийт малын 19.9 хувийг эзэлж байна.

Нийт малын 48 хувь нь хонь, 34 хувь нь ямаа, 9 хувь нь үхэр, адуу байна. Баянгол сум нийтдээ 420 шувуу, 255 гахайтай байна. Нэг онцлог нь зөгийн аж ахуй эрхэлдэг.

Газар тариалан

Баянгол суманд газар тариалан талбай атаршсан байдалд байна.




график 2.17

2004 онд 1982.3 га-д тариалалт хийсэн нь нийт эргэлтийн талбайн 10.7 хувийг эзэлж байна. Үүний 94.1 хувьд үр тариа, 2.5 хувьд төмс, 3.4 хувьд хүнсний ногоо тариалжээ.

Өнгөрсөн онтой харьцуулахад 2004 онд хураан авсан үр тариа 39.3 хувь, хүнсний ногоо 1.3 хувиар тус тус буурч, төмс 3.8 хувь өссөн байна.

Үйлдвэрлэл үйлчилгээ

Улаанбаатар, Дархан, Сэлэнгэ аймгийг холбосон хатуу хучилттай засмал замыг дагасан 20 гаруй үйлчилгээний цэг тус суманд ажилладаг нь хүнсний бүтээгдэхүүний томоохон зах зээлийг бий болгодог.

Баянгол сумын жижиг, дунд үйлдвэрүүд нь 2004 онд талх 58.6 тн, ундаа 51.4 мян литр, 65.7 мянган ширхэг зайрмаг, 0.5 тн нарийн боов буюу 27.7 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 26.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. Баянгол суманд ХААН банкны салбар үйл ажиллагаа явуулж, Хас, Монгол шуудан банкнуудын явуулын үйлчилгээ үзүүлдэг.

Г. Дархан- Уул аймгийн төв Дархан сум

Дархан сум нь Улаанбаатар хотоос 230 км зайд байрлах ба Улаанбаатар болон Сэлэнгэ, Орхон аймагтай хатуу хучилттай засмал зам, төмөр замаар, төвийн эрчим хүчний системд холбогдсон. Тус суманд аж үйлдвэрийн салбар сайн хөгжсөн онцлогтой, 16 багтай. Холбоо мэдээллийн сүлжээ өндөр хөгжсөн.

Хүн ам

Тус сум нь 74295 хүн амтай, нийт хүн амын 53.1 хувь нь эмэгтэй, 46.9 хувийг эрэгтэй. Хөдөлмөрийн насны 49003 хүн байдгаас бүртгүүлсэн ажилгүй хүн 1577 байна.

Нийт ажиллагсадын 7.7 хувь нь төсөвт байгууллагад, 5.4 хувь нь төрийн өмчит үйлдвэрийн газар, 40.1 хувь нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид, 46.7 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг байна.

Үйлдвэрлэл үйлчилгээ

Сумын хэмжээнд 446 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдагаас хүнсний зах 2, барааны зах 1, кафе 21, бөөний худалдааны төв 1, хүнсний дэлгүүр 35, ТҮЦ 74, зочид буудал 30, мах боловсруулах үйлдвэр 2, нэхий боловсруулах үйлдвэр 2, төмөрлөгийн үйлдвэр 1, цементийн үйлдвэр 1, тоосгоны үйлдвэр 2, хүнсний үйлдвэр 1, гахайн мах, хиам үйлдвэрлэх цех 11, талх нарийн боовны цех 22, зайрмагны цех 19 ажилладаг байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ: УЛАМЖЛАЛТ БУС БА САЙЖРУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

3.1.1 Монгол улсын мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, зах зээл

“Хүн амын хоол тэжээлийн бодисуудын зөвлөмж хэмжээ”-гээр монгол хүн жилд 107 кг тураг мах хэрэглэвэл зохимжтой гэж зөвлөсөн байдаг. Статистик мэдээгээр манай улс жилдээ 6-8 сая толгой мал буюу 250 орчим мянган тн мах хүнсэнд хэрэглэж нэг хүнд 100-120 кг мах ногдож байна. Энэхүү тоо баримтаас үзэхэд манай улс мах махан бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг бүрэн хангаж байна.

Сүүлийн жилүүдэд мах боловсруулалтын техник технологийн хувьд олон улсын шаардлагыг хангахуйц 10 үйлдвэр шинээр ашиглалтад орсноор томоохон хот суурин газрын хүн амын хэрэгцээт махыг үйлдвэрийн аргаар боловсруулах хүчин чадалтай том жижиг 28 үйлдвэр ажиллаж байна.

Өнгөрсөн 3 жилд дундажаар 17.5 мянган тн мах экспортлов. Уламжлалт гадаад зах зээл болох ОХУ-аас гадна БНСУ, Иордан, Япон зэрэг оронд үхэр, адуу хонины мах экспортолж эхлээд байна. Экспортлосон нийт махны 70 хувь нь үхэр, 28 хувь нь адуу, 2 хувь нь хонины мах эзэлж байна.

Харин жилдээ дундажаар 0.2-1.3 мянган тн гахайн мах, гахайн өөх, махан нөөш, загас зэрэг бүтээгдэхүүнийг импортоор худалдан авдаг ажээ.

Манай оронд жил дараалан тохиолдсон ган зудын гамшгаас болж малын тоо толгой үлэмж хэмжээгээр хорогдож улс орны эдийн засагт багагүй хохирол учирч хөдөөгийн иргэд амьжиргааны эх үүсвэргүй болж хот суурин газруудад ихээхэн хэмжээгээр суурьшиж нийслэлийн хүн амын нягтралыг ихэсгэж байгаа нь нийслэлийн хүн амын махны хангамжид сөрөг нөлөө үзүүлж байна.

Хүснэгт 3.1

Махны нийт нөөц ба таваарын махны хэрэгцээ

	Нийт хүн ам	Жишмэл хүн	Нэг жишмэл хүний хэрэглэх норм кг	Бүгд хэрэгцээ мян тн	Нийт нөөц мян тн	экспортлох боломж мян тн
Улсын дүн	2504.7	2254.23	90	202.9	259.8	56.9

Монгол улсын хүн амын махны хэрэгцээ 202.9 мян тн мах хэрэгцээтэй байна. Махны хангамжийн түвшин 128.0 хувь байна.


3.1.2. Баянхонгор аймаг

Баянхонгор аймаг нь жилдээ дундажаар 4646.7 тонн мах үйлдвэрлэдэг ба 20000 толгой үхэр мах бэлтгэлд нийлүүлдэг. Эдгээр үхрийг Галуут, Эрдэнэцогт, Байдраг зэрэг хангайн 8 сумаас бэлтгэдэг. Гол худалдан авагч нь “Дорнын говь”, Мах импекс, Дархан мах экспо, В&С зэрэг компаниуд байдаг бөгөөд эдгээрийн брокерууд нь аймгийн төв болон сумуудад байдаг ажээ. Дорнын говь компани нь Сэлэнгэ аймагт өөрийн мах боловсруулах үйлдвэртэй. Баянхонгороос бэлтгэсэн үхрээ Сэлэнгэ аймаг хүртэл туувраар аваачаад Сэлэнгийн мах боловсруулах үйлдвэрт нядлаад экспортлодог. Энэ компани нь Дорноговь аймагт байдаг.

Дорнын говь ХХК нь нэг ээлжиндээ 400 бод, 2000 бог нядлах хүчин чадалтай 900 тн мах хадгалах складтай бол УБ мах импекс нь 400 бод, 4000 бог нядлах хүчин чадалтай 16000 тн мах хадгалах складтай, Дархан мах экспо 300 бод, 2000 бог нядлах, 3500 тн мах хадгалах складтай, Дархан –уул аймаг дахь В&С Монгол ХХК нь 300 бод, 150 бог нядлах, 1000 тн мах хадгалах складтай компаниуд байна.

Мах импортлогч нь ОХУ-ын Буриад улс бөгөөд 1кг мах 1,7\$- ийн үнэтэй байдаг байна.

Махны экспортын суваг нь



Зураг 3.1

Экспортын үнэ нь дотоодын зах зээлийн үнээс 13,3 хувиар өндөр байна. Экспортод голдуу сарлагийн мах гаргаж байгаа нь дотоодын зах зээл дээр сарлагийн махны эрэлт бага байдагтай холбоотой гэж экспортлогчид үздэг байна. Манай улсаас мах экспортлогчдын авдаг гол бүтээгдэхүүн нь адууны мах юм. Баянхонгор аймаг нь цаашдаа ямааны мах экспортлох боломжтой.

Мөн орон нутгийн хүн амын хэрэглээ болон мах бэлтгэлээс гадна Баянхонгор аймагт сүүлийн жилүүдэд маш олон алтны уурхай улирлын байдалтай ажиллаж байгаа нь махны эрэлтийг нэмэгдүүлж байна.

Судалгаанд оролцогсдын махны дундаж хэрэглээ аймгийн төвийнхэн 58.6 кг, сумын төв болон малчдын хэрэглээ 72.3 кг нэг хүн дундажаар 65,5 кг мах хэрэглэж байгааг

жишмэл хүнд шилжүүлбэл 72,7 кг мах болж байна. Энэ нь нормоос даруй 13,4 хувиар бага хэрэглэж байна.

Баянхонгор аймагт сүүлийн 3 жил дараалан малын үнэ өсч байгаа нь хэрэглэгчдийн хэрэглээнд зохих хэмжээгээр нөлөөлж байна.

Хүснэгт 3.2

Баянхонгор аймгийн малын үнэ /мян төг/

нэр	1999. XII	2000. XII	2001. XII	2002. XII	2003. XII
Ат/тэмээ	85,0	90,0	100,0	105,0	150,0
Морь	80,0	70,0	66,0	78,0	100,0
Эр үхэр	70,0	80,0	80,0	95,0	130,0
Үнээ	60,0	70,0	60,0	80,0	100,0
Эр хонь	16,0	18,0	22,0	24,0	32,0
Эмхонь	13,0	15,0	15,0	18,0	28,0
Эр ямаа	10,0	15,0	1,0	15,0	25,0
Эм ямаа	8,0	12,0	10,0	13,0	20,0

Бид зах зээлийн өнөөгийн байдлыг тодруулах зорилгоор дараахь асуулгаар судалгааг хийсэн болно.

БХ аймгийн хэрэглэгчид махаа хаанаас худалдан авдаг вэ?




график 3.1

Графикаас харахад 37 хувь нь өөрийн аж ахуйгаас, 63 хувь нь зах зээлээс эрэлтээ хангадаг байна. Хэрэглэгчид хэрэгцээнийхээ 20 хувийг аймгийн төвийн захаас, 4 хувийг Улаанбаатар хотын захаас, 15 хувийг дэлгүүрээс, 24 хувийг иргэдийн нийлүүлж буй бүтээгдэхүүнээр хангаж байна.

Худалдаж авсан мах таны хүсч буй чанарын шаардлагыг хангаж байна уу?

Судалгаанд оролцогсдын 68,5 хувь нь худалдаж авсан бүтээгдэхүүн чанартай гэж хариулсан бол 31,5 хувь нь дунд зэргийн чанартай гэж хариулжээ.

БХ аймгийн хэрэглэгчдийн худалдан авсан махны юу нь таны хэрэгцээг хангаж чадахгүй байна вэ?




график 3.2

Судалгаанд оролцсон хэрэглэгчдийн 77 хувь нь махны үнэ өндөр, 17хувь нь эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагын түвшин муу, 6 хувь нь чанар муу.

Баянхонгор аймаг дахь хонины махны үнэ




график 3.3

Графикаас харахад Баянхонгор аймаг дахь нэг кг хонины махны үнэ Улаанбаатар хотынхоос 20.6 хувиар хямд, харин хөрш зэргэлдээ Өвөрхангай аймгийнхаас 14.9 хувиар өндөр байна.

Мөн тэд хүнсний зах дээрээс мах худалдан авах маш их эрсдэлтэй гэж хариулсан. Учир нь малчид болон үйлдвэрлэгчид өвдсөн болон үхсэн малын махыг борлуулдаг. Тэд нарыг хянах хяналтын систем хангалтгүй байна.

Хөдөөгийн хэрэглэгчид хүнсэндээ худалдан авсан буюу бэлтгэсэн махныхаа 50-70 орчим хувиар борц хийдэг. Энэ нь 5дугаар сараас 9 сар хүртлэх хугацаанд хэрэглэдэг байна. Харин аймгийн төвийн хэрэглэгч борц хэрэглэх нь харьцангуй бага.

Хэрэглэгчид мах худалдан авахдаа хамгийн их анхаардаг зүйл бол чанарын асуудал гэж судалгаанд оролцогсдын 85,3 хувь хариулж байсан.

БХ аймгийнхан цаашдаа мах бэлтгэлд юуг өөрчлөн сайжруулах хэрэгтэй вэ?




график 3.4

Графикаас харахад хэрэглэгчдийн 58 хувь нь махны эрүүл ахуйн шаардлагыг сайжруулах хэрэгтэй, 20 хувь нь баталгаатай жин хэмжүүртэй болгох, 13 хувь нь сав баглаатай болгох, 7 хувь хагас боловсруулалт хийх, 2 хувь нь махыг үе мөчлөн зарах хэрэгтэй гэж хариулжээ.

Хэрэглэгчдийн хамгийн их санаа зовж буй асуудал бол махны эрүүл ахуй ариун цэврийн шаардлага юм. Иймд мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах, малыг эрүүлжүүлэх асуудал хамгийн чухал асуудал юм.

Таны өрхийн орлого хэрэгцээнд шаардлагатай махыг авч чадаж байна уу?

Судалгаанд оролцогсдын 70.4 хувь нь өөрийн хэрэгцээгээрээ махаа худалдан авдаг байхад, 29.6 хувь нь хэрэгцээгээ хангаж чадахгүй байна гэж хариулсан Үүний гол шалтгаан нь:

1. Орлого багатай
2. Мах өндөр үнэтэй зэрэгтэй холбож тайлбарласан.

Та өөрт шаардлагатай байгаа махаа худалдаж авч чадаж байна уу?

Судалгаанд оролцогсдын 55.5 хувь нь өөрийн худалдан авах чадвараа харж байгаад л махаа авдаг гэсэн бол 44.5 хувь өөрийн хэрэгцээгээр авдаг гэж хариулсан нь хүн амын амьжиргааны түвшин доогуур байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл хэрэглэгчид хэрэгцээт махаа хэрэглэж чадахгүй байна.

Та малчдын бүлгийн үйлдвэрлэх сайжруулсан буюу уламжлалт бус мах худалдан авах уу?

Оролцогчдын 68.8 хувь нь авна гэсэн бол 31.2 хувь нь авахгүй гэж байна. Авахгүй гэж хариулсан нь малчид буюу мал бүхий иргэд өөрийн аж ахуйгаасаа бэлтгэдэгтэй холбоотой юм.

Баянхонгор аймгийн хэрэглэгчид ямар шаардлага хангасан мах худалдан авах вэ?




график 3.5

Графикаас харахад судалгаанд оролцогсдын 37хувь нь чанартай байх ёстой, 29 хувь эрүүл ахуйн шаардлага хангасан байх, 24 хувь сав баглаа боодолтой болгох, 10 хувь одоогийн байгаа байдлаар нь гэж хариулжээ. Эдгээрээс хамгийн их хөрөнгө зарцуулах нь сав баглаа боодлын асуудал юм. Харин малчид тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хийх сонирхолгүй байгаа нь ажиглагдаж байсан. Учир нь савтай ч савгүй ч адилхан үнээр борлогдох учраас гэж тэд хариулж байсан.

Баянхонгор аймгийн хэрэглэгчид цаашдаа хаанаас мах худалдан авах вэ ?




график 3.6

Судалгаанд оролцогсдын 43 хувь нь аймаг, сумын төвд махны нэрийн дэлгүүр байх, 37 хувь малчдад захиалгаар авах, 11 хувь нь одоогийн байдлаар, 9 хувь нь ямарч байж болно гэж хариулсан байна. Нийт хэрэглэгчдийн хүсч буй гол зүйл бол сум орон нутагт тухайн бараа бүтээгдэхүүний нэрийн дэлгүүр, аймгийн төв дээр сумын нэрийн барааны дэлгүүр байх нь зайлшгүй гэж хариулж байсан.

Үүний гол шалтгаан нь:

1. Өнөөдрийн махны борлуулалтын суваг нь хэд хэдэн үе шат дамжиж байгаа учраас үнэ нь хэтэрхий өндөр байна
2. Нэгэнт албан ёсны бэлтгэн нийлүүлэгч байхгүй учраас чанарын асуудал маш хангалтгүй байна
3. Суманд хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг борлуулдаг цэг дэлгүүр байхгүй учраас хэрэглэгчийн хэрэгцээ, үйлдвэрлэгчийн нийлүүлэх гэсэн хүслийн аль аль нь хангагдахгүй байна.

Зуны улиралд ганц хонь, ямаа нядлаад зарах гэхээр зарах газар олдохгүй хэцүү шүү дээ.

Баянхонгор аймгийн Жинст сумын малчин өвгөний ярианаас

4. Үйлдвэрлэгчид чанарт анхаарахгүй зэргийг дурдаж болох юм.

Хүнсний зах дээр махны борлуулалт хамгийн сайн байдаг улирал нь хавар, зуны улирал байхад хамгийн бага нь өвлийн улирал байдаг байна. Хамгийн эрэлттэй үедээ өдөрт дундажаар аймгийн хүнсний зах дээр 4,8 тн орчим мах борлогддог байхад хамгийн бага өвлийн улирал 1,2 тн орчим мах борлогддог ажээ. Аймгийн хүнсний зах дээр мах борлуулдаг 40-50 орчим хүн ажилладаг ба эдгээр хүмүүсийн сарын эргэлтийн хөрөнгө нь 0,2-2,5 сая төгрөгтэй байдаг байна. 2,5 сая түүнээс дээш эргэлтийн хөрөнгөтэй хүмүүс нь бөөний худалдаачин буюу ченжийн үүрэг гүйцэтгэдэг байхад багахан хэмжээний хөрөнгөтэй нь борлуулагчийн үүрэг гүйцэтгэнэ.

3.1.3. Өвөрхангай аймаг

Өвөрхангай аймаг жилдээ 11283.9 тн мах үйлдвэрлэх бололцоотой бөгөөд харин хүн амын мах махан бүтээгдэхүүний хэрэгцээ нь 8787.6 тн болж хэрэгцээнээс 2496.3 тн мах илүү үйлдвэрлэгдэх боломжтой бөгөөд үүнийг рашаан сувилал, жуулчин, цэргийн байгууллага болон Улаанбаатар хотын зах зээлд нийлүүлж байгаа юм. Мөн Баянхонгор, Говь-Алтай аймгийн зах зээлд борлуулдаг байна. Аймгийн төв, Хужирт, Төгрөг суманд махны үнэ Улаанбаатар хотынхоос 10-15 хувиар, харин Сант суманд 20-25 хувиар хямд байдаг байна.

Хужирт суманд үйл ажиллагаа явуулдаг жуулчны бааз, рашаан сувиллын хэрэгцээг оруулан тооцвол махыг өөр сум, аймаг руу худалдах шаардлага үгүй байна. Гэхдээ эдгээр байгууллага нь өвлийн улиралд эрэлт багатай байдаг, Улаанбаатарын зах зээлээс махан бүтээгдэхүүнээр хэсэгчлэн хангагддаг зэргээс шалтгаалан өвлийн улиралд Улаанбаатар хот болон төвлөрсөн зах зээлд махаа нийлүүлдэг. Өвөрхангай аймагт мах боловсруулах үйлдвэр байхгүй тул хиам, утсан мах, нөөш зэрэг боловсруулалт хийсэн бүтээгдэхүүнийг Улаанбаатарын зах зээлээс голлон худалдаж авдаг байна. Говийн сумдын хэрэглэгчид нь тэмээний ба ямааны мах хүнсэндээ илүү хэрэглэж байхад хангайн сумын хэрэглэгчид үхрийн мах илүү хэрэглэдэг ажээ.

Өвөрхангай аймгийн хэрэглэгчид махаа хаанаас худалдан авдаг вэ?

Хүснэгт 3.3

Хувь	Өөрийн аж ахуйгаас	Аймгийн зах дээрээс	Орон нутгийн иргэдээс	Улаанбаатар хотоос
100.0	45.9	25.3	24.5	4.3

Судалгаанд хамрагсадын 45.9 хувь нь өөрийн аж ахуйгаас, 25.3 хувь нь аймгийн зах дээрээс, 24.5 хувь нь орон нутгийн иргэдээс худалдан авдаг, 4.3 хувь нь УБ хотоос тээвэрлэн ирж хэрэгцээгээ хангадаг гэжээ.

Аймгийн төвийн ойролцоо сумын иргэдийн олонхи нь хэрэглээний махаа аймгийн төвийн захаас авах явдал гардаг байна.

Манай суманд малчид малаа өсгөнө гээд сүүлийн жилүүдэд зарахгүй, авна гэхээр өндөр үнэ хэлдэг болсон. Тэмээнээс бусад төрлийн мах аймгийн захынхтай ижил, хавартаа бүр илүү байдаг болсон. Ер нь махны үнэ хэт өндөр байгаа нь бусад хэрэглээнд нөлөөлж байна.

Төгрөг сумын сургуулийн багш Батаа

Энэ нь нэг өрхөд ноогдох малын тоо цөөн, малчдын орлого сүүлийн жилүүдэд буурсан, малын тоо толгойгоо өсгөх сонирхол өндөр байгаатай холбоотой.

Таны худалдан авч байгаа мах чанарын шаардлага хангаж байна уу?

Махны чанар, хэрэгцээ хангаж буй байдлын талаар хэрэглэгчид үнэлэхдээ 95.6 хувь нь чанартай, 4.4 хувь нь дунд зэрэг гээд махны чанарыг хэрэглээний шаардлагад тохируулан их өөхтэй биш харин өөх, мах нь жигд алагласан, гол нь булчингийн хөгжил сайтай, мах зузаантай болгох чиглэлээр үржил, тэжээлийн ажлыг өөрчлөх, эрүүл ахуй, ариун цэврийн нөхцлийг орон нутагт мөрдүүлэн малыг эрүүлжүүлэх арга хэмжээ авах талаар энэ чиглэлээр ярилцлага өгөгсдийн 25 хувь нь саналаа илэрхийлсэн байна.

Та гахай, тахианы мах, махан бүтээгдэхүүн худалдан авах уу?

Гахайн мах хэрэглэхийг хүсч байгаагаа судалгаанд оролцогсдын 9 орчим хувь буюу 8 хүн илэрхийлсэн бөгөөд тэдний дундаж хэрэглээ жилд 3-8 кг байдаг байна. Хэрэглээ бага байгаа нь уг бүтээгдэхүүн орон нутагт тэр бүр байдаггүй, тэгээд ч тэр хэрэглэж заншаагүйтэй холбоотой байна. Гэхдээ гол төлөв бүрэн боловсруулсан байдлаар дэлгүүрээс авч хэрэглэдэг байна. Тахианы мах орон нутагт маш бага хэрэглэдэг бөгөөд жилд нэг хүн 1.5-2 кг орчмыг хэрэглэдэг талаар мэдээлэл өгсөн болно.

Харин тахианы өндөг жилд 45-480 ширхэгийг нэг өрх жилд хэрэглэдэг бөгөөд өндөг хэрэглэх сонирхол сум, аймгийн төвд нэлээд өндөр байна.

Хүнсэндээ өндөг хэрэглэх сонирхолтой. Манай аймгийн төвийн хүнсний зах дээр зарагдаж буй өндөг хэзээ, хаанаас ирсэн нь тодорхой бус. Иймд бараг хэрэглэж чадахгүй байна. Учир нь өндөг бол маш эмзэг бүтээгдэхүүн

Сант сумын бага ангийн багш эмэгтэй

Өндгийг хувьдаа тахиатай зарим хүн цөөн тоогоор худалддаг байна. Тухайлбал Төгрөг, Хужирт суманд аминдаа тахиатай 2 өрх байгаа юм. Тэд өндөг авах чиглэлээр тахиа өсгөж байгаа ба махны үйлдвэрлэл эрхлээгүй байна. Худалдаа эрхлэгч нар аймаг, хилийн боомтоос орос, хятад өндөг авчирч борлуулдаг байна. Хүмүүс орос, монгол гаралтай өндгийг илүүтэй хэрэглэх сонирхолтой байна.

Мах, махан бүтээгдэхүүнийг сайжруулах шаардлага байгаа эсэх?

Махан бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг дээшлүүлэх эрэлт хэрэгцээ үнийн ялгаатай байдлыг харгалзан гулууз махыг мөчилж эвдэх, чанарын байдлаар нь (гол мах, нурууны мах, гуяны мах, хүзүү, дал, сээр г.м) ангилан төрөлжүүлж сав, баглаатай болгох, зузаан махтай хэсгүүдийг шулж шулдас хийх, махыг хоол, хүнсэнд шууд хэрэглэх маягаар

хэсэглэн жижиглэх, 2-4, 4-6 хүний хэрэгцээнд зориулсан хорхогны иж бүрдэл бэлтгэх гэх мэтээр санал бодлоо илэрхийлсэн байна.

Махан бүтээгдэхүүний тодорхой төрлийн нэг болох борцыг судалгаанд хамрагдсан хүмүүс бүгд хэрэглэдэг байна.

Хэрэглэгчдийн саналаа илэрхийлснээр хамгийн сайн гэж үздэг нь үхэр, ямааны махан борц байдаг байна. Борцны хэрэглээний талаар саналаа илэрхийлсэн 10 хүний 5 нь үхрийн, 3 нь ямааны борц хэрэглэдэг бөгөөд цаашид ч хэрэглэх сонирхолтойгоо дурдсан байна.

Харин борцыг цаашид хэрэглэх сонирхолгүй гэдгээ 1 хүн илэрхийлсэн байна. Борц хэрэглэгчдийн 90 хувь нь түүний боловсруулалт хангалтгүй байгаа тухай ярьсан байна. Борцны чанар сайнгүй байдаг нь шороо тоос ихтэй байдаг, өөх ихтэйгээс хуршсан байдагтай холбоотой байдаг байна. Борцны чанар, боловсруулалтыг шаардлагын түвшинд хүргэхийн тулд өөх хальс багатай махыг сонгох, өвөл эрт борцолж бүрэн хатаах, шороо, тоосноос хамгаалах, нүдэж жижиглэн хэрэглээнд тохируулан бага багаар савлах хэрэгтэй талаар саналаа илэрхийлсэн байна.

Малын цусыг дотор махтай нь хольж хярамцаг болгон хэрэглэн хатаах буюу хуурах технологиор боловсруулж өөрсдөө хүнсэнд хэрэглэдэг болон цаашид хэрэглэх сонирхолтойгоо 2 хэрэглэгч илэрхийлсэн байна. Ер нь малын цусыг боловсруулж хүнсэнд хэрэглэх нь хангалттай бус ялангуяа үхэр, адууны цусны ашиглалт муу байдаг байна.

Хиамыг хэрэглэгчид гол төлөв бага хэмжээгээр буюу жилд нэг өрх 6-24 кг -ыг хэргэлдэг бөгөөд хамгийн их хэрэглээ нь баяр ёслолын буюу 12, 3 7 дугаар сард байдаг байна. Утсан гахайн махыг зөвхөн ресторан, жуулчны бааз л хэрэглэдэг байна.

3.1.4. Сэлэнгэ аймаг

Сэлэнгэ аймаг жилд дундажаар 4454.3 тн мах үйлдвэрлэдэг байна.

Сэлэнгэ аймгийн мах үйлдвэрлэлийг бүтэц




график 3.7

Нийт махны 14.7хувь буюу 656.7 тн адууны мах, 48.1хувь буюу 2143.4 тн үхрийн мах, 22.2хувь буюу 989.2 тн хонины мах, 12.4 хувь буюу 551.4 тн ямааны мах, 2.6хувь буюу 113.8 тн гахайн мах үйлдвэрлэж байна.

Хүн амын махны хэрэгцээ ба зах зээлийн өнөөгийн төлөв байдлыг тодорхойлохын тулд дараахь асуулгаар судалгааг явуулсан болно.

Сэлэнгэ аймгийн нэг өрх жилдээ хэдэн төгрөгийг мах авахад зарцуулдаг вэ?




график 3.8

Судалгаанд оролцогсдын 53 хувь 100-аас дээш мянган төгрөгийн, 34 хувь нь 100 хүртлэх мянган төгрөгийн, 13 хувь нь 20-50.0 мянган төгрөгийн зарцуулдаг гэж хариулжээ. Улсын дундажаар өрхийн нэг сарын махны хэрэглээнд 12650 төгрөгийг зарцуулдагтай харьцуулан үзэхэд ойролцоо гарч байсан.

Сэлэнгэ аймгийн хэрэглэгчид ямар төрлийн мах, махан бүтээгдэхүүн хэрэглэдэг вэ?




график 3.9

Хүнсэндээ хэрэглэж буй нийт махны 99.2 хувь малын мах, 0.5хувь нь гахайн мах, 0.3хувь тахианы мах хэрэглэдэг гэж хариулсан байдал нь Дархан болон Сэлэнгэ аймаг нь гахай болон тахианы аж ахуйн эрхэлдэг байсан нь хүн амын хэрэглээнд зохих өөрчлөлтийг бий болгосон. Тэд гахайн махыг утах буюу хиаман хэлбэрээр хэрэглэдэг байна. Дархан-Уул,

Сэлэнгэ аймагт мах боловсруулах үйлдвэрүүд ажиллаж байгаа учраас хиама буюу утах хэлбэрээр дахин боловсруулалт хийх боломжтой юм.

Та хүнсний махаа хаанаас авдаг вэ?

Дархан Уул аймгийн хэрэглэгчдийн 82.3 хувь нь хүнсний зах дээрээс, 7.3 хувь нь өөрийн аж ахуйгаас 10.4 хувь нь Улаанбаатар хотоос авдаг гэж хариулж байсан болно. Энэ нь зам харилцаа сайн хөгжсөнтэй холбон тайлбарлаж болох юм.

Харин Сэлэнгэ аймгийн Баянгол, Мандал, Жавхлант сумдын хэрэглэгчдийн дийлэнх нь Дархан хотын хүнсний зах, УБ хотын зах, сумын зах дээрээс ихэнх хэрэглээгээ хангадаг байна. Тухайлбал Мандал сумын хүнсний захад ажиллаж байгаа мах борлуулагч нар өөрийн сумын малчид болон хөрш зэргэлдээ сумдаас амьд мал худалдан авах, УБ хотын "Хүчит Шонхор" хүнсний захаас төрөл бүрийн малын гулууз мах бөөний үнээр худалдан авч тус сумын хүнсний зах дээр үнийг нь 20-30 хувь нэмж борлуулах зэргээр хангаж байна. Тус сумын зарим иргэд УБ хотын хүнсний захаас өвлийн идэшний махаа бэлтгэдэг.

Гэтэл Дархан-уул аймагт Дархан мах-экспо ХК, Монгол В&Ц ХХК гэсэн 2 мах боловсруулах үйлдвэр үйл ажиллагаа явуулж үйлдвэрлэсэн мах, махан бүтээгдэхүүнийг 100хувь ОХУ, Солонгос улсад экспортонд гаргадаг учраас хүн амын махны хэрэгцээнд нийлүүлэлт хийхгүй байгаа болно.

Тус сумын хүн амын махны хэрэглээг дараах байдлаар хангаж байна.

1. Хүнсний төрөлжсөн 2 зах дээрх бөөний болон жижиглэнгийн үнээр мах борлуулагч нар Сэлэнгэ, Булган, Хөвсгөл, Архангай аймгаас орж ирсэн малын махыг бөөний үнээр авч УБ хотын "Хүчит шонхор" хүнсний захын 1 кг махны үнээс 5-15хувь өндөр үнээр борлуулан хангадаг.
2. Гэр хороолол болон төвөөс алслагдсан хүнсний дэлгүүрүүд хүнсний төрөлжсөн захуудын мах борлуулагч нараас бөөний үнээр худалдан авч 5-10хувь үнэ нэмж борлуулан хангадаг болно.
3. Тус хотын хүн амын 5-10 хувь нь өөрийн хамаатан садан, өрхийн аж ахуйгаас махны эрэлт хэрэглээгээ хангадаг.

Сэлэнгэ аймгийн нэг онцлог нь гахай ба тахианы мах үйлдвэрлэдэг нь хэрэглэгчид хэрэглэх сонирхолтой, боловсруулах аж үйлдвэрүүд байгаа учраас энэ талын судалгааг арай илүү түлхүү хийсэн болно.

Сэлэнгэ аймгийн гахайны мах ба өндөг үйлдвэрлэл




график 3.10

2004 онд Сэлэнгэ аймаг гахайн мах 113.6 тн, өндөг 1029.3 мян ширхэгийг үйлдвэрлэсэн байна.

Сэлэнгэ аймгийнхан жилдээ гахайн утсан маханд хэдэн төгрөгийг зарцуулдаг вэ?




график 3.11

Судалгаанд оролцсон хэрэглэгчдийн 70 хувь нь 100.0 мянгаас дээш төгрөгийн, 4 хувь нь 50-100.0 мянган төгрөгийн, 18 хувь 20-50.0 мянган төгрөгийн, 8 хувь нь 20 хүртлэх мянган төгрөгийн зарцуулдаг гэж хариулсан байна.

Хэрэглэгчид гахайн утсан махны боловсруулалтын талаар үнэлгээг дунд зэрэг гээд, гахайн утсан махыг боловсруулахдаа маш сайн амталж боловсруулах хэрэгтэй гэж хариулсан байна.

Та гахайн мах, махан бүтээгдэхүүн хаанаас авдаг вэ?

Оролцогчдын 60 хувь нь гахайн утсан махыг бөөний худалдааны үйл ажиллагаа явуулж байгаа төвүүд, 40 хувь нь хүнсний зооноос авдаг гэж хариулсан байна.

Өндөг болон тахианы маханд жилдээ хэдэн төгрөгийн зарцуулдаг вэ?

Судалгаанд оролцогчдын 98 хувь нь 20.0-50.0 хүртлэх мянган төгрөгийн зарцуулдаг, 88.5 хувь нь өндгийг жилийн 4 улиралд байнга хэрэглэдэг гэж хариулсан байна. Тэд өндгийг худалдан авахдаа гарал үүслийг маш сайн анхаардаг байна.

Дархан хот болон бусад сумын хэрэглэгчид маш их хэрэглэдэг бүтээгдэхүүн болсон байна. Манай улс өндөгний хэрэглээнийхээ 79.4 хувийг импортоор, 20.6 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангадаг байна.

2002-2004 оны өндөгний үнэ / төгрөгөөр/




график 3.12

Графикаас харахад өндөгний үнэ тогтвортой байна. Хэрэглэгчид үнийг хэвийн боломжийн гэж хариулсан байна.

Тахианы өндгийг хаанаас худалдан авдаг вэ?




график 3.13

Графикаас харахад хэрэглэгчдийн 66 хувь аймгийн зах дээрээс, 32 хувь нь сумын зах дээрээс, 2 хувь таньдаг хүнээсээ авдаг байна.

Худалдан авсан өндөгнийхөө чанарыг та ямар гэж үнэлж байна вэ?

Өндөгний чанар хэр зэрэг байна вэ гэсэн асуултанд тэд хариулахдаа 100 хувь дунд зэрэг гэж хариулсан.

Цаашдаа малчдын бүлгийн үйлдвэрлэсэн өндгийг худалдан авах үү, авах бол ямар шаардлага хангасан байх ёстой вэ?, борлуулалтын ямар сувгаар худалдан авах вэ?

Оролцогчдын 100 хувь нь худалдан авна, 100 хувь чанартай, баталгаат хугацаандаа буюу шинээр нь борлуулах, борлуулахдаа 100 хувь захиалгаар худалдан авна гэж хариулсан байна. Өндөг бол эмзэг бүтээгдэхүүн учир хэрэглэгчид их болгоомжилдаг байна гэдгийг харж болох юм.

Тахианы мах

Тахианы махны хувьд хэрэглэгчид нэгэнт хэрэгцээ хангах нийлүүлэлт байхгүй учраас эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнийг худалдан авахад бэлэн байна гэж хариулж байсан. Өнөөдөр тэд тахианы махны эрүүл ахуйн шаардлага хангасан эсэхэд маш их эргэлздэг байна. Учир нь хэрэглэж буй бүтээгдэхүүн хаана үйлдвэрлэсэн нь тодорхой бус байдаг, тэд БНХАУ-аас импортоор орж ирсэн тахианы гуя л гэж боддог байна. Иргэдийн хэрэглээнээс гадна Дархан хотын нь зоогийн газар, кафе, ресторан, үйлдвэрийн газрууд тахианы мах, өндөгийг хамгийн их хэмжээгээр худалдан авдаг байна.

Аймгийн хэмжээнд 5570 тахиа тоологдсон байдаг боловч хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээний 15-20 хувийг сумын үйлдвэрлэлээр, 80-85 хувийг УБ хот болон бусад зах зээлээс хангаж байгаа гэсэн мэдээлэл байна.

Хэрэглэгчдийн эрэлт, нийлүүлэлтийн цоорхойг дараах байдлаар хангаж байна.

1. Хүнсний төрөлжсөн зах дээрх жижиглэнгийн худалдаачид ОХУ-аас болон бусад аймгаас тахианы мах, өндөг нийлүүлэх замаар хангаж байна. Захууд дээр борлуулж байгаа өндөгний 40хувийг Оросын холбооны улсаас оруулж ирдэг, үлдсэн 40хувийг УБ хот, 20хувийг орон нутгаас нийлүүлдэг гэж мэдээлэл өгч байсан болно.
2. Номин худалдааны төв болон бусад хүнсний дэлгүүрүүд импортлогч нараас дээрх бүтээгдэхүүнийг татаж аван хэрэглэгчдийн хэрэгцээг хангадаг.
3. Дархан хотын зоогийн газар , кафе, рестораны үйл ажиллагаа эрхлэгчид хэрэгцээт тахианы махыг Улаанбаатар хотын хүнсний захаас худалдан авч үйлдвэрлэл явуулдаг.

3.2 Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, зах зээл

3.2.1. Монгол улсын сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Монголчууд бид аливаа нандин, цэвэр ариун бүхнээ сүүтэй зүйрлэн билэгдэж байдаг нь юугаар ч орлуулшгүй үнэт чанарыг зуун зуун жилээр бишрэн хүндэтгэж ирсэний баталгаа билээ.

Бид түүхэн хөгжлийнхээ бүхий л үед мал аж ахуй эрхэлж таван хошуу малынхаа сүүгээр 30 гаруй нэрийн цагаан идээ бэлтгэж, өдөр тутмын хүнсэндээ хэрэглэхийн зэрэгцээ зохих хэмжээгээр нөөцөлж өвөл хаврын улиралд ашиглаж ирсэн уламжлалтай.

Гэтэл сүүлийн жилүүдэд малын тоо 2000 онд 30227.5 мянган толгой, 2002 онд 23897.6 мянган толгой, 2004 онд 27966.8 мянган толгой болж нийт дүнгээрээ өсч байгаа боловч сүү цагаан идээний үйлдвэрлэл буурсаар байна.

Үүний гол шалтгаан нь 1) хөдөө орон нутагт саалинд хамрагдах ёстой мал бүрэн хамруулахгүй 2) арвин ашиг шимт малын тоо толгой буурсан 3) ган, зуд болсны уршгаар сүүний гарц буурсан 4) сүү цагаан идээг бэлтгэж байсан систем нь алдагдсан зэрэг хүчин зүйлтэй холбоотой юм.

Улсын хэмжээний сүүний нөөц /мян.л/

Хүснэгт 3.4

Малын төрөл	Төлтэй малын тоо	Саалинд хамрагдах малын тоо	Нэг малаас саах сүү	Бүгд сүүний нөөц
Ингэ	31.7	24.1	300	7230.0
Гүү	306.3	137.8	250	34450.0
Үнээ	512.8	435.9	450	248155
Эм хонь	3761.0	1692.5	8	13539.6
Эм ямаа	3273.7	1558.3	10	15583
Бүгд				318957.6

Манай улс жилдээ 318.9 сая литр сүү саах нөөцтэй байтал жилдээ 290.0 сая орчим литр сүү сааж, нэг хүнд дундажаар 117.4 литр сүү оногддог байна.

1990 оноос өмнөх 30 жилд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг томоохон хот, суурин газрын хүн амын сүү цагаан идээний хэрэгцээг хангах зорилгоор жилдээ 54.4 сая литр сүү бэлтгэх хүчин чадалтай саалийн механикжсан цогцолбор 41-ийг барьж ашиглалтанд оруулж, нэг үнээнээс жилд 2500-аас дээш сүү сааж байсан бөгөөд энэ нь үйлдвэрийн аргаар сүү, цагаан идээ бэлтгэхэд чиглэгдсэн маш чухал алхам байлаа.

Гэвч зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойшхи хугацаанд саалийн механикжсан фермүүдийн хэвийн ажиллагаа алдагдаж, төвлөрсөн хэрэгцээнд нийлүүлсэн сүүний хэмжээ 1990 онд 61.5 мян тн байсан бол 1995-2000 онуудад 1.1-1.5 мянган тн хүртэл буурч 2001 оноос үйлдвэрлэл аажмаар өсч сүү цагаан идээ боловсруулах жижиг дунд үйлдвэрийн тоо 1999 оныхоос 2 дахин нэмэгдэв. 2003 онд 5.4 мян тн сүү нийлүүлсэн байна. Нөгөө талаар цөцгийн тос үйлдвэрлэж байсан тогтолцоо ч алдагдсан. 1985 онд 4317.6 тн, 1994 онд 500 тн , 2004 онд 1.9 тн-ийг үйлдвэрлэж үндсэндээ үйлдвэрлэл нь зогссон байна.

Монгол Улсын хүн амын сүү, цөцгийн тосны хэрэгцээ

Хүснэгт 3.5

	Бүт. төрөл	Жишмэл дундаж хүний хоногт хэрэглэх хэмжээ /гр/	Жилийн нийт хоногт хэрэглэх хэмжээ /кг/	Хүн амын тоо /мян. хүн/	Жишмэл хүн /мян.хү/	1 хоногийн хэрэгцээ /тн/	Жилийн хэрэгцээ /мян.тн/
Улсын нийт хэмжээгээр	Цагаан идээ	380	138.7	2504	2253.6	856.4	312.6
	Цөцгийн тос	27	9.855	2504	2253.6	60.8	22.2
Үүнээс УБ хот	Цагаан идээ	380	138.7	893.4	804.06	305.5	1115.5
	Цөцгийн тос	27	9.855	893.4	804.06	21.7	7.9

Манай улсын хүн амын сүү цагаан идээний хэрэглээний нормоор тооцож үзэхэд улсын хэмжээгээр жилдээ 312.6 мян. тн сүү, сүүн бүтээгдэхүүн, 22.2 мян тн цөцгийн тос, зөвхөн

Улаанбаатар хотод 111.5 мян. тн сүү, сүүн бүтээгдэхүүн, 7.9 мян тн цөцгийн тосны хэрэгцээ байна.

Хэрэгцээг нөөцтэй харьцуулан үзэхэд зөвхөн хүн амын сүүн сүүн бүтээгдэхүүний хэрэгцээг 85.4 хувийг л хангах нөөц байна. Сүүлийн жилүүдэд үйлдвэрлэсэн сүү, цагаан идээ, цөцгийн тосны хэмжээ багассанаар импортоор орж ирэх сүү цагаан идээний хэмжээ нэмэгдсээр байна.

Импортын сүү, цагаан идээ /2000-2003/

Хүснэгт 3.6

Бүтээгдэхүүний төрөл	2000	2001	2002	2003
шингэн сүү	2322.6	4420.4	5769.5	5258.7
Өтгөрүүлсэн сүү	707.7	1875.4	1876.9	2182.2
хуурай сүү	345.6	1385.1	835.2	967.8
тараг цагаан идээ	130.3	293.4	467.4	265.7
Цөцгийн тос	54.9	62.4	18.6	34.1
бяслаг аарцан бүтээгдэхүүн	11.3	159.9	18.7	110
Нийт дүн	3572.4	8196.6	8986.3	8818.5

Импортоор авсан сүү, цагаан идээ




график 3.14

Дээрх хүснэгт болон графикаас харахад импортоор орж ирж буй сүү цагаан идээний хэмжээ жилээс жилд өсч байна. Эдгээр бүтээгдэхүүнийг сүүнд шилжүүлэн тооцоход 50 сая литр сүү болж байгаа юм. Нийт сүү, цагаан идээний импортын 59.6 хувь нь шингэн сүү, 24.7 хувь нь өтгөрүүлсэн сүү, 10.9 хувийг хуурай сүү эзэлж байгаа нь импортын 95.2 хувийг зөвхөн сүү эзэлж байна.

2003 оны эцсийн байдлаар манай улсад сүү боловсруулах 40 үйлдвэр, цагаан идээний 22 үйлдвэр, зайрмагийн 273 үйлдвэрүүд үйл ажиллагаа явуулж байна. Улаанбаатар хотод сүү боловсруулах 7, цагаан идээний 7, зайрмагийн 163 үйлдвэр ажиллаж, өдөртөө дундажаар 15.0 тн сүү боловсруулж, ариутгасан сүү, төрөл бүрийн тараг, зөөхий аарц, ааруул

зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулж буй нь нийслэлийн зах зээлийн 20 орчим хувийг эзэлж байна.

3.2.2. Баянхонгор аймаг

Баянхонгор аймаг жилдээ дундажаар 2.7 мянган тн сүү саадаг ба суурин газрын нэг хэрэглэгчдэд 35,56 кг, хөдөөгийн хэрэглэгч 60,3 кг ногдож байна. Баянхонгор аймгийн малчдын сүүгээ борлуулдаг гол зах зээл нь аймгийн төв байдаг. Шингэн ба хөлдүү сүүний ихэнх хэсгийг Эрдэнэцогт, Галуут сумын малчид нийлүүлдэг. Зуны улиралд Эрдэнэцогт сумын малчид, иргэд өөрсдөө аймгийн төвд хүргэж борлуулдаг. Тээврийн гол хэрэгсэл нь мотоцикль, УАЗ-452 машин. Малчид хамтран сүүгээ зах зээлд хүргэж, хүнсний зах дээр буюу байнгын хэрэглэгч нартаа борлуулдаг. Харин Богд, Жинст сумын малчид намар, өвлийн улиралд багахан хэмжээний ямааны ба ингэний ааруулыг аймгийн төвийн зах дээр борлуулна. Бид судалгааг дараахь асуулгаар явуулсан болно.

Баянхонгор аймгийн нэг өрх жилдээ хэдэн төгрөгийг зөвхөн сүүнд зарцуулдаг вэ?




график 3.15

Графикаас харахад судалгаанд хамрагсдын 43 хувь 20 мянга хүртэл төгрөг, 18 хувь нь 20-50.0 мян төгрөг, 17 хувь нь 50-100 мян төгрөг, 22 хувь нь 100-аас дээш мянган төгрөг зарцуулдаг гэж хариулсан нь өрхийн нийт хүнсэнд зарцуулсан зардлын 4.3-21.7 хувийг эзэлж байна.

Та сүү худалдан авахдаа худалдан авах чадвар, эсвэл хэрэгцээний хэмжээгээр худалдан авдаг уу?

Судалгаанд хамрагсдын 57 хувь нь өөрийнхээ худалдан авах чадвараар сүүг худалдан авдаг, 43 хувь нь хэрэгцээгээр худалдан авдаг гэж хариулсан нь хүн амын амьжиргааны түвшин доогуур байгаа учир тэд хэрэгцээт сүүгээ худалдан авч чадахгүй байна гэсэн үг юм. Энэ нийт хэрэглээний 31,5-53,4 хувийг л хэрэглэж байна гэсэн үг юм.

Хүн амын хэрэглээнээс гадна аймгийн төв дээр ресторан-2, кафе-11, бар-2 гуанз-28, ажилчдын цайны газар 49, сургуулийн дотуур байр-1, хүүхдийн цэцэрлэг ясли 5, хүн эмнэлэг 4, гал тогоо бүхий 102 газар, харин хөдөө сум болгонд -3 харин Баянлиг суманд цэргийн 1 гал тогоо бүхий газар ажиллаж байна. Эдгээр нь өдөрт дундажаар 3 –5 литр сүүг худалдан авдаг гэвэл өдөртөө 652 литр сүүний хэрэгцээ байна.

Хөдөө сумын цэцэрлэг ясли, хүн эмнэлэг нь Улаанбаатар хотын зах дээрээс хуурай сүү авч хэрэглэдэг байна. Энэ нь дараахь шалтгаантай холбоотой.

1. Цэцэрлэг яслийн ажилладаг хугацаа нь 9 дүгээр сараас дараа оны 6 дугаар сар хүртлэх хугацаа. Энэ үед малын сүү татарсан байдаг учраас олдоц нь багасч үнэ өсдөг учир төсөвлөгдсөн төсөвтэй тохируулан худалдан авдаг.
2. Тухайн байгууллагын эрхлэгч нар орон нутгийнхаа малчид болон хөдөлмөрчидтэй гэрээ байгуулан ажиллах талаар санаачлага дутмаг зэрэгтэй холбоотой.

Сүүлийн жилүүдэд бий болсон ган зудын улмаас говийн болон зарим сумдын хэрэглэгчдийн сүү цагаан идээний хэрэглээ маш их багассан, ялангуяа Богд, Жинст сумын төвийнхэн зуны улиралд зөвхөн цайны сүүтэй байдаг, харин намар, өвлийн улиралд Баянхонгорын хүнсний зах дээрээс сүү цагаан идээгээ худалдаж авдаг байна.

Баянхонгор аймгийн хэрэглэгчид хаанаас сүү худалдан авдаг вэ?

Баянхонгор аймгийн сүүний нийлүүлэлтийн сувгууд




график 3.16

Дээрх графикаас харахад 28 хувь нь аймгийн зах, хүнсний дэлгүүрээс, 40 хувь нь өөрийн аж ахуйгаас, 25 хувь нь таньдаг хүнээсээ, 7 хувь нь хамаатан садангаасаа авдаг гэж хариулжээ. Хөдөө сумын төвийн хэрэглэгчид хамаатан садан буюу таньдаг хүнтэйгээ гэрээ

байгуулах, захиалга өгөх замаар хэрэгцээгээ хангадаг байхад, аймгийн төвийн хэрэглэгчид захаас хэрэгцээт бүтээгдэхүүнээ худалдан авдаг байна. Хэрэглэгчдийн 89 хувь нь түүхий сүү, 11 хувь нь хуурай болон ариутгасан сүү хэрэглэдэг ажээ.

Баянхонгор аймгийн хэрэглэгчид сүү худалдан авахдаа юуг голлон анхаардаг вэ?

Судалгаанд хамрагсдын 56 хувь зөвхөн чанар гэсэн бол 13 хувь нь үнэ ба чанар гэж хариулсан нь хэрэглэгчдэд худалдан авахдаа чанарт илүү анхаардаг байна.




график 3.17

Чанарын шаардлага хэр зэрэг хангаж байна вэ?

Судалгаанд оролцогчдын 78 хувь нь хангаж байна, 22 дунд зэрэг буюу муу гэж хариулсан байна.

Баянхонгор аймагт үйлдвэрлэсэн сүү яагаад бидний шаардлагыг хангахгүй байна вэ?




график 3.18

Чанарын шаардлага хангахгүй гэж хариулсан хэрэглэгчдийн 47.1 хувь нь үнэ өндөр, 29.4 хувь нь эрүүл ахуйн шаардлага хангахгүй, 23.5 хувь нь чанар муу гэсэн шалтгааныг дурджээ.

Баянхонгор аймгийн нэг литр шингэн сүүний үнэ (төгрөг)




график 3.19

Графикаас харахад нэг литр сүүний үнэ УБ-ынхаас 16.1 хувиар өндөр байна.

Одоогийн худалдаалагдаж буй сүү нь ус хольсон, гашилсан, тээвэрлэлтийн нөхцөлд маш их бохирдсон, борлуулж буй хүмүүсийн эрүүл мэнд болон ариун цэврийн байдал хангалтгүй зэрэг шалтгааныг дурдсан байлаа.

Гэхдээ л монгол малын сүү бол жинхэнэ натурал бүтээгдэхүүн учраас импортын сүүнээс илүү чанартай гэж дүгнэжээ.

Хүнсний зах дээрээс сүү худалдан авахад маш хэцүү. Малчид сүүгээ хөлдөөхдөө янз бүрийн зүйл хольсон байдаг. Мөн сав баглаа боодолгүй учраас гадна тал нь маш бохир.

Тэд ариутгасан болон монгол шингэн сүү хоёрыг дараахь үзүүлэлтүүдээр харьцуулан дээрх дүгнэлтийг өгч байсан

Хүснэгт 3.7

№	Сүүний төрөл	Давуу тал	Сул тал
1	Шингэн сүү / Монгол/	<ul style="list-style-type: none"> • тослог ихтэй учир маш амттай • Үнэ хямд • Шинэ байдаг • Янз бүрийн цагаан идээ боловсруулах боломжтой • Жинхэнэ натурал ямар ч химийн хольцгүй 	<ul style="list-style-type: none"> • Хадгалалтын хугацаа богино • Эрүүл ахуй ариун цэврийн баталгаа байхгүй • Сав баглаа боодолгүй
2	Ариутгасан	<ul style="list-style-type: none"> • Сав баглаа боодолтой 	<ul style="list-style-type: none"> • Тослог багатай учраас амтгүй

ба хуурай сүү	<ul style="list-style-type: none"> • Эрүүл ахуйн болон ариун цэврийн баталгаатай • Хадгалалтын хугацаа урт 	<ul style="list-style-type: none"> • Үнэ өндөр • Янз бүрийн хольцтой учраас эрүүл мэндэд сөрөг гэж үздэг. Учир цай чанаж уухад гэдэс дүүрдэг. • Зөвхөн цай чанаж л ашиглана
---------------	--	--

Баянхонгор аймагт цаашдаа сүүний юуг нь сайжруулах хэрэгтэй вэ?




график 3.20

Судалгаанд оролцогсдын 53 хувь нь эрүүл ахуйн нөхцлийг хангасан байх хэрэгтэй гэж хариулсан байхад, 19 хувь нь сав боодолтой байх ёстой, 12 хувь нь батлагдсан стандартын хэмжээтэй байх, 15 хувь нь боловсруулалтын түвшинг сайжруулах хэрэгтэй гэж хариулсан.

Сүүний эрүүл ахуйн нөхцөл гэдэгт малыг эрүүлжүүлэх, малчдын эрүүл мэндийн асуудал хөндөгдөж байна. Мөн сүү, цагаан идээ, махны ариун цэврийн лабораторитой байх нь зайлшгүй юм.

Манай сумын малын 50 орчим нь эрүүл байх

Богд суман дахь бүлгийн хэлэлцүүлэгт оролцогсдын дүгнэлтээс

Сайжруулсан буюу уламжлалт бус аргаар үйлдвэрлэсэн сүүг авах уу?

Судалгаанд хамрагсдын 58 хувь авна, 42 хувь авахгүй гэж хариулсан. Авахгүй гэж хариулсан хэрэглэгчид өөр аймаг, сумаас маш сайн чанартай бүтээгдэхүүн худалдан авах болно, өөрсдөө боловсруулах, ах дүү хамаатан садангаасаа авна, одоо арай ядан хэрэгцээгээ хангаж байхад үнэтэй бүтээгдэхүүн авах боломжгүй гэх мэтийн шалтгаануудыг дурдсан. Аймгийн төвийн иргэд болон үйлчилгээний газрууд маш сайн чанартай бол ямар ч бүтээгдэхүүнийг авахад бэлэн байна гэж хариулсан.

Тус аймагт үйл ажиллагаа явуулдаг хүнсний бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэгчдээс дараах санал асуулга авсан болно. Үүнд:

Сайжруулсан буюу уламжлалт бус сүүн бүтээгдэхүүнийг та борлуулж өгөх үү?

Жижиглэн болон бөөний худалдаа эрхлэгчид 100 хувь борлуулж өгнө гэж хариулсан.

Сайжруулсан болон уламжлалт бус сүүн бүтээгдэхүүн ямар шаардлага хангасан байх ёстой вэ?




график 3.21

Судалгаанд оролцогсдын 28 хувь нь ямар нэгэн хольцгүй цэвэр сүү, 25 хувь нь сав баглаа боодолтой байх, 24 хувь нь ариун цэвэр эрүүл ахуйн шаардлага хангасан, 23 хувь нь жижиглэн савласан байх хэрэгтэй гэж хариулжээ. Дээрх судалгаанаас харахад хэрэглэгчид болон борлуулагчдын аль аль нь эрүүл ахуйн шаардлага, сав баглаа боодолтой болгох хэрэгтэй гэж хариулсан байна.

Баянхонгор аймгийн хэрэглэгчид цаашдаа сүү борлуулалтын ямар сувгийг шаардлагатай сонгох вэ?




график 3.22

Судалгаанд оролцогсдын 46.8 хувь нэрийн барааны дэлгүүр, 27.4 хувь нь захиалгаар нийлүүлэх нь зүйтэй гэж хариулсан байна.

Ер нь хэрэглэгчид аймаг, сумын төвд тухайн сумын ХАА-н бүтээгдэхүүний нэрийн дэлгүүр буюу лангуу ажилладаг байх нь зүйтэй гэж үзсэн. Учир нь энэ дэлгүүрээр нутгийн иргэд бүтээгдэхүүнээ борлуулах, түүнээс худалдан авдаг байх хэрэгтэй. Өнөөдрийн борлуулалтын суваг нь хэтэрхий олон шат дамжиж байгаа учраас сүү цагаан идээний чанар муудах, нэр хүнд унах, чанаргүй бүтээгдэхүүнийг худалдан авах, үнэ хямдрах зэрэг сөрөг талуудтай байна гэж үзэж байсан бол харин захиалгаар нийлүүлэх нь зүйтэй гэж үзсэн хэрэглэгчид өнөөдрийн малчдын үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн маш муу чанартай байгаа. Тэд чанартай ч, чанаргүй ч адилхан үнээр борлогдож байгаа учраас сүү цагаан идээний чанарт ерөөсөө анхаарахгүй байна гэж үздэг ажээ.

3.2.3. Өвөрхангай аймаг

Өвөрхангайчуул эрт дээр үеэс малынхаа сааль, сүүг сайн авч амьдрал ахуйдаа хэрэглэсээр ирсэн уламжлалтай. Хангайн чиглэлийн сумд үхэр, түүний дотор сарлаг олонтой, цагаан идээ нь алдартай байсан. Уянга сум гэхэд Монгол улсын хэмжээнд цөцгийн тосны үйлдвэрлэлээрээ алдаршиж 2 түмэн сарлагийн баяр хийж байсан бол Хужирт суманд улсын хэмжээнд хоёрхон байсан цагаан идээний төрөлжсөн томоохон үйлдвэр ажиллаж олны талархал хүлээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсан түүхтэй. Говийн сумд бог малын саалийг сайн авч заншсан байна. Өвөрхангай аймгийн нийт үхрийн 60.7 хувийг нь сарлаг эзэлдэг байна. Энэ бол асар их хэмжээний сүү үйлдвэрлэх нөөцтэй гэсэн үг. Сарлагийн сүү нь тослог ихтэй учраас монгол хүний уламжлалт хэрэглээ болсон бүтээгдэхүүн юм. Харин ингэний сүү бол шинээр зах зээлд орж ирж буй бүтээгдэхүүн. Ингэний ундаа болон хоормогийг зөвхөн Өмнөговь аймагт л хэрэглэж байсан бол 1990-ээд оноос эхлэн эрүүл мэндэд ач тустай гэдэг үүднээс хэрэглэх хандлагатай болж байгаа бүтээгдэхүүн. Өөрөөр хэлбэл зах зээлд нэвтрэлтийн үе шатанд явж буй бүтээгдэхүүн.

Ер нь хэрэглээ талаас судлахад малчид болон бизнес эрхлэгчид жилийн дөрвөн улиралд сүү цагаан идээг хүнсэндээ хэрэглэдэг байхад сум болон аймгийн төвийн төсвийн ажилтан албан хаагчид зун, намрын улиралд арай түлхүү хэрэглэдэг харин орлого багатай хэсэг нь зөвхөн зуны улиралд л бага зэргийг хэрэглэдэг ажээ. Энэ нь тухайн бүтээгдэхүүний үнэтэй холбоотой юм.

Өвөрхангай аймаг нэг литр шингэн сүүний үнэ төгрөгөөр / улирлаар/




график 3.23

Графикаас харахад зуны улиралд сүү өвлийнхээс 2.5 дахин хямд байх жишээтэй байна. Зуны улиралд малчид өөрийн хэрэгцээнээс илүү гарсан хэсгийг сумын төвд борлуулах, хадгалалтанд тэсвэртэй ааруул, эзгий, өрөм болгон хуримтлуулан хадгалах бөгөөд түүнийгээ намрын улиралд нэгтгэн аймаг, сумын зах зээлд гаргах арга хэмжээ авдаг байна. Малчид үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулахад ямар нэгэн бэрхшээл байхгүй. Учир нь тухайн сумын төвийн иргэд, аймаг болон УБ хотын наймаачид өөрсдөө очиж авдаг байна. Мөн зарим тохиолдолд ах дүү хамаатан садандаа бэлэглэх, худалдах зэргээр борлуулдаг.

ӨХ аймгийн хэрэглэгчид ямар сүү хүнсэндээ илүү хэрэглэдэг вэ?




график 3.24

Графикаас харахад хэрэглэгчдийн 58 хувь нь байнга шингэн сүүг, 8 хувь нь зарим тохиолдолд хуурай сүүг, 34 хувь савласан сүүг хэрэглэдэг гэж хариулсан. Нийтийн гал тогоо

бүхий цайны газар ресторан, хүүхдийн цэцэрлэг нь хуурай сүүг хэрэглэдэг байхад, жуулчны бааз, ресторан, бар зэрэг нь савласан сүүг хэрэглэдэг гэж хариулсан байлаа.

А. Төгрөг сум

908.9 мянган литр сүүний нөөцтэй бол хэрэгцээ нь 587.7 мян.л болж 321.2 мян.л сүү хэрэглээнээс илүү гарч байгаа юм. Зуны улиралд малчид өөрийн хэрэгцээнээс илүү гарсан хэсгийг сумын төвд борлуулах, хадгалалтанд тэсвэртэй ааруул, эзгий, өрөм болгон хуримтлуулж хадгалах бөгөөд түүнийгээ намрын улиралд нэгтгэн аймаг, сумын зах зээлд гаргах арга хэмжээ авдаг байна. Зуны улиралд сүү сумын төвд 250-300 төгрөг орчим үнэтэй борлодог бол намар орой, өвлийн улиралд 350-400 төгрөг, цагаан сар болон баяр ёслолын үед 500 төгрөг хүрдэг байна. Малчны нэг бүлэг сүү боловсруулах бага хүчин чадлын төхөөрөмжтэй болж үйлдвэрлэл эрхлэх санаачлага гаргасан.

Б. Сант сум

Энэ сумын сүүний нөөц 1727.2 мян.л бол хэрэгцээ нь түүнээс 65 орчим хувиар бага буюу 767.1 мян.л байна. Тус сумын сүүний үйлдвэрлэлийн зонхилох хувийг ямааны сүү эзэлж байна. Ямааны сүүний хэмжээ 639.1 мян.л буюу нийт сүүний 37 хувийг дангаараа эзэлж байна. Ямааны сүүгээр бор ааруул хийдэг байна. Ааруулын боловсруулалтын түвшин, зах зээлийн үнэ Төгрөг сумынхтай ижил.

Манай хүүхдийн цэцэрлэг өвлийн улиралд хуурай сүү авч хүүхдийн хоол хүнсэнд хэрэглэдэг. Учир нь өвлийн улиралд шингэн сүүний олдоц бага байдагтай холбоотой.

Сант сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч

Хужирт сумын сүүний нөөц 2202.7 мян.л бөгөөд харин хэрэгцээ нь 1422.3 байна. Хэрэв рашаан сувиллын хэрэгцээг оролцуулан тооцвол хэрэгцээнээс 2 мянга орчим литр сүү илүү гарна. Энэ сумын хувьд сүүг гол төлөв шингэн байдлаар нь ихээр худалдаалж заншсан онцлогтой байна. Сүүний үнэ харьцангуй хямд зуны улиралд 100-200 төгрөг, өвлийн улиралд 300-400 төгрөг байдаг.

В. Арвайхээр сум

Сүүний хэрэгцээ үйлдвэрлэх боломжтой нөөцөөсөө 10.3 дахин илүү. Тухайлбал нөөц боломж нь 469.3 мян.л байхад хэрэгцээ нь 4822.6 мян.л байна. Ойрын сумын малчдаас гол төлөв сүүгээр хангагдах ба мөн үйлдвэрийн боловсруулалттай савласан сүүг Улаанбаатарын зах зээл болон импортоор авч хангадаг.

Архангай аймгийн боловсруулалт сайтай цагаан идээ (гол төлөв хэлбэртэй, чихэртэй ааруул, хорхой ааруул г.м)-г наймаачид авчирч борлуулдаг. Судалгаанд оролцогсдын 73.5 хувь нь жинхэнэ натурал бүтээгдэхүүн авахыг хүсч байхад 26.5 хувь нь чихэртэй, жимстэй бүтээгдэхүүнийг хүсч байсан. Харин сүү цагаан идээ борлуулдаг борлуулагчид болон жижиг дэлгүүрийн худалдагч нар тодорхой хэмжээтэй, хэвлэсэн, чихэр эсвэл жимсээр амталсан ааруулыг худалдан борлуулахад бэлэн байна гэж байсан. Ийм төрлийн ааруулын үндсэн хэрэглэгч нь хүүхдүүд байдаг. Хэрвээ худалдагч нарын тавьж буй шаардлагыг хангасан ааруулыг үйлдвэрлэх юм бол сав баглаа боодолтой байх ёстой гэдгийг ч тэд анхааруулж байсан болно.

Сүүг гол төлөв хөөрүүлсэн, шингэн байдлаар хүнсэнд хэрэглэж заншсан байна. Жилд нэг өрх 30-670 литр сүүг шингэн байдлаар авч хэрэглэдэг байна. Харин өвлийн улиралд хөлдөөсөн байдлаар ихэвчлэн авч хэрэглэдэг байна. Судалгаанд саналаа өгсөн зарим айл сүүг авч хөөрүүлэх, жижиглэн савлах / ундааны саванд хийх / зэргээр боловсруулан бусдад нийлүүлдэг байна.

Шингэн болон хөлдүү сүүг чанарын хувьд учир дутагдалтай байдаг гэж санал асуулгад оролцогчид бүгд тодорхойлж байна.

Хүнсний зах болон сүү зарж буй хүмүүсээс сүү авах маш хэцүү. Тэд сүүндээ янз бүрийн зүйл хольсон байдаг. Иймээс таньж мэддэг хүнээс авах сонирхолтой.

Арвайхээр сум өндөр настны яриа

Сүү гол төлөв гадны хольцтой, бохирдсон байдаг учир хэрэглэгчид таньдаг хүн, хамаатан нараасаа авдаг байна. Харин дэлгүүрийн савлалттай сүүг сум, аймгийн төвийнхэн бага хэмжээгээр авдаг бөгөөд хадгалалт даах нь сайн байдаг боловч чихэр амттай, заримдаа гэдэс дүүргэдэг хэмээн шүүмжилж байна. Хуурай сүүг хаврын цагт буюу орон нутгийн сүү татарсан үед сум, аймгийн төвийнхэн багаар авч хэрэглэдэг бөгөөд 2 кг-аас хэтэрдэггүй байна. Ийм сүүг хэрэглэх нь тун бага байна.

Зун намрын улиралд малчид сүүг гэрийн нөхцөлд боловсруулан гол төлөв тараг, ааруул, эззгий, хураасан өрөм, хольсон тос болгон бэлтгэдэг бөгөөд сэрүүний улирал хүртэл хадгалаад түүнийгээ худалддаг байна.

ӨХ аймгийн Арвайхээр сумынхан хаанаас сүүн бүтээгдэхүүнээ худалдан авдаг вэ?




график 3.25

Графикаас харахад хэрэглэгчдийн 25хувь нь аймгийн хүнсний захаас, 15хувь нь хамаатан садангаасаа, 2 хувь нь өөрийн аж ахуйгаасаа, 26 хувь нь УБ хотын захаас, 28 хувь нь орон нутаг дахь хүнсний дэлгүүрээс, 4 хувь таньдаг хүнээс худалдан авдаг байна.

3.2.4. Сэлэнгэ аймаг

Сэлэнгэ аймаг нь жилдээ 75598 мал саалинд хамруулж 14039.6 мян литр сүү сааж байна. Гэхдээ үйлдвэрлэж буй сүүний ихэнх хэсгийг Улаанбаатар, Дархан-Уулын зах зээлд борлуулдаг байна.

Сэлэнгэ аймаг, Улаанбаатар хотын сүүний үнийн харьцуулалт




график 3.26

Графикаас харахад Сэлэнгэ аймагт шингэн сүүний үнэ Улаанбаатарын зах зээлийн үнээс даруй 3.7 хувиар хямд байна. Харин Баянгол, Мандал сумын малчид нь сүүгээ Улаанбаатар хотын зах зээлд борлуулах ба Баянгол сумын зарим малчид Сүү ХК-д гэрээний дагуу нийлүүлдэг ба үнэ нь зах зээлийн үнээс 31.4 хувиар хямд байдаг ажээ. Мөн зарим

иргэд өглөөний вагоноор ирж сүүгээ зараад Улаанбаатарын зах дээрээс хүнс болон өргөн хэрэглээний бараа авч буцдаг байна.

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн, Сайхан суманд сүү цуглуулах, хөргөх анхан шатны боловсруулалт хийх цех байгуулан ажиллуулж, Дархан-уул, Орхон аймгийн зах зээлд нийлүүлдэг байна. Дархан-уул аймагт сүү цагаан идээ үйлдвэрлэдэг " Дархан-хүнс " ХК үйл ажиллагаа явуулдаг. 2004 оны байдлаар зайрмаг, савласан тараг гэсэн 2 төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж хүчин чадлынхаа 20 хувийг ашиглаж байна. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж нь хоцрогдсон, бүтээгдэхүүний өөрийн өртөг өндөр зэргээс зах зээлд өрсөлдөх чадвар жил ирэх бүр муудаж байгаа. Зөвхөн зуны улиралд 5-6 малчинтай сүү нийлүүлэх гэрээ байгуулдаг ба өвлийн цагт импортын хуурай сүү авч үйл ажиллагаа явуулдаг. Дархан сумын хүн амын хэрэгцээт сүү цагаан идээний 10-15 хувийг хангаж байна. / Дархан -хүнс ХК-ийн ня-бо Чимэдмаа /

Дархан хотын хүнсний төрөлжсөн 2 зах дээр сүү, цагаан идээ 30 гаруй борлуулагч нар өөрийн аймгийн сумд болон Сэлэнгэ аймгийн Жавхлант, Баянгол, Хушаат сумдаас ирэх шингэн сүү, Архангай , Булган аймгуудын сумдаас өвлийн цагт нийлүүлдэг хөлдөөсөн сүү, өрөм, ааруул, шар тос, аарц зэрэг уламжлалт бүтээгдэхүүнийг авч борлуулдаг байна.

"Дархан-Номин" бөөний худалдааны төв болон бусад хүнсний дэлгүүрүүд дотоодын болон импортын ариутгасан сүү, масло, бяслаг зэрэг сүү, цагаан идээг хүн амын хэрэгцээнд худалдаалж байна.

Зөвхөн " Дархан -Номин бөөний худалдааны төв 1 сард УБ хотын боловсруулагчид болон импортлогчдоос ариутгасан сүү, цөцгийн тос, бяслаг зэрэг бүтээгдэхүүнийг 20-30тн -ыг борлуулдаг гэсэн мэдээлэл өгсөн.

Та ямар боловсруулалт хийсэн сүү худалдан авдаг вэ?

Судалгаанд оролцогсдын 70.9 хувь нь ариутгасан болон хуурай сүү хэрэглэдэг бол 29.1 хувь нь малын шингэн сүү хэрэглэдэг гэж хариулсан байна.

Худалдан авсан сүүнийхээ чанарыг юу гэж үнэлж байна вэ?

Ариутгасан сүүг хэрэглэгчид 100 хувь чанартай гэж хариулсан бол шингэн сүү хэрэглэгчдийн 80.9 хувь нь дунд зэрэг гэж хариулсан байна.

Судалгаанд оролцогсдын 42 хувь нь хүнсний бөөний худалдааны төв болон дэлгүүрээс, 29 хувь нь таньдаг хүнээсээ, 29 хувь нь аймгийн болон сумын төв дээрх хүнсний захгаас авдаг гэж хариулсан байна.




график 3.27

Эндээс ажиглаж үзэхэд төв, суурин газрын хэрэглэгчид томоохон супермаркет болон ариун цэвэр эрүүл ахуйн нөхцөл хангасан тохилог газраар үйлчлүүлэх сонирхолтой гэдгийг баталж байна. Энэ байдал Баянхонгор, Өвөрхангай аймгуудад эсрэгээр нь харагдаж байсан.

Сүү худалдаж авахдаа та юуг нь анхаардаг вэ?

Шингэн сүү хэрэглэгчдийн 33.3 хувь нь үнэ ба чанар, 66.7 хувь нь хугацааг анхаардаг бол ариутгасан сүүг хэрэглэгчид 100 хувь хадгалалтын хугацааг анхаардаг гэж хариулсан нь ариутгасан сүүг хэрэглэгчид сонголт хийхдээ санаа зовох зүйл, эргэлзээ багатайгаар худалдан авах шийдвэрээ гаргадаг байна.

Сэлэнгэ аймагт цаашдаа сүү үйлдвэрлэлд юуг нь өөрчлөх хэрэгтэй вэ?




график 3.28

Судалгаанд оролцогсодын 76.2 хувь нь баталгаат хугацаатай байх ёстой гэж хариулсан нь сүүг хөргөх, ариутгах зайлшгүй шаардлага байна гэдгийг илтгэж байна.

Малчид, малчдын бүлэг сүүг хөргөх ариутгах зэргээр хагас боловсруулалт хийгээд одоогийн зах зээлийн үнээс бага зэрэг өндөр үнээр борлуулбал та авах уу?

Хэрэглэгчид 100 хувь авна гэж хариулж байсан.

Сэлэнгэ аймгийн хэрэглэгчид ямар шаардлага хангасан сүүн бүтээгдэхүүн авдаг вэ ?




график 3.29

Судалгаанд оролцогсдын 90 хувь жинхэнэ натурал бүтээгдэхүүн байх ёстой гэж хариулсан нь хэдийгээр өнөөдөр савласан болон ариутгасан сүүг чанартай гэж үнэлж байгаа боловч тэд жинхэнэ натурал бүтээгдэхүүн хэрэглэхийг эрмэлздэгийг харуулж байна.

Борлуулалтын ямар сувгаар худалдан авах вэ?

Судалгаанд оролцогсдын 96.6 хувь нь сүү цагаан идээний нэрийн дэлгүүр байх хэрэгтэй гэж хариулсан байхад 3.4 хувь нь захиалгаар авах нь зүйтэй гэж хариулжээ. Энэ нь өнөөдрийн сүү борлуулалтын суваг нь хэрэглэгчдийн хэрэглээ шаардлагыг хангахгүй байна гэдгийг баталж байна.

3.3 Цагаан идээний зах зээлийн өнөөгийн байдал

Цагаан идээ гэдэгт цөцгийн тос, тараг ааруул, бяслаг аарц зэргийг хамруулан судалгааг хийсэн болно.

Манай улс жилдээ дундажаар 23.9 мян тн ааруул эззгий, 40 сая литр айраг, цагаан тос болон цөцгийн 678.0 тн-ийг үйлдвэрлэж байна.

Бидний авсан судалгаагаар хөдөөний нэг өрх жилдээ 20-50 кг ааруул, эззгий, 40 кг орчим цагаан тос хэрэглэж байхад сумын болон аймгийн төвийн нэг өрх жилдээ ааруул, эззгий 5 -10 кг, цагаан тос 5-25 кг-ийг хэрэглэж байна. Дээрх хэрэглээг үндэслэн тооцоход жилдээ ааруул, эззгий 59.5 мян тн, цагаан ба цөцгийн тос 1284 мян тн хэрэгтэй байна. Тэгвэл манай улс жилдээ дунджаар тараг, цагаан идээ 265.7 мян тн, цөцгийн тос 34.1 мян тн, бяслаг болон аарцан бүтээгдэхүүн 110 мян тн-ийг импортоор авч байна.

3.3.1 Баянхонгор аймаг

Өнөөдрийн байдлаар Баянхонгор аймгийн цагаан идээний ихэнх хэсгийг Галуут, Эрдэнэцогт, Өлзийт, Гурванбулаг зэрэг үхэр олонтой сумууд хангаж байхад Жинст, Богд сумууд нь олдоц багатай боловч хэрэглээ ихтэй ямааны ба ингэний ааруул, ингэний ундаа зэрэг бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлдэг байна. Галуут, Эрдэнэцогт, Өлзийт Гурванбулаг, Жаргалант сумуудад аймгийн нийт үхрийн 66.8 хувь нь байна. Судалгаанд оролцогсод ингэний ааруул, ундаа, ямааны ааруул зэргийг хамгийн сайн бүтээгдэхүүн гэж үнэлж байсан. Дээрх бүтээгдэхүүнд судалгаанд оролцогсдын 60 хувь нь 20 хүртлэх мянган төгрөг, 22 хувь нь 20-50 хүртлэх мянган төгрөг, 18 хувь 50-аас дээш мянган төгрөгийг жилдээ зарцуулдаг гэж хариулсан байна. Энэ нь хөдөөгийн өрхийн дундаж хэрэглээгээр бодоход өрхийн хүнсний бүтээгдэхүүний зардалд 1.5 хувийг эзэлж байна.

Ааруул хэрэглэгчдийн 59.7 хувь нь үхрийн ааруул, 11.3 хувь ингэний ааруул, 29 хувь нь ямааны ааруул хэрэглэдэг гэж байсан Тэд ааруул худалдан авахдаа үхрийн ааруулыг худалдан авагчид чанар ба гарал үүсэлд анхаардаг бол, ингэний ааруул худалдан авагчид чанар ба үнийг анхаардаг, ямааны ааруул худалдан авагчдын 41.3 хувь нь гарал үүслийг харж байж авдаг гэж хариулж байсан. Энэ байдал нь нутаг нутгийн цагаан идээ боловсруулах технологи өөр өөр байдгаар тайлбарлагдана.

Ааруулын одоогийн чанарын байдалд судалгаа хийж үзэхэд хэрэглэгчид ингэний ба ямааны ааруулыг хамгийн сайн чанартай гэж үнэлж байсан.

Баянхонгор аймгийнхан цаашдаа цагаан идээний юуг нь сайжруулах хэрэгтэй вэ?




график 3.30

Графикаас харахад судлагаанд оролцогсдын 31 нь буюу 50 хувь нь хэлбэр дүрсийг нь өөрчлөх, 19.5 хувь нь сав баглаа боодолтой болгох, 19.5 хувь нь боловсруулалтын түвшинг сайжруулах хэрэгтэй гэжээ. Тэд боловсруулалтын түвшинг сайжруулна гэдэгт зөөлөн, жинхэнэ тарагны амттай байх хэрэгтэй гэж үзэж байсан.

Хэрвээ та хүссэн хэмжээгээр сав баглаа боодолтой, янз бүрийн хэлбэр дүрстэй, чихэртэй болон жимстэй ааруулыг одоогийн зах зээлийн үнээс арай илүү үнээр борлуулбал

та авах уу гэсэн асуултанд судалгаанд оролцогсдын 76.7хувь худалдан авна, 23.3 хувь нь авахгүй гэж хариулж байсан.

Баянхонгор аймагт борлуулалтын ямар суваг байвал зохимжтой вэ?




график 3.31

Судалгаанд оролцогсдын 35 хувь нь нэрийн дэлгүүр, 34 хувь нь захиалгаар, 16 хувь нь одоогийн байдлаар, 15 хувь нь ямар ч байж болно гэж хариулсан байна. Энэ нь бас л бүтээгдэхүүний чанар, үнэтэй уялдан гарч ирж байгаа санал юм.

Харин уламжлалт бяслагийг хөдөө сумын төвийнхэн илүү хэрэглэж байхад аймгийн төвийнхэн маш бага хэрэглэж байна. Зах зээлээс хол оршдог малчид зуны цагт төв суурин газарт хүрч бүтээгдэхүүнээ борлуулахад бэрхшээлтэй байгаатай холбоотой.

Харин төв суурингийн хэрэглэгчид бяслагийг хэрэглэх сонирхолтой боловч зуны улиралд олдоц багатай байдаг учраас тэр бүр хэрэглээд байдаггүй гэж байлаа. Цөөн тооны буюу 50-аас дээш насны хэрэглэгчид хэрэглэх бол өөрсдөө хийж хэрэглэдэг гэж байсан.

Аймгийн хүнсний 2 зах дээр сүү цагаан идээ худалдан борлуулдаг 40 орчим борлуулагчид байдаг. Нэг хүн жилдээ дундажаар 550 кг орчим хөлдүү сүү, 2250 л орчим шингэн сүү зардаг гэхээр жилдээ 22.0 тн хөлдүү сүү, 90.0 тн шингэн сүү борлуулдаг байна.

2005 оны 1-р сарын 24-28 хооронд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан Баянхонгор аймгийн хангайн сумдын цагаан идээний үзэсгэлэн худалдаанд оролцогсдоос авсан судалгаагаар:




график 3.32

Судалгаанд оролцогсдын 37 хувь сав баглаа боодолтой байх, 28 хувь нь чанарыг сайжруулах, 21 хувь технологийг өөрчлөх, 14 хувь хэлбэр дүрсийг өөрчлөх хэрэгтэй байна гэжээ. Тэгэхлээр хотын болон хөдөөгийн хэрэглэгчдийн тавьж буй шаардлага сав баглаа боодолтой болгох, янз бүрийн хэлбэр дүрс амттай болгох нь өнөөдрийн уламжлалт бүтээгдэхүүнийг бага зэрэг өөрчлөх аль эсвэл бэлтгэж буй технологийг нь сайжруулах хэрэгтэйг харуулж байна.

Харин та бага зэрэг сайжруулалт хийсэн боловч одоогийн байгаагаас илүү өндөр үнэтэй бүтээгдэхүүнийг худалдан авах уу гэсэн асуултанд 73.6 хувь нь худалдан авна, 26.3 хувь нь худалдан авахгүй гэж хариулсан. Үгүй гэж хариулсан хүмүүс өөр бусад аймаг, сумаас илүү чанартай бүтээгдэхүүн ирэх учраас заавал ийм төрлийн бүтээгдэхүүн худалдан авах шаардлага байхгүй гэж хариулсан байна. Баянхонгор аймгаас жилд дундажаар Улаанбаатар хотын зах зээлд зөөхий, цагаан болон шар тос 100 орчим тн, хөлдүү сүү 50.0 тн, аарц-2.5 тоннийг борлуулдаг ажээ.

3.3.2 Өвөрхангай аймаг

Хөдөө орон нутагт цагаан идээний боловсруулалтын түвшин муу, үнэ өндөр учраас зарим хэрэглэгчид УБ хот болон төвлөрсөн зах зээлээс импортын болон бусад аймаг сумдын сүү цагаан идээ авдаг байна.

Цагаан идээний үйлдвэрлэлийн юуг өөрчлөн сайжруулах вэ?

Хүснэгт 3.8

Бүгд	Амт үнэр	Хэв загварыг өөрчлөх	Сав баглаа боодолтой болгох	Жижиглэнгээр бэлтгэх	Эрүүл ахуйн шаардлага хангах
100	11	14	26	26	23

Хүснэгтээс харахад хэрэглэгчдийн 26 хувь сав баглаа боодолтой, жижиглэнгээр савласан байх, 14 хувь нь хэв загварыг өөрчлөх, 23 хувь нь эрүүл ахуйн шаардлага хангасан байх, 11 хувь нь амт, үнэрийг өөрчлөх хэрэгтэй гэжээ.

Хэрэглэгчид бүтээгдэхүүн тус бүрээр дараахь шаардлагыг тавьж байсан:

Тарагны талаар хэрэглэгчид гарал үүслийн хувьд натурал байдгаараа сайн талтай ч амархан исдэг, эрүүл ахуй ариун цэврийн нөхцөлд боловсруулсан эсэх нь эргэлзээтэй, савлалт муу, амт нь импортынхоос доогуур гэсэн шүүмжлэл гаргаж байна.

Тарагны хэрэглээг нэмэгдүүлэхийн тулд чихэр, жимс болон бусад амтлагчтай хольж боловсруулах, нэг удаагийн хэрэглээнд зориулан 100-500 гр, 1 литрээр жижиглэн савлах, хадгалалтын хугацааг нэмэгдүүлэх арга хэмжээ авах, сумын төвд хөлдөөж худалдах гэсэн саналыг гаргаж байв. Төгрөг, Сант сумын малчдын зарим бүлгээс өтгөрүүлсэн тараг хийж туршсаныг сайшааж байв.

Сүүний **шинэ өрмийг** тогооны, 100гр, 200 гр болгон жижиглэн савлаж худалдаанд урьдчилан бэлтгэж байх, хольсон тос, хураасан өрөм нь хольц багатай чанартай эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагад нийцсэн байх талаар хэрэглэгчдийн санал давамгайлж байна.

Бяслaгны хэрэглээ ерөнхийдөө бага байдаг байна. Жилд нэг айл 2-5 кг-ыг хэрэглэдэг бөгөөд шинэ технологийн тэгээд савлалт сайтай хатаагүй байдлаар хэрэглэхийг хэрэглэгчид сонирхож байна. Уламжлалт бяслагийг нэг их хэрэглэхгүй бөгөөд хэрэгцээ гарсан үед захиалж буюу өөрсдөө хийж авдаг гэнэ. Харин өвөрмөц технологийн (голланд буюу брынза г.м) бяслагийг аймгийн төв болон Хужиртад зуны улиралд голдуу ирдэг зочид, жуулчид хэрэглэх бөгөөд өргөн хэрэглээ болж чадаагүй байна.

Ааруулын хэрэглээ суманд зун, намрын улиралд их байдаг бол харин аймгийн зах зээлд гол төлөв намар орой болон өвлийн улиралд өндөр байдаг байна. Ааруулыг хэрэглээний хувьд авч үзвэл аймгийн төв, Улаанбаатарын хэрэглэгч нар чихэрлэг амттай, хэлбэртэй буюу бага хэмжээтэй зүссэн (аманд багтахаар хэмжээтэй байх), хорхойн технологиор хийсэн байх, цөцгийтэй хольж амтлах, ингэний болон ямааныхыг тусад нь үйлдвэрлэсэн байх, мөн бага бага хэмжээгээр жижиглэн савласан байх зэргээр чанарыг өөрчлөх санал гаргасан байна. Харин сумын хэрэглэгч нар заншсан байдлаараа боловсруулж хэрэглэхийг зүйтэй гэж үзжээ.

Таны тавьсан шаардлагыг хангасан бүтээгдэхүүнийг одоогийн үнээс арай илүү үнээр худалдвал та авах уу?

Хэрэглэгчдийн 85 хувь худалдан авна гэсэн байхад 15 хувь авахгүй гэж хариулсан.

Малчид үнэхээр чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх юм бол бид авна.

Учир нь: 1. Үндэсний үйлдвэрлэлээ хөгжүүлэх

2. Манай бүтээгдэхүүн цэвэр экологийн бүтээгдэхүүн шүү дээ

Арвайхээр сумын нэг хэрэглэгчийн яриа

Худалдан авахгүй гэсэн хэрэглэгчид малчдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс илүү чанартай боловч хямд үнэтэй бүтээгдэхүүн элбэг байдаг учраас заавал тийм бүтээгдэхүүн авах шаардлага байхгүй гэж байсан.

Арвайхээрийн хүнсний зах дээр цагаан идээ борлуулдаг борлуулагчдаас авсан судалгаа:

Малчдын бүлгийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн ямар шаардлага хангасан байх вэ?

Хүснэгт 3.9

Эзлэх хувь	Чанартай байх	Эрүүл ахуйн шаардлага хангасан	Сав баглаа боодолтой	Жин хэмжүүртэй байх
100	25.3	35.3	15.9	23.5

Дээрхи хүснэгтээс харахад 35.3 хувь нь эрүүл ахуйн шаардлагыг хангасан байх ёстой гэдэг шаардлагыг тавьж байсан болно. Энэ нь өнөөдрийн хэрэглэгчид эрүүл бүтээгдэхүүн хэрэглэх гэсэн чиг хандлага өсч байгаатай холбоотой байна.

Худалдан авч байгаа цагаан идээний чанарыг та хэрхэн үнэлж байна вэ?

Оролцогчдын 86 хувь маш сайн, 14 хувь дунд зэргийн чанартай гэж үнэлсэн байна.

ӨХ аймгийн нэг өрх цагаан идээ худалдан авахад жилдээ хэдэн төгрөг зарцуулдаг вэ?




график 3.33

Судалгаанаас харахад хэрэглэгчдийн 20 хувь нь 50-100.0 мянган төгрөг зарцуулдаг байхад 80 хувь нь 20-50.0 мянган төгрөг зарцуулдаг байна. Энэ бол маш бага зардлыг эзэлж байна. Мөн нөгөө талаас өрхийн орлого зарлагыг нэг бүрчлэн тооцдоггүй байдал нь судалгааг үнэн зөв гэж итгэхэд бас эргэлзээ төрүүлж байна. Тухайлбал 20000 төгрөгийг зарцуулдаг гэж үзвэл ердөө л 40л сүү л авна гэсэн үг.

3.3.3 Сэлэнгэ аймаг

Сэлэнгэ аймаг нь жилдээ 90.5 мянган литр айраг, 54.4 тн ааруул, 27.0 тн өрөм, 10.9 тн цөцгийн тос үйлдвэрлэдэг байна. Энэ нь нэг хүнд 290 кг цагаан идээ ногдож байна. Энэ нь улсын дундажаас даруй 2.47 дахин илүү байна. Сэлэнгэ аймгийн малчид зөвхөн өөрийн хэрэгцээнд зориулан цагаан идээ боловсруулдаг байна.

Дархан, Сэлэнгийн цагаан идээний хэрэгцээг Булган, Архангай, Хөвсгөл аймгийн малчид, наймаачид хангадаг байна.

Сэлэнгэ аймгийн хэрэглэгчдээс цөцгийн тосны талаар судалгааг авсан болно.

Цөцгийн тос

Судалгаанд хамрагдсан сумдын малчид малын сүүг шингэн хэлбэрээр боловсруулалт хийлгүй шууд зах зээлд гарган борлуулдаг ба өрхийн хэрэгцээнд зориулан шар тос, ааруул, өрөм боловсруулахаас гадна зах зээлд борлуулахаар цөцгийн тосны үйлдвэрлэдэггүй байна.

Цөцгийн тос боловсруулах нь ажиллагаа ихтэйгээс гадна технологи нь хоцрогдсон 1 кг цөцгийн тос өндөр өртөгтэй гардаг учраас үнийн хувьд импортоор орж байгаа цөцгийн тостой өрсөлдөх чадваргүй байдагтай холбоотой байна.

Сэлэнгэ аймгийн цөцгийн тосны үнэ / 1 кг-ийн үнэ /




график 3.34

Сэлэнгэ аймагт борлуулж буй 1 кг цөцгийн тосны үнэ УБ-ын зах зээлийн ханшаас 1 дахин хямд үнэтэй байна. Энэ нь ОХУ-аас импортоор ихээхэн хэмжээний цөцгийн тос Алтанбулагийн боомтоор орж ирдэгтэй холбоотой юм. Импортоор авдаг цөцгийн тос нь тослог багатай, сав баглаа боодолтой, жижиглэнгээр савласан зэрэг нь хэрэглэхэд хялбар байдаг бол монгол цөцгийн тос нь тослог ихтэй хурц, амт нь тийм ч сайн биш байдгаас гадна жижиглэн савлалт байдаггүй, давс ихтэй зэрэг нь хэрэглэгчдэд таалагдахгүй байна. Монгол цөцгийн тосны гол хэрэглэгч нь нарийн боовны цех юм байна.

Та малчид болон малчдын бүлэг цөцгийн тос үйлдвэрлэвэл худалдан авах уу гэсэн асуултанд судалгаанд оролцогсад 100 хувь авна гэж хариулаад харин үйлдвэрлэх бүтээгдэхүүн нь тослог багатай, бага багаар савласан, жинхэнэ натурал, шинэ бүтээгдэхүүн

байх ёстой гэж хариулжээ. Тэгэхлээр манай улсад цөцгийн тос үйлдвэрлэхэд борлуулах зах зээл хангалттай байна.

3.4 Төмс, хүнсний ногооны зах зээлийн өнөөгийн байдал

2004 онд манай улс 80.2 мян тн төмс, 49.2 мян тн хүнсний ногоо хураан авсан байна. Манай улс жилдээ 249.4 мянган тн төмс хүнсний ногооны хэрэгцээтэй ба нийт хэрэгцээний 51.9 хувийг өөрийн үйлдвэрлэлээр 18.0 хувийг импортын ногоогоор хангаад 30.1 хувийг хангаж чадахгүй байна.

3.4.1 Баянхонгор аймаг

Баянхонгор аймаг жилдээ 800-900 тн төмс, 300-560 тн хүнсний ногоо хураан авдаг нь нийт хүн амын хэрэгцээний 10.5 хувийг хангахаар байна. Үлдэх 89.5 хувийг Улаанбаатар хотын хүнсний захгаас худалдан авч борлуулдаг байна. Хөдөөгийн сумдын иргэд төмс, хүнсний ногоо маш бага хэрэглэдэг ба бидний судалгаагаар нэг хүнд 25.8 кг төмс хүнсний ногоо оногдож байна. Тэд хэрэглэхгүй байгаа шалтгаанаа дараахь зүйлтэй холбон тайлбарлаж байсан. Үүнд:

1. Манай нутагт төмс, хүнсний ногоо олдоц муутай
2. Бид мал маллахын зэрэгцээ төмс хүнсний ногоо тариалах боломж маш бага. Учир нь мал маллахад байнга л хажууд нь байх хэрэгтэй учраас төмс хүнсний ногоогоо арчлах зав муутай
3. Манай нутагт төмс, хүнсний ногоо тариалахад усны болон хөрсний байдал маш хязгаарлагдмал
4. Манай сум болон аймгийн хүнсний зах дээр ихэнх тохиолдолд хятад ногоо байдаг учраас тэр бүр аваад хүнсэндээ хэрэглэе гэсэн бодол байдаггүй
5. Зөвхөн намар л өөрийн нутагт ургасан төмс хүнсний ногоог авч хэрэглэдэг. Учир нь ногоогоо тарьсан хүмүүс хадгалах зоорьгүй учраас арай хямдхан үнээр бөөнөөр нь зарж буй үед л авдаг гэж тайлбарлаж байсан.

Харин төмс хүнсний ногоо тариалдаг иргэд намар бага зэргийн хүнсний ногоо хурааж аваад л хурдан борлуулдаг. Учир нь ногоо хадгалах стандартын шаардлага хангасан зоорь байхгүй байдагтай холбон тайлбарласан. Баянхонгор аймгийн хүнсний зах дээр ногоо зардаг 10 хүн байдаг ба тэд ихэнх ногоогоо УБ хотын Барс захгаас бөөндөж авдаг. Ногоог голчлон аймгийн төвийн албан газар, иргэд хэрэглэдэг байна. Аль ч суманд ажиллаж байгаа дэлгүүр, мухлагт төмс хүнсний ногоо зарж байсангүй. Тэгэхлээр сумын төвийнхэн маш бага хэрэглэдэг гэж дүгнэж болно.

3.4.2 Өвөрхангай аймаг

Өвөрхангай аймаг нь жилдээ 1800 тн төмс, 800 тн хүнсний ногоо хураан авч хүнсэндээ хэрэглэдэг байна. Жилийн дундаж хэрэглээ нэг өрхөд 100-180кг төмс, түүнээс 20 орчим хувиар бага бусад төрлийн ногоо байна. Тэгэхлээр 2180 тн төмс, 2384 тн хүнсний ногоог УБ хот болон импортын бүтээгдэхүүнээр хангадаг байна.

Хэрэглэгчид монгол үрээр орон нутагт тарьсан ногоо хэрэглэхийг сонирхдог боловч үнэ болон нийлүүлэлтийн байдлаас шалтгаалан дийлэнх нь хятад төмс, хүнсний ногоо хэрэглэдэг байна. Төмс, хүнсний ногоог жилийн аль ч улиралд худалдан авч хүнсэндээ хэрэглэх ба зах болон дэлгүүрээс голчлон худалдан авдаг байна. Импортын төмсийг чанарын хувьд муу гэж үздэг.

Хятадын төмс бол чанар муутай. Учир нь хөрсөө олон жилийн турш химийн бодисоор бордсон учраас мэдээж төмс нь химийн янз бүрийн бодис ихтэй л байгаа. Иймд монгол төмсний үрээр тарьсан төмс л хэрэглэмээр байна. Даанч олдоц муутай

Арвайхээр сумын өндөр настны яриа

Ер нь намрын улиралд орон нутагт тарьсан төмс, хүнсний ногоо хэрэглээд өвөл, хаврын улиралд ихэнхдээ импортын төмс хэрэглэдэг.

Төмс, хүнсний ногоо борлуулдаг борлуулагч нарын судалгаагаар бол төмс хүнсний ногоо тариалдаг иргэд болон аж ахуйн нэгжүүд ногоо хадгалах зоорьгүй байдаг учраас намар үнэ хямд байгаа үед нь зардаг гэжээ.

Өвөрхангай аймгийнхан тарьсан ногоогоо хэдийд худалддаг вэ?




график 3.35

Судалгаанд оролцогсдын 80.6 хувь нь намар зардаг, 16.1хувь нь өвөл, 3.3 хувь нь жилийн турш зардаг гэж хариулсан байна. Тэгэхлээр хэрэглэгчид зөвхөн намар л өөрийн аймагт тариалсан ногоог хүнсэндээ хэрэглэдэг ажээ.

3.4.3 Сэлэнгэ аймаг

Аймгийн хүн амыг физиологийн хэрэгцээт төмс, хүнсний ногоогоор бүрэн хангаж зах зээлд 4512 тн төмс, 6648 тн хүнсний ногоог борлуулсан байна.

Хүн амын хүнсний ногоог хангах бүрэн боломжтой ургац хураан авсан дүнтэй харагдаж байгаа боловч хүнсний ногоо тариалагчид бэлэн мөнгөний хэрэгцээ, нөөцлөх агуулах, зоорины хүрэлцээ муу байгаа зэргээс шалтгаалан хураасан ургацынхаа 60-70 хувийг намрын улиралд Улаанбаатар хот болон Эрдэнэт хотын зах зээлд хямд үнээр борлуулдаг байна. Үүнээс шалтгаалан өвөл, хаврын улиралд хүнсний ногооны эрэлт ихэсч, үнэ нэмэгддэг байна.

Эрэлтийг хангах үүднээс Дархан хотын хүнсний ногоо борлуулагч нар БНХАУ болон ОХУ-аас төмс, сонгино, лууван байцаа, манжин, чинжүү их хэмжээгээр импортлон авч хангадаг байна. Аймгийн хэмжээнд улаан, ногоон чинжүү огт тариалалт явуулдаггүй байна.

Тус хотын хүн амын 70 хувь нь хүнсний төрөлжсөн 2 захаас, 30 хувь нь хүнсний дэлгүүрүүдээс хэрэгцээт хүнсний ногоогоо худалдан авдаг гэж мэдээлэл өгч байв.

Дархан сумын хүнсний захын бөөний худалдаа эрхлэгч, бизнесмен сард 4-5 тн төмс, 1-2 тн сонгино, 1 тн байцаа, 1-2 тн лууван борлуулдаг гэж хэлж байсан бөгөөд намар өвөл Сэлэнгэ аймаг болон бусад газраас ногоо худалдан авч борлуулдаг ба хавар, зуны улиралд Хятадаас төмс, манжин, лууван, Оросоос сонгино импортлон борлуулдаг юм байна. Зөвхөн энэ хүн жилд дунджаар 60 тн төмс, 12-24 тн сонгино, 12 тн байцаа, 24 тн лууван борлуулдаг байна.

Түүнээс гадна хүнсний ногооны бөөний худалдаа эрхэлдэг 6 хүн байгаа гэж байсан ба жижиглэнгийн наймаачид хавар зуны улиралд тэдгээр хүмүүсээс хүнсний ногоо авч жижиглэнгийн үнээр борлуулдаг байна. Тус сумын зоогийн газар, гуанзууд импортоор орж ирсэн улаан болон ногоон чинжүүг худалдан авч хэрэглэж байгаа гэж хариулж байв.

Мандал сум.

Хүснэгт 3.10

Нийт хүн ам (мян хүн)	Жишмэл хүн (мян хүн)	Нэг хүний норм (кг)	Жилийн хэрэгцээ (тн)
22.8	20.5	99.6	2041.8

Тус сумын хүн амын хүнсний ногооны хэрэглээ 2041.8 тн байдаг бөгөөд өнгөрсөн онд 4117.1 тн хүнсний ногоо хураан авсан бөгөөд хураан авсан ногооныхоо 60 хувийг УБ болон Дархан хотын зах зээл дээр борлуулсан байна.

Төвлөрсөн зах зээлд борлуулсан шалтгаан

- Тус сум их хэмжээний ногоо хадгалах зоорь байхгүй,

- Ногоочдын дийлэнх хэсэг нь өөрсдийн өрхийн хэмжээний ногооноос илүүг хадгалах зоорьгүйн улмаас намар яаралтай борлуулалт хийдэг
- Бэлэн мөнгөний хэрэгцээ

Хүнсний ногооны борлуулалтын байдал.

Тус сумын хүнсний ногоо борлуулагч нар өвлийн улиралд өөрийн болон хөрш сумдын тариаланчдаас хүнсний ногоог бөөний үнээр худалдан авч борлуулах явдал түгээмэл бөгөөд хүнсний зах дээр нь Хятадаас оруулж ирсэн төмс, сонгиныг орон нутгийн төмс, сонгиноос 100-200 төгрөгөөр доогуур үнээр борлуулж байсан ба 14 хүн зах дээр бөөний ба жижиглэнгийн үнээр хүнсний ногоо тогтмол борлуулж байгаа гэсэн мэдээлэл өгч байсан. Мөн зоогийн газар, зочид буудлууд хэрэгцээт хүнсний ногоо ялангуяа мөөг, сонгино, улаан ногоон чинжүү даршилсан ногоог Улаанбаатар хотын зах зээлээс худалдан авдаг гэж ярилцлага өгч байсан.

Үүнээс үзэхэд тус сумын малчдын бүлгүүдийн нэг хэсэг нь зөвхөн улаан, ногоон чинжүү, сонгино, сармис тариалж сумын зах зээлд борлуулах боломжтой нь харагдаж байсан болно. Хамгийн гол асуудал бол тариалах үрийг олж нийлүүлэх болон хүнсний ногоог хадгалах зоорь бэлтгэх явдал юм.

3.5 Жимс жимсгэний зах зээл

3.5.1 Баянхонгор аймаг

Баянхонгор аймагт хармаг, жигд, буйлс модны жимсийг ашиглан ундаа, чанамал зэрэг бүтээгдэхүүнийг өрхийн хэрэглээнд зориулан бэлтгэдэг байна. Гэхдээ аймгийн төвийн хүнсний зах дээр гаргаж зардаггүй байна. Аймгийн нийт хэрэгцээг Тэнгэр бөөний худалдааны төвийн импортоор оруулж ирдэг варень, компот хангадаг ажээ. Тэнгэр болон бусад бөөний худалдааны төв жилдээ дундажаар 15 тн жимс, жимсний чанамалыг борлуулдаг. Зарим тохиолдолд иргэд өөрсдөө УБ хотын зах зээлээс жимс худалдан авч хэрэгцээгээ хангадаг байна. Богд, Жинст сумын зарим малчид нутагтаа чацаргана тарих талаар санаачлага гаргаж байсан болно.

3.5.2 Өвөрхангай аймаг

Өвөрхангай аймагт байгалийн жимсний ургац харьцангуй бага байдаг учраас хэрэглэгчид импортын жимсний чанамал болон жимсийг УБ хотоос тээвэрлэн авчирч хэрэглэдэг байна. Хэрэглээ маш бага. Аймгийн төвийн хэрэглэгчид үнэ өндөр учраас тэр бүр хэрэглэж чаддаггүй гэсэн бол сумын төвийнхэн болон малчид хэрэглэх онц шаардлага байхгүй гэж хариулсан байна. Малчид болон сумын төвийнхэн намрын улиралд өөрсдөө түүж хэрэгцээгээ хангадаг ажээ. Хужирт, Бат-Өлзий, Уянга зэрэг хангайн сумынхан нэрс, хад,

гүзээлзгэнэ зэрэг зэрлэг жимсийг түүж боловсруулан худалддаг байна. Мөн хүүхдийн цэцэрлэг болон яслы эмнэлэг зэрэг газрууд УБ хотын зах зээлээс жимсний хэрэгцээгээ хангадаг байна. Монгол улсын жимсний зах зээл дээр борлуулагдаж буй жимс бүгд Хятад улсынх байдаг учраас чанарын шаардлага тэр бүр хангахгүй байгаа хэдий ч манай улсад жимс, жимсгэний аж ахуй хөгжөөгүй учраас яах аргагүй л хэрэглэдэг байна

3.5.3 Сэлэнгэ аймаг

Сэлэнгэ аймгийн иргэд жилийн хэрэгцээндээ зориулан жилд дундажаар 1 тн орчим жимс, жимсгэнийг байгалиас түүж хэрэглэдэг байна.

Судалгаанд хамрагдсан сумдын хүн амын жимс, жимсгэний эрэлт хэрэгцээг авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 3.11

Сумын нэр	Нийт хүн ам	Жишмэл хүн ам	Нэг хүний норм. /кг/	Жилийн хэрэгцээ /тн/
Жавхлант	1804	1623.6	10.8	17.5
Мандал	22864	20577.6	10.8	222.2
Баянгол	4827	4344.3	10.8	46.9
Дархан хот	74295	66865.5	10.8	722.1

Жавхлант, Мандал, Баянгол сумдын хүн ам хэрэгцээт жимс, жимсгэнийхээ дийлэнх хувийг байгалийн жимс, жимсгэнийг түүж өрхийн хэрэгцээнд зориулан гар аргаар боловсруулах замаар хангадаг байна.

Дархан хотын хүнсний зах дээр Сэлэнгэ болон Хөвсгөл, Архангай аймгаас нэрс, хад, мойл, аньс түүхий болон хагас боловсруулж авчран намрын улиралд борлуулдаг байна.

Дархан хотын хэрэглэгчдийн хэрэгцээт жимс, жимсгэний чанамалын 70-80 хувийг “Дархан-Номин” бөөний худалдааны төв болон жижиглэнгийн дэлгүүрүүд дотоодын болон импортлогчдоос татан авч хангадаг байна.

Сэлэнгэ аймгийн дотоодын жимсний чанамал хэр зэрэг чанартай байна вэ?




график 3.36

Графикаас харахад 25 хувь нь маш сайн чанартай гэсэн бол 75 хувь нь дунд зэрэг гэж хариулсан байна. Энд сайн гэдэг үнэлгээг өгөхдөө:

1. Жинхэнэ байгалийн бүтээгдэхүүнээр үйлдвэрлэж байгаа
2. Янз бүрийн химийн бодис хэрэглээгүй
3. Шинэхэн буюу өрхийн хэмжээнд бага багаар үйлдвэрлэгдэж байгаа учраас маш богино хугацаанд борлуулдаг гэсэн байна.

Харин дунд зэрэг гэж үнэлсэн хэрэглэгчид:

1. Хаяг шошго байхгүй / хэн хэзээ үйлдвэрлэсэн нь тодорхой бус/
2. Сав баглаа боодол муутай
3. Эрүүл ахуйн шинжилгээг хийлгэхгүй байгаа
4. Үнэ өндөр гэж хариулсан байна.

Сэлэнгэ аймгийн нэг өрх жимсний чанамалд хэр зэрэг мөнгө зарцуулдаг вэ?




график 3.37

Судалгаанд оролцогсдын 53 хувь нь 20-50.0 мянган төгрөг зарцуулдаг бол 17хувь нь 20.0 мянган хүртлэх төгрөгийг зарцуулдаг байна.

Сэлэнгэ аймгийнхан хаанаас жимс, жимсний чанамалаа авдаг вэ?




график 3.38

Графикаас харахад хэрэглэгчдийн 59 хувь дэлгүүрээс, 17 хувь өөрийн аж ахуйгаас, 14 хувь аймгийн зах дээрээс, 5 хувь нь УБ хотын зах дээрээс, 5 хувь нь сумын зах дээрээс авдаг гэж хариулсан байна.

Тухайн сумдын хүнсний дэлгүүрүүд жимсний чанамлын борлуулалт тийм сайн биш зөвхөн баяр ёслолын үед хүмүүс худалдан авдаг гэсэн мэдээлэл өгч байв.

Сэлэнгэ аймгийн нэг өрхийн хэмжээнд үйлдвэрлэгдэж буй жимсний чанамлын юуг нь өөрчлөн сайжруулах вэ?




график 3.39

Судалгаанаас харахад дотоодын чанамалын амтыг сайжруулах хэрэгтэй гэж 84 хувь хариулсан нь одоогийн боловсруулж буй жимсний чанамал нь хэрэглэгчдийн хэрэгцээг тэр бүр хангаж чадахгүй байна гэдгийг баталж байна.

Хэрэглэгчид жимсний чанамалыг авахдаа голдуу өрхийн худалдан авах чадварыг харгалзан худалдан авдаг гэж судалгаанд оролцогсдын 90.8 хувь хариулсан байсан. Харин цаашдаа малчдын болон нутгийн иргэдийн үйлдвэрлэсэн жимсний чанамлыг та худалдан авах уу гэсэн асуултанд 100 хувь авна гэж хариулсан байна.

Сэлэнгэ аймгийнхан ямар шаардлага хангасан бүтээгдэхүүн /жимс, жимсний чанамал/ худалдан авах вэ?




график 3.40

Эрүүл ахуйн шаардлага хангах гэж 75 хувь, чанартай байх ёстой гэж 21 хувь, жинхэнэ натурал байх ёстой гэж 2 хувь, сав баглаа боодолтой байх гэж 2 хувь нь тус тус хариулсан бол одоогийн байгаа байдлаар нь авах уу гэсэн асуултанд хэн ч авна гэж хариулсангүй нь өнөөдрийн жимсний чанамал хэрэглэгчдийн хэрэгцээг хэр зэрэг хангаж байгааг илтгэж байна. Иймд жимсний чанамалын боловсруулалтын түвшин, сав баглаа боодол зэрэгт өөрчлөлт хийх хэрэгтэй гэж дүгнэж болох юм.

3.6 Байгалийн гаралтай хүнсний ногоо ба эмийн ургамал

3.6.1 Баянхонгор аймаг

Баянхонгорын нутагт цульхир, таана хөмүүл зэргийг зөвхөн өрхийн хэрэглээнд зориулан хэрэглэдэг. Жинст сумын иргэн Э 2004 онд 25 шил хөмүүл дарж борлуулсан нь хэрэглэгчид маш дуртай авсан гэж ярьж байсан. Гэхдээ дарсан хөмүүлийг аймгийн төвийн иргэд худалдан авдаг байна. Малчид болон орон нутгийн иргэд өөрсдөө түүгээд даршилдаг ажээ. Харин цульхир хэмээх ургамлын үрийг түүж аваад цай чанаж уудаг байна. Цульхир нь нэг жил өнжиж ургадаг ургамал учраас олдоц багатай.

Баянхонгор аймгийн Богд сумын нутагт чихэр өвс ургадаг боловч сүүлийн жилүүдэд маш ихээр ашигласан учраас олдоц нь багасч байгаа, нөгөө талаас чихэр өвсийг бизнесийн зорилгоор авч ашиглахыг хориглосон Засгийн газрын 2003 оны 174, 2004 оны 165-ртогтоолууд гарсан. Иймд малчид болон иргэд өөрийн ахуйн хэрэгцээнд зориулан маш бага хэмжээгээр түүж авч хэрэглэдэг байна.

3.6.2 Өвөрхангай аймаг

Говийн сумынхан хөмүүл түүж өөрсдөө хэрэглэдэг ба зарим нь дарж шил болон гялгар уутанд 500-1000 гр-аар савлаж худалдаж үзсэн байна. 1 шил нь 600-800 төгрөгийн үнэтэй. Хужирт сумынхан зэрлэг сонгино, мангир түүж хүнсэндээ хэрэглэдэг ажээ.

3.6.3 Сэлэнгэ аймаг

Сэлэнгэ аймаг нь жилд дундажаар зэрлэг сонгино, мангир, жууцай гэх мэт байгалийн ногоо 0.5 тн, мөөг 0.2 тн-ыг өөрсдийн хэрэгцээндээ зориулан авч ашигладаг байна. Мандал сумын орлого багатай зарим иргэд байгалийн гаралтай ногоог даршлан сумын зах дээр борлуулдаг байна.

3.7 Даршилсан болон нөөшилсэн хүнсний ногоо

Манай улс импортоор жилд дундажаар 2800 тн өргөст хэмх, салат зэргийг Польш, Вьетнам, Хятад, ОХУ зэрэг орнуудаас авдаг байна. Манай улсад “Газар шим” ХХК, “Заяа” зэрэг үйлдвэрлэгчид ногоо даршлах, нөөшлөн зах зээлд борлуулдаг байна.

3.7.1 Баянхонгор аймаг

Баянхонгор аймгийн төв, хөдөөгийн аль ч суманд өөрсдөө ногоо дарах буюу боловсруулалт хийдэг иргэд маш цөөхөн байна. Хүн амын хэрэглээ маш бага. Зөвхөн баяр ёслолын үеэр л 2-3 шилийг авдаг байна. Учир нь үнэ өндөр учраас тэр бүр худалдан авч чаддаггүй байна. Тэд импортын бүтээгдэхүүнийг хэрэглэх сонирхолтой, манай улсын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн амт муутай боловч үнэ нь импортын бүтээгдэхүүнтэй адилхан гэж дүгнэсэн.

Харин аймгийн төв дээр ногоо даршилдаг иргэдээс өөрсдийнхээ хэрэгцээний дагуу авдаг гэж судалгаанд хамрагсдын 10 хувь нь хариулсан.

Малчдын бүлэг болон иргэд ногоо даршлаад худалдвал та авах уу?

Тэд хэрэглэж үзээд хэрэгцээ хангах чадвартай бол авна гэж хариулсан.

Манай малчид газар тариалангийн салбар эрхэлж байгаагүй, ногоогоор янз бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсан уламжлал байхгүй учраас чадахгүй л гэж дүгнэж болох юм. Тэгэхлээр ийм төрлийн бүтээгдэхүүний зах зээл маш хумигдмал шинжтэй байна.

3.7.2 Өвөрхангай аймаг

Аль ч хүрээний хэрэглэгч дарсан ногоог хүнсэнд зохих хэмжээгээр хэрэглэдэг бөгөөд энэ хэрэглээ нь харьцангуй бага байдаг. Судалгаанд хамрагдагсдын олонх нь сард 1-3 шил дарсан ногоо хэрэглэдэг ба хамгийн олныг хэрэглэсэн нь жилд 180 ширхгийг хэрэглэжээ. Тэд

хэрэгцээнийхээ хирээр хэрэглэж чадахгүй байна. Үнэ өндөртэй, орлоготой багатай учраас гэж тайлбарласан болно. Зөвхөн баяр ёслолын үеэр л авч хэрэглэдэг ажээ.

Өрх гэрийн хэмжээнд даршлах, дахин боловсруулалт хийсэн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулбал авах уу?

Одоогийн зах зээлийн үнээс хямд бол авна гэж 60 хувь, авахгүй гэж 40 хувь нь хариулжээ. Сүүлийн 2 жилд Төгрөг сумынхан өөрсдийн тарьж ургуулсан ногоо дарах, салат хийх зэргээр савлаж хэрэглэж заншсан байна.

Дотоод бүтээгдэхүүн импортын бүтээгдэхүүн хоёрын аль нь чанартай вэ?

Мөн өнөөдрийн зах зээлд зарагдаж буй импортын даршилсан бүтээгдэхүүнийг / нэн ялангуяа Польшийн бүтээгдэхүүнийг / чанар нь маш сайн, харин дотооддоо үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн амт нь арай сул байдаг гэж дүгнэжээ.

3.7.3 Сэлэнгэ аймаг

Судалгаанд хамрагдсан сумдын иргэд өрхийн хэмжээнд тарьсан огурцы, помидор зэргийг даршлах, дахин боловсруулах зэргээр өрхийн хэрэглээгээ хангадаг байна. Харин нийтийн хоол болон томоохон ресторан, үйлчилгээний газрууд импортын огурцы болон алаг салатыг хэрэглэдэг байна. Тэд өөрийн эх оронд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг үнэлэхдээ чанарын хувьд дунд зэрэг гэж үнэлсэн Үүний гол шалтгаан нь:

1. Амт муутай
2. Сав баглаа боодол муутай
3. Зарим тохиолдолд орц нормын хэмжээ тааруухан байдаг зэргийг дурдсан байна.

Мандал, Баянгол, Жавхлант сумдын хэрэглэгчдийн 90 орчим хувь нь өөрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр хэрэгцээгээ хангадаг гэж хариулсан байна. Энэ нь өрх бүр салат, өргөст хэмхээ дарж чаддагтай холбоотой юм.

Та даршилсан ногоог хаанаас авдаг вэ?

Дархан хотын хэрэглэгчдийн 60 хувь нь аймгийн зах дээрээс, 25.8 хувь нь ах дүүгээсээ, 14.2 хувь нь намар хүнсний зах дээр ногоо хямдхан байх үед худалдаж аваад өөрсдөө өрхийнхээ хэрэгцээт ногоо даршлаад авдаг гэж хариулсан байна.

3.8 Эсгий урлалын зах зээл

Эсгий, ширмэл ширдэг, эсгий гутал, эсгий оймс зэрэг бүтээгдэхүүн нь манай уламжлалт бүтээгдэхүүн юм. Харин 2000 оноос эхлэн эсгий урлал болон зарим эсгий эдлэл хийх хөдөлгөөн эрчимтэй өрнөж эхэлсэний нэг нь Норвегийн хүмүүнлэгийн байгууллагын тусламжтайгаар хэрэгжсэн “Өрхийн ноосны үйлдвэрлэл ба маркетинг” хөтөлбөр КАС-ийн “Ядуурлыг бууруулах ажлын байрыг нэмэгдүүлэх” төсөл зэрэг юм. Эдгээр төсөл, хөтөлбөрийн

хүрээнд болон Бэлчээрийн тогтвортой менежмент төслийн хүрээнд сонгогдсон аймгийн сумдын малчдын бүлэг, иргэдэд эсгийн эдлэлийн сургалтыг зохион байгуулжээ.

3.8.1 Баянхонгор аймаг

Уг аймгийн Богд, Жинст сумын иргэд, бүлгийн ба бүлгийн бус малчид зөвхөн өөрсдийн хэрэгцээт эсгий оймс, эсгий табчек зэргийг үйлдвэрлэдэг байна. Богд сумын төв дээр ШУА-ийн харьяа жуулчны бааз байрладаг учраас зарим тохиолдолд жуулчдад худалддаг байна. Гэхдээ тэдний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн чанарын хувьд маш муу, хялгас ихтэй, загвар муу байдаг учраас тэр бүр авдаггүй байна. Ер нь жуулчид манай нутагт ирсэнийг билэгдэн хааяа л худалдаж авдаг гэж тус сумын засаг дарга дүгнэж хэлсэн. Тэгэхлээр орон нутгийн зах зээлд эрэлт байхгүй гэж дүгнэж болох юм.

Харин Баянхонгор аймгийн “Хонгорын сор” хоршооны үйлдвэрлэсэн эсгий тавчек болон бусад эдлэлийг аймгийн захиргаа, эрүүлийг хамгаалах газар зэрэг төр захиргааны байгууллагуудын захиалгаар үйлдвэрлэдэг ажээ. Уг хоршоо цаашдаа гэрийн ширмэл ширдэг ширэх зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байна. Жилийн борлуулалтын орлогын хэмжээ 1.0 сая төгрөг байна.

Харин эцсийн хэрэглэгчид болох хүн ам нь эсгий табचेкийг хэрэглэж үзсэн боловч эсгий тавчек нь хялгас ихтэй, амархан урагдсан учраас чанар нь тааруу учраас дахин аваагүй буюу цаашид сайжруулсан тохиолдолд л хэрэглэнэ гэж хариулж байсан.

3.8.2 Өвөрхангай аймаг

Эсгий эдлэлийн үйлдвэрлэл олигтой хөгжөөгүй, зах зээл нь судалгааг хийсэн 2 аймагтай адилхан байсан. Харин малчид нь гэрийн эсгийг нилээд хэмжээгээр хийдэг ба 2004 онд 26.8 мянган метр гэрийн эсгий хийсэн байна. Гэвч сүүлийн 2 жилд ноосны үнэ 100 төгрөгөөр нэмэгдсэн нь тэд эсгий хийхээсээ илүү ноос хэлбэрээр борлуулдаг болсон. Энэ байдал нь эсгий, эсгий эдлэлийн үйлдвэрлэлийг бууруулсан байна. Судалгаанд хамрагдсан 3 сумын тус бүр 1-2 бүлэг ноосоор гутал, бойтог, улавч, малгай, хантааз зэрэг бүтээгдэхүүн хийж сурсан бөгөөд жуулчдад цөөхөн тоогоор борлуулдаг байна.

3.8.3 Сэлэнгэ аймаг

Сэлэнгэ аймгийн Мандал, Жавхлант, Баянгол сумын иргэд болон малчид эсгий эдлэлийг өөрсдийн хэрэгцээнд зориулан үйлдвэрлэдэг байна. Эсгий тавчек, улавч, оймс зэргийг гол хэрэглэгч нь УБ, Дархан, Эрдэнэт зэрэг томоохон хот суурин газар байдаг байна. Харин Сэлэнгэ аймгийн нэг давуу тал нь нарийн нарийвтар ноост хонь үржүүлдэг нь түүхий эдийн чанар сайн байдаг учраас үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь чанартай байх боломжтой.

УБ хотын хэрэглэгчдийн судалгаагаар тэд эсгий тавчекийг хэрэглэж үзэхэд дулаахан, чийг татахгүй, эрүүл мэндэд тустай гэж үнэлжээ.

Цаашид юуг нь сайжруулах вэ?

Тэд 65.8 хувь нь хялгасыг багасгах, өлмийг нь дахин ширэх, уланд нь резин наах зэргээр сайжруулах хэрэгтэй гэсэн бол 34.2 хувь нь боломжийн чанартай дулаахан гэж хариулж байсан.

3.9 Суран ба модон эдлэл

Судалгаанд хамрагдсан аймаг сумдад араг, савар болон суран эдлэлийн хувьд нэгдсэн үйлдвэрлэгч байдаггүй бөгөөд харин хэрэгцээ нь говийн сумдад нэлээн байна. Одоогийн байдлаар эдгээр зүйлийг ой мод, үхэр ихтэй хангайн сумынхан бага хэмжээгээр хийж өөрсдийн хэрэглээ болон говийн зарим сумын хэрэглээг хангадаг. Гэхдээ эдгээр зүйлийг хилийн худалдаагаар болон Улаанбаатар хотын хувиараа юм хийдэг хүмүүсээр захиалан хийлгэж хангадаг наймаачдын тогтолцоо бий болсон байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: УЛАМЖЛАЛТ БУС БА САЙЖРУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНҮҮДИЙН ТАЛААРХ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖҮҮД

Дүгнэлт 1. Уламжлалт бус болон сайжруулсан бүтээгдэхүүний талаар

Мал аж ахуйн үйлдвэрлэл нь хөдөлмөр зарцуулалт их шаарддаг тул малчдын хувьд өөр төрлийн үйлдвэрлэл хослон эрхлэхэд ихээхэн хүндрэлтэй салбар билээ. Харин малчид бүлэг, хоршооны хэлбэрээр хөдөлмөрөө хорших замаар уламжлалт бус болон сайжруулсан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, уламжлалт бүтээгдэхүүний боловсруулалтыг сайжруулах, хамтран борлуулалт хийх замаар орлогоо нэмэгдүүлэх боломж байгаа нь бидний судалгаагаар тогтоогдлоо.

Судалгааны ажлын үр дүнд уламжлалт бус болон сайжруулсан бүтээгдэхүүнийг дараахь байдлаар тодорхойлж байна. Үүнд:

1.1 Уламжлалт бус бүтээгдэхүүн

Тухайн аймаг, суманд өмнө нь үйлдвэрлэж байгаагүй, зах зээлд шинээр нэвтэрч байгаа малчид үйлдвэрлэх боломжтой бүтээгдэхүүнийг уламжлалт бус бүтээгдэхүүн гэж томъёлов. Эсгий эдлэл, гахай, тахианы мах, өндөг, зөгийн бал, төмс, хүнсний ногоо болон даршилж, савласан ногоо, жимс зэргийг уламжлалт бус бүтээгдэхүүн гэж үзлээ. Үүнийг судалгаанд хамрагдсан аймгуудаар үзүүлбэл:

Баянхонгор аймаг:

Төмс, хүнсний ногоо
Тахианы мах, өндөг
Эсгий эдлэл
Жимс, жимсгэнэ
(Чацаргана гэх мэт)
Ингэний сүүн савласан
бүтээгдэхүүн.

Өвөрхангай аймаг:

Төмс, хүнсний ногоо
Тахианы мах, өндөг
Даршилсан ногоо
Жимс, жимсгэнэ
Шахмал тэжээл, хужир
Эсгий эдлэл
Утсан мах, хиамны
үйлдвэр (Төгрөг сум)

Сэлэнгэ аймаг:

Тахианы мах, өндөг
Гахайн мах
Зөгийн бал
Жимс, жимсгэнэ
Тэжээвэр галуу
Нарийн ногоо
(сармис, сонгино,
улаан ногоон чинжүү
гэх мэт)


Зураг 4.1

1.2 Сайжруулсан бүтээгдэхүүн

Сайжруулсан бүтээгдэхүүн гэж тухайн аймаг, суманд үйлдвэрлэж буй уламжлалт бүтээгдэхүүний амт, хэлбэр дүрс, чанар зэргийг сайжруулсан буюу нэмэлт боловсруулалт

хийсэн, өмнө нь үйлдвэрлэж байгаад дахин өөр дэвшилт технологиор сэргээн үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнийг тодорхойлж байна.

Судалгаанд хамрагдсан аймгуудын сайжруулсан бүтээгдэхүүн:



Зураг 4.2

1.3 Нутгийн нэрд гарсан шилдэг (бренд) бүтээгдэхүүн

Тухайн аймаг болон улсын хэмжээнд хэрэглээ нь тогтворжсон, хэрэглэгчдийн дунд нэрд гарч танигдсан бүтээгдэхүүнийг нутгийн нэрд гарсан шилдэг (бренд) бүтээгдэхүүн гэж тодорхойлсон. Судалгаанд хамрагдсан аймаг сумдын нутгийн нэрд гарсан шилдэг (бренд) бүтээгдэхүүн:

Баянхонгор аймагт:	Богд сум - бор ааруул Жинст сум- бор ааруул, ингэний ааруул, хоормог Эрдэнэцогт сум - цөцгийн тос
Өвөрхангай аймагт:	Төгрөг сум – Зэгстийн угшлийн илүү нугаламтай хонь Сант сум - ямааны бор ааруул Хужирт сум - гэрийн сийлбэртэй мод
Сэлэнгэ аймагт:	Жавхлант сум - лууван Мандал сум – байцаа Баянгол сум – тодруулаагүй

Зөвлөмж 1.1:

Уламжлалт бус болон сайжруулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг малчид эрхлэх сонирхол их байгаа ч ажлыг бие даан зохион байгуулах чадвар сул, технологийн мэдлэг дутмаг, эдийн засгийн тооцоо гаргах ойлголт бага, хэрэглэгчдийн сонирхол, чиг хандлагыг

мэдэхгүй байна. Эдгээр бэрхшээлийг даван туулахын тулд олон төрлийн **сургалт зохион байгуулах, зөвлөлгөө өгөх, мэдээллээр хангах хэрэгтэй байна**. Үүнд:

1. Юуны өмнө төслийн орон нутгийн ажилтан, малчдын бүлгийн ахлагч нарын чадавхийг дээшлүүлэх, үйл ажиллагааг нь дэмжих, тэдний хүлээх үүрэг, хариуцлагыг илүү тодорхой болгох;
2. Төслийн орон нутгийн ажилтан нарыг бизнесийн болон тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх гарын авлага, сургалтын материалаар хангах. Энэ материалыг сонирхсон иргэд, малчид үзэж ашигладаг байх нөхцлийг бүрдүүлэх;
3. Бүлгүүдийн боловсруулсан бизнес саналуудыг цуглуулан авч, судалгааны үр дүнд түшиглэн боломжит үйл ажиллагааны нарийвчилсан тооцоо бүхий бизнес төлөвлөгөө боловсруулахад нь зөвлөлгөө өгөх. Энэ нь танхимын сургалт биш харин тухайлсан бүлэг дээр ажиллаж зөвлөлгөө өгөх ажил юм. Энэхүү зөвлөлгөө өгөх ажилд төслийн ажилтнууд болон тухайн сум, орон нутгийн хоршооны сургагч багш нарыг татан оролцуулах боломжтой юм.
4. Бизнес төлөвлөгөөний үр дүн урьдчилсан байдлаар эерэг гарвал эрхлэх гэж буй үйл ажиллагаатай нь холбоотой технологийн сургалтыг зохион байгуулах, жишээлбэл Баянхонгор аймгийн Жинст, Өвөрхангай аймгийн Төгрөг сумын малчдын бүлэг болон орон нутгийн иргэдэд зориулан үнсэн блок, тоосго үйлдвэрлэх сургалтыг зохион байгуулах;
5. Хамгийн сайн бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй малчдын бүлэг дээр үзүүлэх сургууль зохион байгуулах. Уг үзүүлэх сургуульд тухайн төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг оролцуулах зэрэг үйл ажиллагааг хамруулна.

Зөвлөмж 1.2

Уламжлалт бус болон сайжруулсан бүтээгдэхүүний аймаг, сумаар тодорхойлсон үйлдвэрлэлийг дэмжвэл зах зээлийн эрэлт хэрэгцээ, үйлдвэрлэх боломж, сонирхол байна. (Бүтээгдэхүүн тус бүрээр нарийвчилсан зөвлөмжийг хавсралт 6-аас үзнэ үү.)

Дүгнэлт 2. Уламжлалт бус болон сайжруулсан бүтээгдэхүүний зах зээлийн эрэлтийн талаар

- 2.1. Хүн амын дийлэнхи хэсэг дотооддоо үйлдвэрлэсэн уламжлалт болон уламжлалт бус/сайжруулсан бүтээгдэхүүнээс импортын бүтээгдэхүүн, ялангуяа сүү, цөцгийн тос, бяслаг, даршилсан буюу савласан ногоо, жимс, жимсгэнэ, мөөг, өндөг, тахиа, гахайн өөх зэрэг бүтээгдэхүүнийг илүү худалдан авч байна. Үүний гол шалтгаан нь дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний

- чанар, боловсруулалтын түвшин муу;
- зарим бүтээгдэхүүний үнэ импортынхоос илүү;
- амт, үзэмж, савлалт хангалтгүй;
- энэ төрлийн бүтээгдэхүүнийг Монголд маш бага хэмжээгээр хийдэг буюу эсвэл огт үйлдвэрлэхгүй байгаатай холбоотой нь судалгаанаас харагдаж байна.

Тухайлбал сүү, цагаан идээний 17.2 хувь, даршилсан болон савласан бүтээгдэхүүний 90.0 хувь, төмс, хүнсний ногооны 18 хувийг импортын бүтээгдэхүүн эзэлж байна. Мөн өндөг, гахай, тахианы мах, жимс, жимсгэнэ, загас, мөөг зэргийн хэрэгцээг бараг бүхэлд нь импортоор хангаж байна.

- 2.2. Хэрэглэгчид дотоодын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг экологийн цэвэр бүтээгдэхүүн гэдэг талаас нь үнэлж, түүнийг хэрэглэх гэсэн чиг хандлага өсч байна. Энэ нь зах зээлд дээрх бүтээгдэхүүний эрэлт цаашид тогтвортой хөгжих боломжтойг харуулж байна.
- 2.3. Уламжлалт бус болон сайжруулсан бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ Дархан, Сэлэнгэ, Улаанбаатар зэрэг хүн ам олноор суурьшсан газруудад харьцангуй өндөр байна. Хүн амын дунд экологийн цэвэр бүтээгдэхүүн, өөх тос багатай, аливаа хольцгүй бүтээгдэхүүн хэрэглэх сонирхол өсч байна. Энэ нь дэлхийн хэрэглээний чиг хандлагатай адил байна. Харин Баянхонгор, Өвөрхангай аймгуудад уламжлалт бус бүтээгдэхүүний эрэлт маш бага, сайжруулсан бүтээгдэхүүний эрэлт бага зэрэг байна.
- 2.4. Орон нутгийн хэрэглэгчид хэрэгцээний хирээр биш харин орлогын байдал буюу худалдан авах чадвартаа тохируулан худалдан авалт хийж байгаа нь бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлтөнд нөлөө үзүүлж чадахгүй байна. Энэ нь Баянхонгор, Өвөрхангай аймгийн хэрэглэгчдийн ихэнх нь тодорхой хэмжээний зардал шингэсэн одоогийнхоос арай үнэтэй сайжруулсан болон уламжлалт бус бүтээгдэхүүнийг худалдан авах сонирхол бага байхад, Улаанбаатар, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн хэрэглэгчид худалдан авахад бэлэн гэж хариулт өгч байгаагаар тодорхойлогдож байна. Ялангуяа, дотоодын бүтээгдэхүүн импортын бараанаас хямд байх шаардлагыг хэрэглэгчид тавьж байна.

Зөвлөмж 2.1.

Энэ судалгааны дүнг БТМТөслөөс төр, засгийн байгууллагын хэмжээнд танилцуулж үндэсний үйлдвэрлэлийг дэмжих төрийн бодлоготой уялдуулах арга хэмжээ авах хэрэгтэй байна.

Зөвлөмж 2.2


Уламжлалт бус ба сайжруулсан бүтээгдэхүүний сурталчилгааг идэвхжүүлэх, үүний тулд:

1. Судалгааны явцад гарсан хотын болон аймгийн төвийн хэрэглэгчдийн тавьж буй шаардлагыг үйлдвэрлэгчидэд танин мэдүүлж ойлгуулах талаар төслийн зүгээс анхаарах. Тухайлбал төслийн орон нутгийн ажилтнаар дамжуулан үндсэн үйлдвэрлэгч болох гэрийн эзэгтэй нарт ойлгуулах ажлыг зохион байгуулах
2. Орон нутгийн засаг захиргаатай хамтран уламжлалт болон уламжлалт бус бүтээгдэхүүнийг сурталчлах өдөрлөг зохион байгуулж хэвшүүлэх ажлыг орон нутгийн төслийн ажилтан нарын ажил үүргийн хуваарьт тусгах
3. Баянхонгор аймгийн “Нэг сум-нэг бүтээгдэхүүн” үзэсгэлэн худалдааны туршлагыг бусад аймаг, сумдад таниулах, сурталчлах. Уг үзэсгэлэн худалдаанд амжилттай оролцсон бүлгийн хамт олон болон гишүүдийг урамшуулж байх
4. Уламжлалт бус ба сайжруулсан бүтээгдэхүүний ач холбогдол, шим тэжээллэг чанар, технологийн дэвшил зэрэг давуу байдлыг тусгасан сурталчилгааны материал боловсруулж, хэвлүүлэн хэрэглэгчдэд хүргэхэд төслийн зүгээс дэмжлэг үзүүлэх
5. Уламжлалт бус бүтээгдэхүүнийг боловсруулах, хоол хүнсэнд хэрэглэх заавар, жорын тухай гарын авлага, үзүүлэн бэлтгэж хэвлүүлэн орон нутагт тараах. Тухайлбал, сүүлийн үед ургац сайн, нилээд их хэмжээгээр тариалж байгаа хулуугаар чанамал, ундаа, компот хийх талаар гарын авлага бэлтгэх
6. Зарим төрлийн бүтээгдэхүүн ялангуяа хазаар, ногт, хөхүүр, зэл, арьс, нэхий элдэх уламжлалт арга ажиллагаа алдагдсанаас бүтээгдэхүүний чанар муудах хандлага бий болж байна. Иймд тухайн сум, баг нутгийн хамгийн алдартай бүтээгдэхүүн боловсруулах арга технологийн талаар “Ахмадаас суралцъя” сэдэвт өдөрлөгийг ахмадын өдөр буюу 10-р сарын 1-ний өдөр зохион байгуулж хэвшүүлэх, хамгийн сайн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийг тодруулж тухайн бүлгийн нэрэмжит урамшуулал олгохыг хөхүүлэн дэмжих,
7. Төслийн орон нутгийн ажилтан өөрийн суманд үйлдвэрлэгдэж байгаа уламжлалт ба уламжлалт бус бүтээгдэхүүний тухай мэдээллийг орон нутгийн хэвлэл мэдээлэл болон иргэдэд сард нэг удаа сурталчилдаг байх.

Дүгнэлт 3. Зах зээлийн нийлүүлэлт, борлуулалтын сувгийн талаар

- 3.1. Малчдын өөрсдийн хэрэгцээнээс илүү гарсан мал аж ахуйн бүтээгдэхүүн зах зээлд ямар нэгэн байдлаар (худалдах, бэлэглэх, бараа солилцоо зэрэг) борлуулагдаж байгаа боловч өнөөдрийг хүртэл бодлого зохицуулалтгүй явагдаж байна.

- 3.2. Одоогийн борлуулалтын суваг үйлдвэрлэгч - ченж - боловсруулах үйлдвэр/ захын жижиглэн наймаачид/ - хэрэглэгч гэсэн бүтэцтэй байгаа нь малчдын орлогыг нэмэгдүүлэх боломжийг хязгаарлаж, нөгөө талаас эцсийн хэрэглэгчдийн зардлыг өсгөж байна.
- 3.3. Зарим аймаг, сумдын хооронд бүтээгдэхүүний борлуулалтын өвөрмөц сүлжээ тогтсон байна. Жишээлбэл, Баянхонгор аймгийн Жинст сумын малчдын бүлэг ба иргэд төмс, хүнсний ногоо тарьж Богд сумын иргэдэд борлуулж байгаа, Баянхонгор, Өвөрхангай аймгийн хангайн сумд говийн сумдыг сүү, цагаан идээ, зарим төрлийн суран эдлэл, малын тэжээлээр хангаж байна, Архангай аймгаас Өвөрхангай аймаг руу, Архангай, Хөвсгөлөөс Сэлэнгэ аймаг руу цагаан идээ борлуулах сүлжээ тогтоод байгаа зэрэг энэхүү сүлжээ цаашид улам бэхжих хандлагатай байна.
- 3.4. Малчид бүтээгдэхүүнээ бүлгээрээ буюу хамтран борлуулах боломжийг тэр бүр ашигладаггүй. Учир нь үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн нь бага, нөгөө талаас бие биедээ итгэх итгэлгүй, зохион байгуулалт муу байна. Бүтээгдэхүүн нийлүүлэлтийн үед малчдын бүлгийн гишүүдийн хүлээх хариуцлага сул.
- 3.5. Малчид болон бусад үйлдвэрлэгчид зах зээлийн мэдрэмж, эдийн засгийн мэдлэг дутмаг. Тухайлбал тухайн сумын төвийн хэрэглэгчдэд эрэлт байсаар байтал өөр аймаг сум, хотын зах зээлд бүтээгдэхүүнээ борлуулахыг сонирхдог. Жишээлбэл, Баянхонгор аймгийн сумдын махны борлуулалтын сүлжээг дараах зургаар харууллаа.



Зураг 4.3 Баянхонгор аймгийн сумдын махны борлуулалтын сүлжээ

Тайлбар: Сумдын малчид малаа мах боловсруулагч ХХК, болон аймгийн төвийн махны ченжүүдэд бөөний үнээр худалддаг харин сумын төвийн хэрэглэгчид идэшний махаа аймгийн төв болон Улаанбаатар хотын зах дээрээс жижиглэн

үнээр авч байна. Үүнтэй холбоотой мөн хэрэглэгчдийн хувьд тээврийн болон унааны зардал нэмэгдэж байна.

- 3.6. Борлуулалтын энэ сүлжээ мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний чанарын ялгаатай үнийн системийг бий болгохгүй, үүнээс улбаалан малчид-үйлдвэрлэгчид бүтээгдэхүүнийг чанарыг сайжруулах, анхан шатны боловсруулалт, ангилан ялгалт хийлгүүгээр хямдхан үнээр борлуулж байна.
- 3.7. Төвлөрсөн зах зээлд "Сумын нэрийн барааны дэлгүүр"-ийг ажиллуулах хэрэгтэй гэж судалгаанд хамрагсдын 46.5 хувь нь хариулсан.
- 3.8. Аль ч аймаг сумдад мал аж ахуй түүхий эдийг иж бүрнээр боловсруулалт хийдэг үйлдвэр байхгүй, нөгөө талаас хадгалах, нөөцлөх агуулах зоорьгүй байгаа нь бүтээгдэхүүнээ хямдхан үед нь яаравчлан борлуулахад хүргэж байна.


Зөвлөмж 3.1

Уламжлалт бус ба сайжруулсан бүтээгдэхүүний нийлүүлэлт, борлуулалтын сувгийг сайжруулах шаардлага байна. Үүний тулд:

1. Суманд уламжлалт бус бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг анхан шатны хоршоо, бүлэг хэлбэрээр зохион байгуулах, бүлгүүдийн бизнесийн үр ашгийг дээшлүүлэхийн тулд хоршоо хэлбэрт шилжихийг дэмжих (ингэснээр гишүүдийн бизнест эзлэх эрх, үүрэг тодорхой болно, хариуцлага, санаачлага нэмэгдэнэ).


Дараах зурагт өнөөдрийн тогтсон борлуулалтын сүлжээг хэрхэн өөрчлөж болох жишээг харууллаа.

Зураг 4.4. Мандал сумын сүүний борлуулалтын суваг – 2004 оны байдлаар



Зураг 4.5. Сүүний борлуулалтыг малчид болон тэдгээрийн бүлэг, дундын

хоршооны хэлбэрээр зохион байгуулах боломжит бүтэц



Дээрх зурагт судалгааны багаас санал болгож буй борлуулалтын сувгийг харууллаа. Энэ тохиолдолд сүүний үнийг малчид өөрсдөө тогтоож зах зээлийн түвшинд хүргэх боломжтой болно. Энэ жишээг зөвхөн сүүгээр авсан ба малчдын үйлдвэрлэж буй мах, ноос, арьс, шир гэх мэт бусад төрлийн бүтээгдэхүүний борлуулалтыг мөн энэ бүтцээр зохион байгуулбал илүү үр өгөөжтэй болох юм.

- Аймгийн түвшинд малчдын бүлэг, хоршоод бүтээгдэхүүнийг хамтран борлуулах, хадгалах, нэмэлт боловсруулалт хийх, хэрэгцээтэй түүхий эд материалыг олж нийлүүлэх, нэрийн дэлгүүр ажиллуулах зэргээр зуучлан үйлчлэх үүрэг бүхий дундын нэгж байгуулан ажиллах хэрэгтэй байна. Үүнийг дундын хоршооны хэлбэрээр зохион байгуулж болно. Иймд аймгийн төвд хоршоодын дарга, бүлгийн ахлагч нарт зориулан дундын хоршооны ач холбогдлын талаар сургалт зохион байгуулах

3. Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийг нэр төрөл болон хэмжээгээр нь тодорхойлж худалдааны байгууллага, хүүхдийн цэцэрлэг, сургууль, эмнэлэг гэх мэт хэрэглэгчдэд оновчтой холбож өгөх. Тухайлбал малчид болон малчдын бүлэгтэй гэрээ байгуулахыг тухайн байгууллагын төсвийн захирагч нарт санал болгох гэх мэт
4. Өөрсдийн чадавхид тулгуурлан бүлгийн төрөлжилтийн асуудалд гишүүдийн анхаарлыг хандуулах,
5. Нийлүүлэлтийг хамтран зохион байгуулах нь хамгийн оновчтой хувилбар мөн. Хамтран зохион байгуулах ажлыг албан ба албан бус байдлаар хэрэгжүүлэх, хамтын ажиллагааны хэлбэрийг сонгоход дэмжлэг үзүүлэх үүний тулд хууль эрх зүйн асуудлаар сургалт, зөвлөлгөө, гарын авлагаар хангаж ажиллах
6. Зарим орон нутагт төмс, хүнсний ногоо хадгалах зоорь, сүү цуглуулах хөргүүртэй цэг барих бизнес төлөвлөгөөг боловсруулж санхүүгийн байгууллагаас зээл авахад баталгаа гарган зуучлах, хандивлагч нарт санал болгох
7. Мөн бусад ижил төрлийн үйл ажиллагаа явуулж буй төслүүдтэй хамтран малчдын бүлгийн үйлдвэрлэл буй уламжлалт бус ба сайжруулсан бүтээгдэхүүнийг борлуулах талаар туршлага судалж хоршиж ажиллах, Энэ талаарх гарын авлага, материалыг DVD, CD бичиж малчдад хүргүүлэх

Дүгнэлт 4. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний чанарыг сайжруулах тухай

Хэрэглэгчдийн худалдан авалт хийхэд нөлөөлдөг нэг гол хүчин зүйл нь бүтээгдэхүүний чанар, мал болон малчдын эрүүл мэндийн асуудал юм. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 50-70 хувь нь бүтээгдэхүүний эрүүл ахуйн байдал, чанарыг сайжруулах нь нэн тэргүүнд шийдэх ёстой асуудал гэж хариулж байв.

Зөвлөмж 4.1

1. Мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулахын тулд малын эмч нарт бизнесийн сургалт зохион байгуулах
2. Мал эрүүлжүүлэхэд шаардлагатай сайн чанарын вакцин, эмийг худалдан авахад зориулж сан байгуулах, үүнийг хоёр аргаар хэрэгжүүлэх боломжтой:
 - a. Дундын сангийн хөрөнгийн тодорхой хувийг мал эмнэлгийн үйлчилгээнд зориулах
 - b. Бүлгийн болон бүлгийн бус малчдаас ноолуурын буюу мах борлуулалтын үеэр мал эмнэлгийн үйлчилгээний санд зориулах хураамжийн жишгийг тогтоох
3. Орон нутгийн болон төвлөрсөн зах зээл дээр мал нядалгааны цэг байгуулж ажиллуулах талаар зөвлөлгөө өгч, бизнес төлөвлөгөө боловсруулахад дэмжиж, орон нутгийн засаг захиргаатай хамтран хэрэгжүүлэхэд туслах

4. ХАА-н бүтээгдэхүүний эрүүл ахуй болон ариун цэврийн баталгаажуулалтыг хийдэг төв болон явуулын лаборатори бий болгох талаар аймгийн Засаг даргын тамгын газар, ХАА-н газартай хамтран ажиллах
5. Ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангасан бүтээгдэхүүний үнийг 10 хүртэл хувиар өндөр тогтоох, сурталчлах, борлуулахыг дэмжих, үүнтэй холбогдуулж малчдын бүлгүүдийн дундын эзэмшлийн “Нэрийн барааны дэлгүүр”-ийг төвлөрсөн зах зээлд нээн ажиллуулах, эхний ээлжинд аймгийн төвд ажиллуулж болох юм.
6. Бүлгийн болон бүлгийн бус малчдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сав баглаа боодол, хаяг шошготой болгох санаачилгыг өрнүүлэх орон нутгийн засаг захиргааны байгуулагатай хамтран ажиллах


Дүгнэлт 5: Санхүүжилтийн хэрэгцээний талаар

Судалгаанд хамрагдсан сумдын зарим малчдын бүлэг уламжлалт бус бүтээгдэхүүнийг өрхийн хэмжээнд үйлдвэрлэж байгаа буюу цаашид үйлдвэрлэхийг сонирхож байгаа боловч санхүү болон техникийн нөөцгүй байна. Малчдын бүлэг уламжлалт бус бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, зарим төрлийн бүтээгдэхүүнийг сайжруулахад зарцуулах хөрөнгийн эх үүсвэргүй, арилжааны банкнуудаас олгож буй зээлийн нөхцөл нь малчдын бүлгийн үйлдвэрлэлд тохиромжтой бус байна.

Зөвлөмж 5.1.

1. Малчдын бүлгийн гишүүдийн зарим нь илүүдэл мөнгөтэй ба эргэлтэнд оруулж чаддаггүй, заримд нь үйлдвэрлэл эрхлэх хөрөнгийн эх үүсвэр дутагдаж байгаа нь судалгаанд харагдлаа. Иймд, энэ эх үүсвэрүүдийг ашиглан бүлгүүдийг олон төрөлт хоршооны хэлбэрт шилжиж хадгаламж зээлийн үйл ажиллагаа эрхэлж болох тухай ойлгуулан дэмжих.

Зураг 4.6 Олон төрөлт хоршооны дотоод бүтэц.



Олон төрөлт хоршоо нь малчдын үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний борлуулалтыг хариуцна. Борлуулалтаас олсон бэлэн мөнгөний зохих хувийг гишүүд өөрийн нэр дээр хоршоондоо хадгаламж хэлбэрээр байршуулна. Хоршооны өөр нэг үйл ажиллагаа нь малчдыг хэрэглээний бараагаар хангах явдал юм. Энэ үед зарим гишүүд барааг зээлээр авч болно. Хадгаламж, зээлийн алба нь хадгаламж, зээлийн бичилтыг цаг тухайд нь хийж бэлэн мөнгөний зохистой удирдлагыг хангаж ажиллах үүрэгтэйгээс гаднаас хадгаламж, зээлийн нөхцөлийг өөрсдийн гишүүдийн хэрэгцээнд тулгуурлан гаргах боломжтой болно.

2. Дээрх загварыг дэмжиж буй малчдын бүлэг, хоршоодод Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тухай сургалт зохион байгуулах
3. Жижиг үйлдвэр эрхлэхэд тоног төхөөрөмжийн хэрэгцээ нэн их байна. Тухайлбал, Баянхонгор аймгийн Жинст сумын төв, Өвөрхангай аймгийн Сант сумын төвд талх, нарийн боовны тоног төхөөрөмж, ноос сэмлэх машин гэх мэт. Энэ байдлыг харгалзан дээрх сумдын иргэд болон аж ахуй нэгжид лизингээр болон урт хугацааны зээлээр техник худалдан авах санаачлагыг бусад төслүүдтэй хамтран шийдвэрлэх. Тухайлбал өрхийн амьжиргааг дэмжих хөтөлбөрийн зарим эх үүсвэрийг тоног төхөөрөмжийн болон малчдын бүлгийн зээл олголтонд хамарч болох талаар мэдээлэл хүргэх
4. Мөн Сэлэнгэ аймгийн Баянгол, Мандал сумдад, Өвөрхангай аймгийн Хужирт, Төгрөг, Баянхонгор аймгийн Баянхонгор суманд төмс, хүнсний ногоо хадгалах зоорь барих санаачлагыг дэмжих, үүний тулд 1) зоорь барих талаар сургалт зохион байгуулж гарын авлагаар хангах; 2) бизнес төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлэх, 3) шаардлага хангасан бүлгүүдэд бусад төслүүдийн зээлд хамрагдахад туслах.
5. Сэлэнгэ аймгийн Мандал сумын малчдын бүлгүүдийн дунд сүү цуглуулах, хөргөх цех байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэрэг ажлуудыг төслийн зүгээс дэмжин ажиллах хэрэгтэй байна.

ХАВСРАЛТ

Хавсралт 1

АСУУЛГЫН ҮНДСЭН АГУУЛГА

1. Эцсийн хэрэглэгчээс авах асуулгын агуулга:

1. Ерөнхий мэдээлэл: аймаг, сум, багийн нэр, асуулга өгч буй хүний мэргэжил, албан тушаал, нас, хүйс, ам бүлийн тоо, сарын дундаж орлого, байршил болон хэрэглэдэг уламжлалт бус ХАА-н бүтээгдэхүүний нэрс.
2. Уламжлалт бус бүтээгдэхүүний зах зээл: уламжлалт бус бүтээгдэхүүний жагсаалт, боловсруулалт хийгдсэн бүтээгдэхүүний хэрэгцээ, уламжлалт бус бүтээгдэхүүний чанар, үнэ, сав баглаа боодолд тавих шаардлага, эдгээр бүтээгдэхүүнийг худалдан авч буй гол сувгууд, жилийн хэрэгцээ, зарцуулдаг хөрөнгө, уламжлалт бус бүтээгдэхүүнийг сайжруулах саналууд.

2. Жижиглэн худалдаа эрхэлдэг хувь хүнээс авах асуулгын агуулга:

1. Ерөнхий мэдээлэл: аймаг, сум, багийн нэр, үйлдвэр, үйлчилгээний чиглэл, албан тушаал, мэргэжил, нас, хүйс, боловсрол, эргэлтийн хөрөнгө, борлуулдаг уламжлалт бус бүтээгдэхүүний нэрс
2. Уламжлалт бус бүтээгдэхүүний зах зээл: бизнес эрхэлж буй жил, гол өрсөлдөгч, нийлүүлэлтийн суваг, борлуулж буй бүтээгдэхүүний тоо, хэмжээ, чанар, үнэ, хугацаа, зах зээлд эзэлж буй хувь, хэрэглэгчид, улирлын хэлбэлзэл, эдгээрийг сайжруулах саналууд.

3. Бөөний худалдаа эрхлэгчдээс авсан асуулгын агуулга:

1. Ерөнхий мэдээлэл: аймаг, сумын нэр, үйлдвэр үйлчилгээний чиглэл, албан тушаал, мэргэжил, нас, хүйс, боловсрол, эргэлтийн хөрөнгө, борлуулж буй уламжлалт бус бүтээгдэхүүний нэрс
2. Уламжлалт бус бүтээгдэхүүний зах зээл: бизнес эрхэлж буй жил, гол өрсөлдөгч, нийлүүлэлтийн суваг, борлуулж буй бүтээгдэхүүний тоо, хэмжээ, чанар, үнэ, хугацаа, урамшуулал, сайн ба сул талууд, зах зээлд эзэлж буй хувь, хэрэглэгчид, улирлын хэлбэлзэл, эдгээрийг сайжруулах саналууд

4. Гадаад худалдаа эрхлэгчидээс авсан асуулгын агуулга:

1. Ерөнхий мэдээлэл: аймаг, сумын нэр, байгууллагын нэр, үйл ажиллагааны чиглэл, албан тушаал, мэргэжил, нас, хүйс, боловсрол, экспорт, импортын жилийн нийт эргэлтийн хөрөнгө
2. Уламжлалт бус бүтээгдэхүүний зах зээл: бизнес эрхэлж буй жил, гол өрсөлдөгч, нийлүүлэгч, борлуулж буй бүтээгдэхүүний тоо, хэмжээ, чанар, үнэ, хугацаа,

урамшуулал, сайн ба сул талууд, зах зээлд эзэлж буй хувь, хэрэглэгчид, улирлын хэлбэлзэл, эдгээрийг сайжруулах саналууд

5. Түүхий эд боловсруулагчдаас авсан асуулгын агуулга:

1. Ерөнхий мэдээлэл: аймаг, сумын нэр, байгууллагын нэр, үйл ажиллагааны чиглэл, албан тушаал, мэргэжил, нас, хүйс, боловсрол, эргэлтийн хөрөнгө, борлуулж буй уламжлалт бус бүтээгдэхүүний нэрс
2. Уламжлалт бус бүтээгдэхүүний зах зээл: бизнес эрхэлж буй жил, гол өрсөлдөгч, нийлүүлэлтийн суваг, боловсруулж буй бүтээгдэхүүний тоо, хэмжээ, чанар, үнэ, сайн ба сул талууд, хэрэглэгчид, улирлын хэлбэлзэл, тулгарч буй бэрхшээл, эдгээрийг сайжруулах саналууд

6. Үйлчилгээний байгууллагаас авсан асуулгын агуулга:

1. Ерөнхий мэдээлэл: аймаг, сумын нэр, байгууллагын нэр, үйл ажиллагааны чиглэл, байгуулагдсан огноо, албан тушаал, мэргэжил, нас, хүйс, боловсрол, эргэлтийн хөрөнгө, худалдан авч/борлуулж буй уламжлалт бус бүтээгдэхүүний нэрс, үйлчлүүлэгчдийн тоо
2. Уламжлалт бус бүтээгдэхүүний зах зээл: бизнес эрхэлж буй жил, гол өрсөлдөгч, нийлүүлэлтийн суваг, хадалдан авч буй/борлуулж буй бүтээгдэхүүний тоо, хэмжээ, чанар, үнэ, сайн ба сул талууд, хэрэглэгчид, улирлын хэлбэлзэл, тулгарч буй бэрхшээл, сарын борлуулалт тоо бө төгрөгөөр, хамгийн сайн борлуулалттай бүтээгдэхүүн, улирал, бүтээгдэхүүнийг сайжруулах саналууд

7. Аймаг, сумдын удирдлагаас авсан асуулгын агуулга:

1. Ерөнхий мэдээлэл: аймаг, сумын нэр, ярилцлага өгч буй хүний нэр, албан тушаал, мэргэжил, нас, хүйс, боловсрол
2. Уламжлалт бус бүтээгдэхүүний зах зээл: аймаг, сумын мөрийн хөтөлбөрт малчдын орлогыг нэмэгдүүлэх тухай орсон заалтууд, зах зээлийг хөгжүүлэх талаар ямар арга хэмжээ авч байна, малчид орлогоо нэмэгдүүлэх ямар эх үүсвэр байна вэ, бодит эрэлт, хэрэгцээ ямар вэ

8. Банкны мэргэжилтэнгээс авсан асуулгын агуулга:

1. Ерөнхий мэдээлэл: аймаг, сум, банкны нэр, албан тушаал, мэргэжилт, нас, хүйс, боловсрол
2. Зээлийн тухай асуулга: энэ орон нутагт ажиллаж байгаа жил, олгож буй зээлийн төрлүүд, үүнээс хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн, жижиг бизнесийн зээлийн хэмжээ, хугацаа

Сургалтанд оролцогчдын нэрсийн жагсаалт

1. Баянхонгор аймаг

Сумдын нэр	Хамрагдсан хүмүүс	
Богд	<ol style="list-style-type: none"> 1. Наран- Хамтын хүч 2. Энхбаатар- Бүгийн гэээг 3. Төмөрбат- Шинэ богд 4. Батсайхан- Бүгийн гэээг 5. Жаргал- Бүгийн гэээг 6. Энхжаргал- Орог нуур 7. Бүжин- бүлэг бус 8. Энхцэцэг- бүлэг бус 9. Нямжаргал- бүлэг бус 	<ol style="list-style-type: none"> 10. Дуламжав- бүлэг бус 11. Хандмаа- Шинэ богд 12. Цэмүүнмаа- Орог нуур 13. Амаржаргал- Хамтын хүч 14. Дуламжав- жижиг үйлдвэр эрхлэгч 15. Дуламдорж- ЗД-ын орлогч 16. Батсуурь- төслийн ажилтан 17. Ганболд-Тогтвортой амьжиргаа төслийн ажилтан
Жинст	<ol style="list-style-type: none"> 1. Долгормаа- Бодь 2. Тунгаа-Дэвшил 3. Батсүрэн- Дэвшил 4. Батцэцэг- Оргил 5. Мөнхжаргал- бүлэг бус 6. Равжих- Дэвшил 7. Жанчив- Шархад 8. Базардарь-Шархад 9. Дэмбээ- бүлэг бус 10. Галбаяр- бүлэг бус 	<ol style="list-style-type: none"> 11. Болдбаатар- Дэвшил 12. Ганбаяр- Оргил 13. Чулуунцэцэг- Бодь 14. Ганчимэг- Дэвшил 15. Оюунцэцэг-Шар хад 16. Мөнгөнцэцэг- Шар хад 17. Долгордулам-Дэвшил 18. Банзрагч- Оргил 19. Гэрэлмаа- бүлэг бус
Эрдэнэцогт	<ol style="list-style-type: none"> 1. Б.Чимэдмаа- Нурамт 2. Жүжгаа- Нурамт 3. Х.Мөнхсайхан-Нурамт 4. П.Тогооч- Нурамт 5. П.Янжин- Сая сүрэг 6. Г.Цэдэвбалам- Өлзийт 7. С.Эрдэнэ-Очир - Зүрххайрхан 8. Р.Дашдаваа- бүлэг бус 9. Н.Энхбаатар- бүлэг бус 	<ol style="list-style-type: none"> 14. Г.Долгорсүрэн -Өлзийт 15. С.Сэр-од - бүлэг бус 16. Х.Лхавгажав- бүлэг бус 17. В.Өлзийбат- бүлэг бус 18. Х.Сампилдэндэв- бүлэг бус 19. Л.Должинсүрэн-БТМТ-ийн ажилтан 20. Д.Цэвэгдорж-БТМТ-ийн ажилтан 21. Л.Пагжаанбуу- Сая сүрэг 22. Х.Бэгз- бүлэг бус

10. С.Лхавга- ХАА-н түшмэл	23. Н.Энхтүвшин- БО-ны байцаагч
11. С.Эрдэнэчимэг- бүлэг бус	24. Батсүх- бүлэг бус
12. Б.Тунгалаг- бүлэг бус	25. Очир- бүлэг бус
13. Ц.Доржбат- Шинэ хороот	26. Ганзориг- бүлэг бус

2. Өвөрхангай аймаг

Сумын нэр	Оролцогчдын нэрс	
Төгрөг	1. Х.Лхагваа - малчин (Бүлгийн ахлагч) 2. Д.Должидсүрэн-малчин 3. Д.Батдорж - малчин 4. Ч. Отгонцэцэг – малчин 5. Д.Батсүрэн – малчин (Бүлгийн ахлагч) 6. Ч.Пагамсүрэн – малчин 7. С.Алтансүх - малчин 8. С.Чойдог -малчин 9. Б.Шийрэв-Арилдий– малчин 10. А.Дуламсүрэн-малчин 11. Ц.Доржзэвэг -малчин 12. .П.Нангилдулам-малчин 13. Д.Чулуунбат-малчин (Бүлгийн ахлагч)	14. С.Алтанцэцэг- малчин (Бүлгийн ахлагч) 15. С.Сүхбаатар - малчин 16. Ц.Мөнхбаяр - малчин 17. Д.Алтангэрэл - малчи 18. Д.Эрдэнэцэцэг - малчин 19. Я.Дүгэржамаа - малчин 20. А.Бат-Уул - малчин 21. Д.Энхбаатар - малчин 22. Д.Цэцэггээ - малчин 23. С.Эрдэнэтогтох - малчин 24. Д.Лхагвасүрэн- малчин 25. Д.Мөнхтогтох–малчин (Бүлгийн ахлагч) 26. Д.Янжиндулам - малчин 27. Д.Сандагдорж – малчин 28. н.Оюунгэрэл -ОНА 29. н.Батбаяр -ОНА
Сант	1. Д.Тогтох - малчин (Бүлгийн ахлагч) 2. М.Мөнхдалай- малчин 3. Г.Гантулга – малчин 4. С.Цэнд - малчин 5. Б.Энхтуяа- малчин (Бүлгийн ахлагч) 6. Ж.Сумьяа - малчин 7. Ч.Хатанбаатар - малчин	11. В.Буянтогтох - Тамгын газрын дарга 12. Ч.Долгорсүрэн – Хувиараа хөдөлмөр эрхлэгч 13. Т.Ойдов - Засаг даргын орлогч 14. У.Мөнхтогтох - малчин 15. Ч.Цогзолмаа - малчин 16. П.Дүвжир - малчин

	8. Д.Нямсүрэн – малчин 9. Н.Пунцаг - малчин (Бүлгийн ахлагч) 10. Ч.Цэрэнбанди – ХАА-н түшмэл	17. П.Анхболд - малчин 18. Д.Адьяа- малчин 19. М.Эрдэнэцэцэг – малчин 20. н.Пагамжав - ОНА 21. н.Саранчимэг - ОНА
Хужирт	1. С.Батцэнгэл -Малчин (Бүлгийн ахлагч) 2. Ж.Батбаяр – малчин 3. Ц.Зундуй – малчин 4. Д.Батболд - малчин (Бүлгийн ахлагч) 5. Л.Оюунцэцэг – малчин 6.Ю.Ороолонбуу – малчин 7. П.Балдандорж – малчин (Бүлгийн ахлагч) 8. У.Батбаатар –малчин 9. Ж.Пүрэвдагва – малчин 10.Б.Сэдэд- малчин 11.Б.Лхагвадулам -малчин 12.А.Туяа – малчин	13. Д.Пүрэвдорж –малчин (Бүлгийн ахлагч) 14. Л.Үржинлхам - малчин 15. Б.Цэрэнлхам –малчин 16. Д.Эрдэнэбаатар –малчин 17. Д.Нэргүй – малчин (Бүлгийн ахлагч) 18. С.Рэнцэндондив– малчин 19. Д.Батхуяг – малчин 20. Д.Батхуяг – малчин 21. Д.Жавзандулам – малчин 22. П.Гэрэлдарь –малчин 23. Д.Дашкэвэг –малчин 24. Б.Долгор –малчин 25. Н.Цэрэнсоном – ОНА 26. Н.Нарантуяа -ОНА

3. Сэлэнгэ аймаг

Сумын нэр		Нэрс	Хүйс	Боловсрол	Ажил
Жавхлант	1.	Ц. Эрдэнэ	Эм	Бүрэн дунд	Малчин
	2.	К.Жазира	Эм	Бүрэн бус	Малчин
	3.	Н. Цэвээндорж	Эр	Дээд	Малчин
	4.	Г.Баасанхүү	Эр	Дээд	Малчин
	5.	Бат-Өлзий	Эр	Бүрэн дунд	Малчин
	6.	Сэрчмаа	эм	Бүрэн дунд	Малчин
	7.	Баторших	Эр	Бүрэн дунд	Малчин
	8.	Батнасан	Эр	Тусгай дунд	Малчин
	9.	Цэвээндулам	Эм	Тусгай дунд	Малчин
	10.	Энхтөр	Эр	Бүрэн дунд	Малчин
	11.	Цэндхүү	Эм	Бүрэн дунд	Малчин

	12.	С. Эрдэнэдалай	Эр	Дээд	Малчин
	13.	С. Алтангэрэл	Эр	Дээд	Малчин
	14.	З. Батзориг	Эр	Бүрэн бус	Малчин
	15.	Авгалий	Эр	Бүрэн бус	Малчин
	16.	Е. Баурыжан	Эр	Бүрэн бус	Малчин
	17.	Ж. Алтанзул	Эм	Дээд	Малчин
	18.	Х. Телекей	Эр	Бүрэн бус	Малчин
	19.	Д. Дамсгуль	Эр	Бүрэн бус	Малчин
	20.	Х. Аугали	Эр	Бүрэн бус	Малчин
	21.	М. Авдугани	Эр	Бүрэн бус	Малчин
	22.	С. Манет	Эр	Бүрэн дунд	Малчин
	23.	Чапи	Эр	Бүрэн бус	Малчин
	24.	Б. Амангельд	Эр	Бүрэн бус	Малчин
	25.	Х. Жанчив	Эр	Бүрэн бус	Малчин
	26.	Д. Батсайхан	Эр	Бүрэн дунд	Малчин
Мандал	27.	Туяа	Эм	Тусгай дунд	Малчин
	28.	Молом	Эр	Дээд	Малчин
	29.	Чойжилсүрэн	Эр	Тусгай дунд	Малчин
	30.	Нармандах	Эр	Тусгай дунд	Малчин
	31.	Лхамсүрэн	Эр	Бүрэн дунд	Малчин
	32.	Цэрэнбалжир	Эр	Тусгай дунд	Малчин
	33.	Туяа	Эм	Дээд	бизнес
	34.	Өлзий	Эр	Бүрэн дунд	Малчин
	35.	Ариунболд	Эр	Бүрэн бус	Малчин
	36.	Дэрэм	Эр	Тусгай дунд	Малчин
	37.	Ганболд	Эр	Тусгай дунд	Малчин
	38.	Гүнсэн	Эр	Тусгай дунд	Малчин
	39.	Байгалмаа	Эм	Тусгай дунд	Малчин
	40.	Чинбат	Эр	Бүрэн дунд	Малчин
	41.	Болормаа	Эр	Тусгай дунд	Малчин
	42.	Жуковбат	Эр	Дээд	Бизнес
	43.	Анигаан	Эр	Бүрэн бус	Малчин
	44.	Цогсүрэн	Эр	Бүрэн бус	Малчин
	45.	Энхцэцэг	Эм	Тусгай дунд	Малчин
	46.	Мөнгөнхүлэг	Эр	Дээд	Төслийн ажилтан

	47.	Эрдэнэболор	Эр	Бүрэн дунд	Малчин
Баянгол	48.	Пунцагноров	Эр	Тусгай дунд	Малчин
	49.	Доржсүрэн	Эр	Бүрэн дунд	Малчин
	50.	Жигүүсэн	эм	Бүрэн бус	Малчин
	51.	Сайнням	Эр	Бүрэн бус	Малчин
	52.	Отгоо	Эр	Бүрэн бус	Малчин
	53.	Батсуурь	Эр	Бүрэн дунд	Малчин
	54.	Алтай	Эр	Тусгай дунд	Малчин
	55.	Цэдэнбал	Эр	Бүрэн бус	Малчин
	56.	Даваасүрэн	Эр	Бүрэн бус	Малчин
	57.	Болд	Эр	Тусгай дунд	Малчин
	58.	Л. Ганболд	Эр	Бүрэн дунд	Малчин
	59.	А. Ганболд	Эр	Бүрэн бус	Малчин
	60.	Батаа	Эр	Тусгай дунд	Малчин
	61.	Нямсүрэн	Эр	Бүрэн бус	Малчин
	62.	Тогмид	Эр	Бүрэн бус	Малчин
	63.	Батхүү	Эр	Бүрэн дунд	Малчин
	64.	Баасанжав	Эр	Тусгай дунд	Малчин
	65.	Отгонбаяр	Эр	Тусгай дунд	Малчин
	66.	Бадрах	Эр	Бүрэн дунд	Малчин
	67.	Наранчимэг	Эм	Бүрэн дунд	Малчин
	68.	Дэлгэрцэцэг	Эм	Тусгай дунд	Малчин
	69.	Батболд	Эр	Бүрэн дунд	Малчин
	70.	Отгонжаргал	Эр	Бүрэн бус	Малчин
	71.	Нарангэрэл	Эм	Тусгай дунд	Малчин
	72.	Шагдар	Эр	Тусгай дунд	Малчин
	73.	Алтанчимэг	Эм	Дээд	Малчин
	74.	Чүлтэмжамц	Эр	Бүрэн бус	Малчин
	75.	Н. Энхбаяр	Эр	Бүрэн дунд	Малчин
	76.	Д. Даваасүрэн	Эр	Бүрэн бус	Малчин
	77.	Ч. Баасанжав.	Эр	Тусгай дунд	Малчин
	78.	Ичинноров	Эм	Тусгай дунд	Багийн дарга
79.	Гансолонго	Эм	Бүрэн дунд	Малчин	
80.	Нарантуяа	Эм	Бүрэн дунд	Малчин	
81.	Цэрэндолгор	Эм	Бүрэн бус	Малчин	

82.	Янжмаа	Эм	Бүрэн бус	Малчин
83.	Бямбажав	Эр	Бүрэн дунд	Малчин
84.	Батжаргал	Эр	Бүрэн бус	Малчин
85.	Өлзиймаа	Эм	Бүрэн дунд	Малчин
86.	Долгорсүрэн	Эм	Тусгай дунд	Малчин
87.	Отгончимэг	Эм	Бүрэн дунд	Малчин
88.	Алтантуяа	Эм	Бүрэн бус	Малчин
89.	Батням	Эр	Бүрэн бус	Малчин
90.	Сэрчмаа	Эм	Бүрэн дунд	Малчин
91.	Алтанчимэг	Эм	Тусгай дунд	Малчин

БИЗНЕС ГЭЖ ЮУ ВЭ?

Хуулийн хүрээнд

- ажил үйлчилгээ, үйлдвэрлэл явуулж
- ашиг олох үйл явдал

МАЛЧИН ӨРХИЙН БИЗНЕС ЮУ ВЭ?

Мал аж ахуй <ul style="list-style-type: none"> • Бэлчээр • Уст цэг • Хашаа, хороо • Малчин • Мөнгө 	Малын гаралтай бүтээгдэхүүн түүхий эд борлуулалт ҮНЭ – ЗАРДАЛ = ?
--	---

БИЗНЕСТ ЮУГ БАГТААН ОЙЛГОХ ВЭ

- Худалдаа, арилжаа
- Үйлчилгээ үзүүлэх
 - Мал аж ахуй
- Үйлдвэрлэл эрхлэх
- Санхүү, даатгалын үйлчилгээ

МАЛЧНЫ БИЗНЕСИЙН ГОЛ ЗОРИЛГО

МАЛ АЖ АХУЙН <ul style="list-style-type: none"> • ҮЙЛДВЭРЛЭЛЭЭ САЙН ЯВУУЛЖ • ЧАНАРТАЙ ИХ БҮТЭЭГДЭХҮҮН АВЧ • ӨНДӨР ҮНЭЭР • ЗАХ ЗЭЭЛД ХҮРГЭЖ • ЗӨВ СУВГААР БОРЛУУЛАХ 	ҮЙЛДВЭРЛЭЛ, АХУЙДАА ХЭРЭГЦЭЭТЭЙ <ul style="list-style-type: none"> • ХЭРЭГСЭЛ • БАРАА • МАТЕРИАЛЫГ • БАГА ҮНЭ • ХЯМД ЗАРДЛААР ОЛЖ АВАХ
---	---

БИЗНЕСМЕН ГЭЖ ХЭН БЭ?

Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа арилжаа эрхэлж буй хүнийг **бизнесмен** гэнэ.

- **Малчин** хүн бизнесмен мөн үү?
- Мөн бол **яагаад?**

МАЛЧДЫН БИЗНЕСИЙН ҮР АШГИЙГ ЯАЖ ДЭЭШЛҮҮЛЭХ ВЭ?

- Бүтээгдэхүүн чанартай байх
- Хэрэгцээнд нийцсэн байх
- Бүлгийн хэмжээнд бүтээгдэхүүнээ төвлөрүүлэн тоо, хэмжээг нэмэгдүүлэх
- Төвлөрсөн зах зээлд үнэ хүргэх
- Хэрэгцээт зүйлээ бөөнөөр авах
- Бүлгээрээ хэлэлцэж бизнесээ төлөвлөх

БИЗНЕСИЙН АЛТАН ХУУЛЬ


Зах зээлийн нөхцөлд аливаа үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа арилжаа эрхлэх үйл ажиллагаа нь эзэн хүндээ их, бага ямар нэг хэмжээгээр **ЗААВАЛ АШИГ АВЧ ИРЖ БАЙЖ** цаашид оршин тогтнох, хөгжин дэвжих нөхцөл бүрддэг.

МАЛЧИН ӨРХИЙН ТӨСӨВ

<ul style="list-style-type: none"> • Өрхийн орлогын төлөвлөгөө • Өрхийн зарлагын төлөвлөгөө • Мөнгөн урсгалын төлөвлөгөө 	Зах зээлийн нөхцөлд өрх бүр орлого, зарлага, мөнгөн урсгалын төлөвлөгөөгөө оны эхэнд урьдчилан хийж ажиллах шаардлагатай болж байна.
---	--

МАЛЧНЫ БҮЛГИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

- Гишүүн өрхүүдийн бүтээгдэхүүний тооцоо
- Гишүүн өрхүүдийн хэрэгцээний тооцоо
- Гишүүн өрхүүдийн мөнгөн урсгалын төлөвлөгөө



ХОРШООНЫ МӨН ЧАНАР

- Хоршоог гишүүд бүрдүүлдэг
- Хоршоог гишүүд удирддаг
- Хоршоог гишүүд нь хянаж байдаг
- Хоршоо гишүүндээ үйлчилдэг
- Хоршоо гишүүн төвтэй байгууллага
- Хоршоо ашгийн төлөө бус хуулийн этгээд

МАЛЧНЫ БҮЛЭГ ХУУЛИЙН ЯМАР ЭТГЭЭД БАЙВАЛ ЗӨВ БЭ?

МАЛЧНЫ БҮЛЭГ НЬ ХАМТАРЧ АЖИЛЛАХ ХЭЛБЭРЭЭ ӨӨРСДӨӨ СОНГОЖ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ХЭЛБЭРЭЭР ОРШИН ТОГТНОЖ БОЛОХ БОЛОВЧ БИЗНЕС БУЮУ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХЫН ТУЛД АЖ АХУЙН НЭГЖ БАЙХ ШААДЛАГАТАЙ.

ХОРШОО БАЙГУУЛАХ АЛХМУУД

- Сонирхогч нарыг бүрдүүлэх
- Бизнесийн саналыг боловсруулах
- Зохион байгуулах хурал
- Бизнес төлөвлөгөө боловсруулах
- Бэлтгэл ажил
- Үүсгэн байгуулах хурал
- Хоршоог бүртгүүлэх
- Бизнесийг эхлүүлэх
- Холбоо, дундын хоршоонд элсэх

АЖ АХУЙН НЭГЖИЙН ТӨРЛҮҮД



БИЗНЕСИЙН ШИНЖИЛГЭЭ, "SWOT" ШИНЖИЛГЭЭ

	ЭЭРЭГ НӨЛӨӨ	СӨРӨГ НӨЛӨӨ
ДО-ТООД ОР-ЧИН	ДАВУУ ТАЛ • •	СУЛ ТАЛ • •
ГА-ДААД ОР-ЧИН	БОЛОМЖ • •	БЭРХШЭЭЛ(АЮУЛ) • •

Хоршооны үндсэн зарчмууд

- Сайн дурын нээлттэй гишүүнчлэл
- Ардчилсан удирдлага, хяналт
- Гишүүдийн эдийн засгийн оролцоо
- Бүрэн эрхт бие даасан байдал
- Боловсрол, сургалт, мэдээлэл
- Хоорондын хамтын ажиллагаа
- Нийгэм, бүлгийн эрх ашиг

ӨРСӨЛДӨГЧИЙН ШИНЖИЛГЭЭ

- ӨӨРИЙН БОЛОН ӨРСӨЛДӨГЧИЙН БИЗНЕСИЙГ ХАРЬЦУУЛАХ
- Зах зээлд эзлэх хувь
 - Бүтээгдэхүүний чанар
 - Нэр хүнд
 - Хэрэглэгчийн тоо
 - Байршил
 - Үнэ
 - Борлуулалтын суваг
 - Давуу тал
 - Сул тал

МАРКЕТИНГ ГЭЖ ЮУ ВЭ?

Байгууллага болон хувь хүн өмнөө тавьсан **зорилтоо шийдэхийн** тулд сонгож авсан **зах зээл** дээрээ үйлчлүүлэгчдийн **хэрэгцээг** хангахуйц **бараа, үйлчилгээ, санааг** төлөвлөж, түүндээ **зохистой үнэ** тогтоон **оновчтой сувгаар** хуваарилах үйл ажиллагааны нэгдмэл цогц юм.

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АМЬДРАЛЫН МӨЧЛӨГ

- **ЗАХ ЗЭЭЛД НЭВТРЭЛТИЙН ҮЕ**
- **ӨСӨЛТИЙН ҮЕ**
- **ТОГТВОРЖИЛТИЙН ҮЕ**
- **БУУРАЛТЫН ҮЕ**

МАРКЕТИНГ БА БОРЛУУЛАЛТ

БОРЛУУЛАЛТЫН ЧИГ БАРИМЖАА

Эхлээд бүтээгдэхүүнээ үйлдвэрлээд дараа нь төрөл бүрийн аргаар хэрэглэгчид зарахыг хичээдэг аргад тулгуурладаг.

ЗАХ ЗЭЭЛИЙН ЧИГ БАРИМЖАА

Эхлээд үйлчлүүлэгчдийн хэрэгцээг судлаад дараа нь түүндээ үндэслэн үйлдвэрлэл, үйл ажиллагаагаа түүнийг хангахад чиглүүлэх аргад тулгуурладаг.

ЗАХ ЗЭЭЛТЭЙ ХОЛБОГДСОН СТРАТЕГИ

- Зах зээлд нэвтрэх -Одоо байгааг одоогийн үнээр борлуулах
- Зах зээлийг хөгжүүлэх -Одоо байгааг шинэ зах зээлд борлуулах
- Шинэ бүтээгдэхүүн-Одоогийн зах зээлд шинийг гаргах
- Шинэлэг бүтээгдэхүүн-Одоогийнхийг өөрчлөн сайжруулж борлуулах
- Өрсөлдөгчийг давах-бага өртөг, орон зай эзлэх, бүтээгдэхүүний онцгой шинжийг гаргаж тавих

МАРКЕТИНГИЙН ХОЛЬЦ

- | | |
|----------------|---------------------|
| • Бүтээгдэхүүн | -Хэрэгцээтэй байх |
| • Үнэ | -Боломжийн байх |
| • Идэвхжүүлэлт | -Зөв танилцуулагдах |
| • Хуваарилалт | -Зөв суваг сонгох |

ҮНИЙН БОДЛОГО

Бүтээгдэхүүний хэмжээ, чанарт тохирсон төлбөрийн хэмжээг үнэ гэдэг.

- | | |
|--|--|
| ҮНИЙН ЗОРИЛТ <ul style="list-style-type: none"> • Худалдаа, үйлчилгээгээ өргөтгөх • Ашиг, орлогоо нэмэгдүүлэх • Үнийг тогтвортой байлгах • Өрсөлдөөнд зохицох | <ul style="list-style-type: none"> • Өртөг-нашиг =үнэ зарчим • Өрсөлдөөнд үндэслэх • Нэмэгдэлд үндэслэх • Эрэлт нийлүүлэлтэд үндэслэх • Хаалттай худалдааг үндэслэн тогтоох |
|--|--|

БҮТЭЭГДЭХҮҮН

- БАРАА
- ҮЙЛЧИЛГЭЭ
- ТЕХНОЛОГ
- ШИНЭ САНАА

ЗАХ ЗЭЭЛИЙН СЕГМЕНТ

- | | |
|---|---|
| <p>Худалдан авагч, хэрэглэгчийн ялгаатай байдал, байршилд тохируулан зорилтот зах зээл сонгон олж тэнд бизнес эрхлэх ажиллагааг зах зээлийг хэсэгчлэн хуваах буюу сегментчлэх гэнэ.</p> | ТОДОРХОЙЛОХ ЗАРЧМУУД <ul style="list-style-type: none"> • Хүн ам зүйн зарчим • Газар зүйн нөхцөл • Цаг уурын нөхцөл • Сэтгэл зүйн зарчим • Худалдан авагчийн төлөв байдлын шинж |
|---|---|

ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭР

Аливаа бизнес үйл ажиллагааг санасан хэмжээндээ хэрэгжүүлэхэд тодорхой хэмжээний хөрөнгийн эх үүсвэр зайлшгүй шаардлагатай болдог.

ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ДАРААХ БАЙДЛААР БҮРДҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ

- Өөрийн хөрөнгийг шавхан даячлах
- Гадны хөрөнгө ашиглах (Банк болон бусад иргэн, төсөл зэрэг газраас зээл, санхүүгийн дэмжлэг тусламж авах)

Хүнсний зарим зүйл зохистой хэрэглээ /нэг хүн-нэг жил/

• Мах, махан бүтээгдэхүүн	90 кг
• Сүү, сүүн бүтээгдэхүүн	111.6 кг
• Гурилан бүтээгдэхүүн	110.4 кг
• Цөцгийн тос	8.4 кг
• Буддаа	13.4 кг
• Сахар, чихэр	39.6 кг
• Төмс, хүнсний ногоо	99.6 кг
• Жимс, жимсгэнэ	10.8 кг

БИЗНЕС БОЛ ӨРСӨЛДӨӨН өрсөлдөгчөө ялахын тулд

БУСДААС ЯЛГАРАХ

- Хэрэглэгчдэд ижил үнэтэй боловч илүү чанарлаг бараа үйлчилгээ санал болгох

эсвэл

- Харьцангуй үнэтэй боловч чанараар хавьгүй илүү бараа, үйлчилгээ санал болгох

БАГА ЗАРДЛААР ҮЙЛДВЭРЛЭХ

- Ижил үнэтэй ижил бараа санал болгох

эсвэл

- Ижил бараа, үйлчилгээг бага үнээр санал болгох

МАРКЕТИНГИЙН ҮЕ ШАТ

• ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮЕ ШАТ

- 1-дүн шинжилгээ
- 2-зорилго тодорхойлох
- 3-орлого үр дүн тооцож төлөвлөх
- ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЕ ШАТ
- ХЯНАЛТЫН ҮЕ ШАТ

ХҮН АМЫН ЖИШМЭЛ ТОО коэффициент-0.9

• 0-1 нас	0.30	• Оюуны хөдөлмөр эрхлэгч	1.0
• 1-3 нас	0.57	• Хөнгөн ажил эрхэлдэг хүн	1.03
• 4-7 нас	0.68	• Хагас механикжсан ажил эрхлэгч	1.27
• 8-11 нас	0.79	• Хүнд ажил эрхэлдэг хүн	1.48
• 12-14 нас	0.96		
• 15-18 нас	1.10		

СУРГАЛТАНД АНХААРАЛ ТАВЬЖ ОРОЛЦСОНД БАЯРЛАЛАА

ТА БҮХНИЙ БИЗНЕСТ ӨНДӨР АМЖИЛТ ХҮСЬЕ !

Судалгааны ажлын хүрээнд явуулсан бүлгийн хэлэлцүүлэг.

Баянхонгор аймаг

Дээрхи 3 сумын бүлгийн ба бүлгийн бус малчид, сумын удирдах ажилтан, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг хамруулан тухайн орон нутагт үйлдвэрлэж байсан болон үйлдвэрлэж болох уламжлалт бус бүтээгдэхүүний зах зээлийг тодруулах зорилгоор сум тус бүрд 4-6 цагийн хэлэлцүүлэг хийсэн. Энэ хэлэлцүүлгийн үр дүнд тухайн орон нутгаас Улаанбаатар болон төвлөрсөн зах зээл, аймаг, сумын төвшинд борлуулж болох бүтээгдэхүүний нэр төрөл хэмжээг тодруулсан. Мөн тухайн орон нутгийн мал аж ахуйн болон газар тариалангийн бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийн ерөнхий чиг хандлагыг тодорхойлж, тухайн нутгийн хамгийн алдартай болон их хэмжээгээр нийлүүлж чадах бүтээгдэхүүнийг тодруулсан. Малчдын бүлгийн цаашдын чиг хандлагыг тодорхойлсон. Тухайлбал, хоршоо юу эсвэл, ТББ байх уу?. Мөн тухайн орон нутагт байгаа байгалийн баялаг болон түүнийг ашиглаж болох эсэх тухай асуудлыг хөндсөн.

2.2 Өвөрхангай аймаг

Судалгааны ажлын нэгдсэн удирдамжийн дагуу уламжлалт бус шинэлэг бүтээгдэхүүний талаар бизнес санал гаргах, малчдын санаачилгыг тодруулахын тулд Өвөрхангай аймгийн Төгрөг, Сант, Хужирт сумдад бүлгийн хэлэлцүүлгийг тус бүр нэг удаа зохион байгуулав. Бүлгийн хэлэлцүүлгийг сумын удирдлагын оролцоотойгоор зохион байгуулсан болно. Бүлгийн хэлэлцүүлгийг оролцооны аргаар явуулж оролцогчдоор өөрсдөөр нь санал бодлыг илэрхийлүүлж бусадтай нь санал солилцуулах, оролцогч бүр санаа гаргах зарчмыг баримтлав. Хэлэлцүүлгийг үндсэн 2 үе шаттай явуулж, эхний шатанд тухайн суманд малчдын бүлэг, болон малчдаас ойрын хугацаанд үйлдвэрлэн ашиг, орлогоо нэмэгдүүлэх боломжтой бүтээгдэхүүний нэр төрлийн дэлгэрэнгүй жагсаалтыг гаргах, хоёр дахь шатанд дээрх жагсаалтанд дурдагдсан бүтээгдэхүүнүүдэд тодорхой шалгуураар үнэлгээ өгч ач холбогдлоор нь эрэмбэлэх замаар үйлдвэрлэх боломжтой 10 бүтээгдэхүүнийг сонгон тодорхойлох ажиллагааг хийсэн юм. Хоёр дахь шатанд харгалзан үзэх шалгуур үзүүлэлтэнд :

- зах зээлийн эрэлтийн байдал
- технологи эзэмшилт
- хөрөнгө оруулалтын боломж
- түүхий эдийн нөөцийн байдал
- үйлдвэрлэх байгууллагын чадамж

- мэргэжлийн ажиллах хүчний нөөц
- орон нутгийн зах зээлийн багтаамж зэргийг багтаасан болно.

